

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-47
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	48-115
<hr/>	
<i>1.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	48-109
<i>2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	109-115

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
05 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Анужин, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг .

Нэг.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, мөн газрын ахлах шинжээч А.Цолмон, шинжээч Ж.Нарантуяа, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын ахлах шинжээч Ж.Чойсүрэн, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн ахлах шинжээч Д.Адилбиш, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Монгол Улсын Консерваторын сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал Ш.Ариунаа, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт,” гэснийг “зорилго, зарчим, тогтолцоо” гэж, “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль болон түүнтэй” гэснийг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай, Дээд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “нэр томьёо” гэснийг “нэр томьёоны тодорхойлолт” гэж, мөн зүйлийн 3.1.1 дэх заалтын “12 жилийн сургалтын агуулгын түвшинг” гэснийг “бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “төлөвшилийг” гэснийг “төлөвшилийн цогцыг” гэж, 3.1.3 дахь заалтын “мэргэжлийн болон дээд гэсэн ангиллыг” гэснийг “мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг” гэж, 3.1.5 дахь заалтын “танхимын бус хэлбэрээр явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 3.1.6 дахь заалтын “олгох” гэснийг “эзэмших” гэж, 3.1.7 дахь заалтын “бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ, сонирхолдоо” гэснийг “хүний хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө” гэж, мөн заалтын “албан бус” гэснийг “албан болон албан бус” гэж, 3.1.8 дахь заалтын “хэрэгцээг ханган, тухайн түвшний” гэснийг “үр дүнг” гэж, 3.1.11 дэх заалтын “иргэнийг” гэснийг “хүнийг” гэж, 3.1.13 дахь заалтын “түүний үнэлгээ” гэснийг “зорилго, зорилт, үнэлгээ” гэж, мөн заалтын “багц” гэснийг “цогц” гэж, 3.1.15 дахь заалтын

“хандлагыг” гэснийг “хандлага, эрхэмлэх үнэт зүйлийг” гэж, 3.1.16 дахь заалтын “иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөшлийг” гэснийг “хүний эзэмшсэн чадвар, чадамжийг” гэж, “эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг” гэснийг “эрэмбэлсэн бүтцийг” гэж, 3.1.18 дахь заалтын “мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан явуулах” гэснийг “цахим технологи ашиглан зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 3.1.8 дахь заалтын “хөтөлбөрийн” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “элсэн” гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.10, 3.1.17, 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.9.“албан бус боловсрол” гэж иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.10.“амьдралын орчинд суралцахуй” гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.17.“хувьсах зардал” гэж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэг суралцагчид ногдох шууд болон шууд бус өртөгт суурилсан зардлын дундаж хэмжээг;

3.1.19.“цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.20-3.1.25 дахь заалт нэмэх:

“3.1.20.“боловсролын үнэлгээ” гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг;

3.1.21.“чанарын баталгаажуулалт” гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг;

3.1.22.“хөндлөнгийн үнэлгээ” гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг;

3.1.23.“магадлан итгэмжлэл” гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж буй эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

3.1.24.“эндаументын сан” гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;

3.1.25.“ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “шинжлэх ухаан, олон улсын” гэснийг “шинжлэх ухааны” гэж, 5.1.5 дахь заалтын “оролцоо” гэснийг “оролцоог хангасан” гэж, 5.1.7 дахь заалтын “үндэслэсэн” гэснийг “нийцсэн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.3 дахь заалтын “уялдаатай” гэсний дараа “; уян хатан” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.11 дэх заалт нэмэх.

“5.1.11.хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.1, 5.1.8, 5.1.9 дэх заалтыг төслөөс хасаж, 5.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.1.Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил, тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж, 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.6, 6.7 дахь хэсэг нэмэх:

“6.6.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.7.Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “албан бус” гэсний дараа “боловсрол” гэж нэмж, мөн 7.1 дэх хэсгийн “орчноос суралцах боловсролоос” гэснийг “орчинд суралцахуйгаас” гэж, 7.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “шаттай” гэснийг “түвшинтэй” гэж, 7.3 дахь хэсгийн “орчноос” гэснийг “орчинд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5, 8.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 8.3 дахь хэсгийн “дэмжигч болон явуулын багшийн, цахим” гэснийг “хувилбарт болон цахим, дадлага” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.7 дахь хэсэг нэмэх.

“8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь энэ хуулийн 8.1-д зааснаас гадна хосмог болон ажлын байрны сургалтын хэлбэртэй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “мэргэжлийг” гэснийг “мэргэжил болон чадамжийн түвшнийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Боловсролын” гэсний дараа “болон сургалтын” гэж, “олгох” гэсний өмнө “түүнийг хөтлөх,” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “ хувийн хэрэг” гэснийг “бүртгэл мэдээлэл” гэж, 9.6 дахь хэсгийн “боловсролын” гэснийг “боловсролын болон сургалтын” гэж, 9.7 дахь хэсгийн “болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс” гэснийг “эсхүл, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас” гэж, “сургалтын баримт бичгийг” гэснийг “суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж,” гэж, 9.8 дахь хэсгийн “шатлалын” гэснийг “түвшний” гэж, “олгохыг хориглоно” гэснийг “олгохгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.10 дахь хэсэг нэмэх.

“9.10.Боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтын “байгууллага” гэсний өмнө “сургалтын гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.12, 10.1.13, 10.1.14, 10.2.7, 10.2.8 дахь заалт нэмэх.

“10.1.1.эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;

10.1.12.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш, боломж нөхцөлөөр хангагдах;

10.1.13.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх;

10.1.14.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах.

10.2.7.ерөнхий боловсролыг заавал эзэмших;

10.2.8.бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар хандлагаа” гэснийг “чадамжаа” гэж, 10.1.6 дахь заалтын “төлөөллийн” гэснийг “өөрийн удирдлагын” гэж, 10.2.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилтэй холбоотой боловсролын байгууллага, багшаас тавьсан” гэснийг “багш, ажилтны” гэж, 10.2.4 дэх заалтын “багш, суралцагч, анги” гэснийг “багш, ажилтан, суралцагч,” гэж өөрчилж, мөн төслийн 10.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 10.2.1 дэх заалтын “хугацаанд нь бүрэн” гэснийг, 10.2.5 дахь заалтын “сургуулийн дотоод журам” гэснийг хасаж, мөн төслөөс 10.1.4, 10.1.10, 10.2.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад” гэж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “нэн шаардлагатай” гэснийг “эрэлттэй” гэж, “тэтгэлэг” гэснийг “хөнгөлөлт, тэтгэлэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “зардлын дундаж нормативт “ гэснийг хасаж, 11.3, 11.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Гадаад болон дотоодын мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.

11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “Хууль тогтоомжид” гэсний өмнө “Холбогдох” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.7 дахь хэсэг нэмэх.

“11.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.17-д заасны дагуу 24 дүгээр саналаар 3 хүртэл удаа санал хураалт явуулав.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.9.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системтэй байна.

12.12.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.9-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багшлах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 1 дэх удаа явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.9.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системтэй байна.

12.12.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.9-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багшлах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 2 дахь удаа явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.9.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системтэй байна.

12.12.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.9-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багшлах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 3 удаа дахь явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан, Эцэг, эх, суралцагчийн хүсэлтэд үндэслэн ажлын бус цагаар бүх шатны багш нь нэмэлт орлого олж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.11 дэх заалт нэмэх.

“13.1.11.цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцлөөр хангагдах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “албан тушаалын тодорхойлолтод” гэснийг “хууль тогтоомжид” гэж, “ажлын үр дүн, гүйцэтгэлд” гэснийг “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ” гэж, 13.2.7 дахь заалтын “эрхэмлэн, ажил амьдрал үйл ажиллагаагаараа үлгэрлэх” гэснийг “эрхэмлэх” гэж, 13.2.9 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийг” гэснийг “цахим технологи, хэрэглэгдэхүүнийг” гэж, мөн заалтын “платформыг” гэснийг “цахим системийг” гэж, 13.2.10 дахь заалтын “багшийн мэргэжлээ дээшлүүлэх” гэснийг “ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж” гэж, 13.2.3 дахь заалтын “мэдлэг, чадвар, дадлыг” гэснийг “чадамжийг” гэж, 13.2.11 дэх заалтын “цэцэрлэг, сургуулийн” гэснийг “сургалтын” гэж, 13.3.3, 13.3.5 дахь заалтын “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 13.3.4 дэх заалтын “дэмжлэг үзүүлэх” гэснийг “ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 3.3.5 дахь заалтын “сургуулийн захирал” гэснийг “ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал” гэж, 13.3.6 дахь заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “5” гэснийг “эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь” гэж, 13.5 дахь хэсгийн “бүх шатны” гэснийг “бүх түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2, 13.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.2.суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, “саад учруулах” гэсний өмнө “зориуд” гэж нэмж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9, 13.10, 13.11 дэх хэсэг нэмэх.

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

Мөн ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, 13.1.7, 13.2.13, 13.3.1, 13.3.2 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 13.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 13.2.3 дахь заалтын “суралцагчийг идэвхжүүлсэн сургалтын арга зүйг сургалтад ашиглах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 дэх заалтын “хэл зохиол” гэснийг ”монгол хэл, уран зохиол” гэж, 14.4.4 дэх хэсгийн “ёс зүйн” гэснийг “ёс зүйн болон зан төлөвийн” гэж, “14.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын” гэж, 14.3 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол болон” гэснийг “мэргэжлийн болон техникийн,” гэж, “нарийвчилсан харилцааг” гэснийг “харилцааг” гэж, 14.5, 14.9 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.4, 14.6, 14.7, 14.8 дахь хэсэг, 14.4.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.4.Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын сургалтын байгууллага хэрэгжүүлнэ:

14.4.6.хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;

14.6.Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, Монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно.

14.7.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Цахим сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 14.2-т заасан хөтөлбөрт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Боловсролын сургалтын байгууллага нь” гэж, 14.4.3 дахь заалтын “жендэрийн” гэсний өмнө “хүний эрхийн боловсрол,” гэж, 14.4.9 дэх заалтын “сэргийлэх” гэсний дараа “талаар” гэж, 14.9 дэх хэсгийн “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “албан боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмэх.

“15.3.Албан бус боловсролын сургалтыг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага бүртгэж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “багшийн” гэснийг “эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмэх.

“16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА” гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллага нь боловсрол судлалын ёс зүйн хороо, боловсролын сургалтын байгууллага, ажил олгогчийн түншлэл хамтын ажиллагааг хариуцсан төвтэй байна.

17.4.1.энэ хуулийн 17.4-д заасан ёс зүйн хороо орон тооны бус байх бөгөөд ажлын албатай байна. Ёс зүйн хорооны ажлын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

17.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг шалгах, турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.5.1.энэ хуулийн 17.4-д заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас тохирц, нийцлийг шалгах, турших үед сонгосон цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх;

17.6.Насан туршийн суралцахуйн төв нь хүний насан туршийн суралцахуйг чиглүүлэх, түгээн дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.6.1.энэ хуулийн 17.6-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах;

17.6.2.эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага, эсхүл төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэж болох бөгөөд шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

17.6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших, тасралтгүй сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллуулж болно.

17.6.4.Дэмжих төвийн хүний нөөц болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.6.5.энэ хуулийн 17.6-д заасан төв нь сургалт, үйлчилгээний хамрах чиглэлээс хамаарч салбар дундын санхүүжилттэй байх;

17.7.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.8.Энэ хуулийн 17.8-д заасан үнэлгээ болон элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.9.Боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага нь сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

17.10.Энэ хуулийн 17.9-д заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсын магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, дүйцүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

17.11.Энэ хуулийн 17.9-д заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 18.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.4.Боловсролын сургалтын байгууллага нь төрийн, орон нутгийн өмчийн, хувийн болон холимог өмчийн хэлбэртэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их,” гэж, 18.3, 18.5, 18.6 дахь хэсгийн “Боловсролын байгууллага” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “зорилгодоо” гэснийг “чиг үүрэгт” гэж өөрчилж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 18.3.1 дэх заалт, 18.8, 18.9 дэх хэсэг шинээр нэмэх.

“18.3.1.ашгийн төлөө, ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-т заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг эрх бүхий байгууллагаас баталсан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоод, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.” гэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах горимын санал гаргав.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Г.Дамдинням нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.17-д заасны дагуу 37 дугаар саналаар 3 хүртэл удаа санал хураалт явуулав.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их,” гэж, 18.3, 18.5, 18.6 дахь хэсгийн “Боловсролын байгууллага” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “зорилгодоо” гэснийг “чиг үүрэгт” гэж өөрчилж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 18.3.1 дэх заалт, 18.8, 18.9 дэх хэсэг шинээр нэмэх.

“18.3.1.ашгийн төлөө, ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-т заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг эрх бүхий байгууллагаас баталсан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоод, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 1 дэх удаа явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их,” гэж, 18.3, 18.5, 18.6 дахь хэсгийн “Боловсролын байгууллага” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “зорилгодоо” гэснийг “чиг үүрэгт” гэж өөрчилж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 18.3.1 дэх заалт, 18.8, 18.9 дэх хэсэг шинээр нэмэх.

“18.3.1.ашгийн төлөө, ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-т заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг эрх бүхий байгууллагаас баталсан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоод, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 2 дахь удаа явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их,” гэж, 18.3, 18.5, 18.6 дахь хэсгийн “Боловсролын байгууллага” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “зорилгодоо” гэснийг “чиг үүрэгт” гэж өөрчилж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 18.3.1 дэх заалт, 18.8, 18.9 дэх хэсэг шинээр нэмэх.

“18.3.1.ашгийн төлөө, ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-т заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг эрх бүхий байгууллагаас баталсан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоод, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг 3 дахь удаа явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан эхлэх цаг болсон тул хуралдаан 15 цаг 10 минутаас 15 цаг 36 минутад түр завсарлав.

Г.Мөнхцэцэг: 38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 16, 22 дугаар зүйлд заасан стандартын шаардлага хангасан хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнээр хангагдсан, зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавигдах шаардлагыг хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг эрх бүхий этгээд Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, “22 дугаар зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавигдах шаардлага

22.1.Зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

22.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгчдийн гэрээг үндэслэл, танилцуулгын хамт;

22.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, тэдгээрийн боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3.стандартын шаардлага хангасан, зориулалтын хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын бүтээгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заасан шаардлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд зориулан гаргасан хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа, боловсролын сургалтын байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7.сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байхыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байхыг нотолсон баримт бичиг;

22.1.8.цэрэг цагдаа, төмөр замын чиглэлээр мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт явуулах тохиолдолд холбогдох байгууллагын санал, дүгнэлт, ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг;

22.1.9.сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн дипломтой байх бөгөөд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй буюу зөрчил гаргаж байгаагүй талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10.татвар, нийгмийн даатгалын байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу гарсан алдагдалгүй, нөхөн төлбөргүй талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2.Энэ хуулийн 21.2-т заасан эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн байгууллага, бусад байгууллагад шилжүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан үндэслэлээр эрх хүлээн авагч нь тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

22.4.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

22.5.Боловсролын сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 21.1.3-21.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх сургалтын үндэслэл, танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.6.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа хүсэлт, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7.Тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжил нээх хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ хуулийн 21.2-т заасан хугацаа харгалзахгүй хүлээн авч шийдвэрлэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, “23 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1.Эрх бүхий этгээдээс олгох ерөнхий боловсролын сургууль байгуулахад олгох зөвшөөрлийн хугацаа 12 жил байх бөгөөд сургуулийн өмнөх болон дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд олгох зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн хугацаанаас доошгүй байна.

23.2.Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3.Энэ хуулийн 21.1.19-д заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах үндэслэл болно.

24 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

24.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

24.1.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон;

24.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

24.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

24.3.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг Иргэний хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

24.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахад суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр тухайн хичээлийн жилтэй уялдуулж үүсгэн байгуулагч шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.3 дахь хэсгийг төслөөс хасах.

“27.1.Боловсролын удирдлага нь Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.4, 27.5, 27.6 дахь хэсэг нэмэх.

“27.4.Боловсролын үндэсний зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд мэргэжлийн зөвлөлтэй байна. Үндэсний зөвлөл нь ажлын албатай байх бөгөөд ажлын албаны даргын чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ.

27.5.Энэ хуулийн 27.4-т заасан Боловсролын үндэсний зөвлөл нь боловсролын бодлого, хэрэгжилт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж чиглэл гаргах, боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа, судалгаа шинжилгээнд дэмжлэг үзүүлэх болон багш, судлаач, эрдэмтэн, төрийн бус байгууллага, ажил олгогчийг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоо тэдгээрийн хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

27.6.Энэ хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Мэргэжлийн зөвлөлд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг энэ хуулийн 27.4 дэх хэсэгт заасан ажлын алба хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтын “боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн” гэснийг “энэ хуулийн 17.2, 17.7-д заасан” гэж, 28.1.4 дэх заалтын “батлах” гэснийг “баталж, хэмжээг тогтоох” гэж, 28.1.7 дахь заалтын “мэргэжлийн болон дээд боловсролын” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын” гэж, 28.1.9 дэх заалтын “болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол” гэснийг “, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “хувьсах зардлын дундаж норматив зардал” гэснийг, “суурь, хувьсах зардлын дундаж норматив зардал” гэснийг тус тус “хувьсах зардал” гэж, 28.1.10 дахь заалтын “хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг” гэснийг “хувьсах зардлын хэмжээг 2 жил тутамд шинэчлэн” гэж өөрчилж, 28.1.16 дахь заалтын

“дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “, буцалтгүй тусламж олгох” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.1.19, 28.1.20 дахь заалт нэмэх.

“28.1.19.боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг батлах;

28.1.20.энэ хуулийн 12.6, 12.8-д заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх журмыг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, 28.1.3, 28.1.8, 28.1.12 дахь заалтыг төслөөс хасаж, 28.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.1.14.боловсролын үндэсний зөвлөл байгуулах, бүрэлдэхүүн, дүрмийг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна” гэж нэмж, 29.1.3 заалтын “боловсролын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, 29.1.8 дахь заалтын “нэн шаардлагатай мэргэжлийн” гэснийг “мэргэжлийг тодорхойлох аргачлал,” гэж, 29.1.9 дэх заалтын “ажлыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчилж, 29.1.1, 29.1.2, 29.1.4, 29.1.5, 29.1.6 дахь заалт, 29.2 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.4, 30.1.5, 30.1.11, 30.1.16, 30.1.17, 30.1.19, 30.1.21 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 30.1.1, 30.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 106.3-т заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативыг батлах;

30.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын “ерөнхий боловсролын сургууль” гэсний дараа “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн” гэж, 30.1.10 дахь заалтын “мэргэжлийн болон” гэсний дараа “техникийн,” гэж, 30.1.15 дахь заалтын “сургалт зохион байгуулах” гэсний дараа “, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх” гэж, 30.1.18 дахь заалтын “бэлэн байдлыг хангах,” гэсний дараа “гамшгийн нөхцөл байдлыг харгалзан хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаанд” гэж, 30.1.20 дахь заалтын “боловсролын хэлтсийн” гэсний дараа “, насан туршийн суралцахуйн төвийн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 30.1.25-30.1.35 дахь заалтыг шинээр нэмэх.”

“30.1.25.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоог энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн тогтоох;

30.1.26.Төрийн албаны тухай хуулийн 57.14-д заасан төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн доод хэмжээг салбарын онцлог, гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлэх асуудлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх;

30.1.27.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;

30.1.28.аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог тухайн нутаг дэвсгэрийн суралцагчийн тоо, төвөөс алслагдмал байдлыг үндэслэн батлах;

30.1.29.боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

30.1.30.боловсролын сургалтын байгууллагад олгох зөвшөөрлийн гэрчилгээний загварыг батлах;

30.1.31.мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлтийн журам, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах;

30.1.32.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалт, аргачлалыг хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

30.1.33.боловсролын чанарын баталгаажуулалтын журам, аргачлал батлах;

30.1.34.боловсролын салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбоотой санал боловсруулах, салбарын холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

30.1.35.энэ хуулийн 17.6.3-т заасан төвийн бүтэц, орон тоо, үлгэрчилсэн дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр,

нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.8 дахь заалтын “сургалтын хэрэглэгдэхүүнд” гэснийг “сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд” гэж, 30.1.9 дэх заалтын “боловсролын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер” гэснийг “цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер,” гэж, мөн зүйлийн 30.1.12 дахь заалтын “дээд боловсролын байгууллага” гэснийг “мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага” гэж, 30.1.13 дахь заалтын “боловсролын эрдэм шинжилгээ, үнэлгээ, арга зүйн байгууллагын бүтэц, орон тоо” гэснийг “энэ хуулийн 17.2, 17.6, 17.7-д заасан байгууллагын бүтэц” гэж, 30.1.14 дэх заалтын “боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн” гэснийг “энэ хуулийн 17.2, 17.7, 17.9-д заасан” гэж, 30.1.22 дахь заалтын “багш бэлтгэх их, дээд сургуулийн суралцагчаас улсын нэгдсэн болон багшлах эрхийн шалгалт авах” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох бусад үйл ажиллагааны” гэж өөрчилж, 30.1.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.23.боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.5, 31.1.6, 31.1.9, 31.1.10, 31.1.12, 31.1.13 дахь заалтыг төслөөс хасаж, 31.1.2 дахь заалтын “сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж” гэснийг “сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл,” гэж өөрчилж, мөн зүйлийн 31.1 дэх хэсгийн “төрийн захиргааны байгууллага нь” гэсний дараа “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлийн 31.1.8 дахь заалтын “олимпиад” гэсний дараа “, мэргэжлийн болон техникийн боловсролын ур чадварын уралдаан” гэж, 31.1.11 дэх заалтын “тайланг” гэсний дараа “, статистикийг” гэж, “хуульд” гэсний өмнө “холбогдох” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.1.16-31.1.20 дахь заалт нэмэх.

“31.1.16.гадаад улсад насан туршийн суралцахуйн төвд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг батлах;

31.1.17.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт батлах;

31.1.18.аймаг, нийслэлийн насан туршийн суралцахуйн төвийн захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

31.1.19.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд ашиглах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагыг батлах;

31.1.20.Сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн нэрийг **“Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс”** гэснийг **“Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага”** гэж цаашид тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх.

“33.1.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын “тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг” гэснийг “хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт, 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг төслөөс хасаж, 33.1.5, 33.5.1, 33.6.1 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.5.1, 33.6.1 дэх хэсгийн “удирдах” гэсний дараа “эсхүл, нийгмийн” гэж нэмж, мөн зүйлийн 33.5.1 дэх заалтын “ажилласан” гэсний дараа “, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар, 33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмэх.

“Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-г заасан “Сургуулийн орчин” гэдэгт бүх түвшний боловсролын сургалтын байгууллагыг хамааруулна.”

“33.1.19.зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;”

“33.7.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нь сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.8.Нийслэлийн боловсролын газрын дарга нь дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтаар үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

82.3 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэснийг “хяналт-шинжилгээ” гэж, 33.1.12 дахь заалтын “боловсролын байгууллагын орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” гэснийг “сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан” гэж, 33.1.13, 33.1.15 дахь заалтын “орон нутгийн боловсролын” гэснийг “орон нутгийн өмчийн боловсролын сургалтын” гэж, 33.1.16 дахь заалтын “боловсролын байгууллагатай” гэснийг “суралцахуйн төвтэй” гэж, 33.5.2 дахь заалтын “үнэлгээний” гэснийг “үнэлгээ, нийгмийн ажил, сэтгэл зүйн” гэж, 33.6.1 дэх заалтын “10” гэснийг “9” гэж, “3-аас” гэснийг “4-өөс” гэж өөрчилж, 33.1.3, 33.1.8, 33.1.11, 33.6.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.1.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;

33.1.8.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, зөвлөн туслах;

33.1.11.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохируулгат орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

33.6.2.энэ хуулийн 33.5.2-д заасан шаардлагыг хангасан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан, Төсөлд “33.5.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан, Төсөлд “33.6.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, 34.1.2 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 34.1 дэх хэсгийн “тухайн” гэснийг “харьяа” гэж, 34.1.3 дахь заалтын “боловсролыг” гэснийг “боловсролын сургалтын байгууллагыг” гэж, 34.1.4 дэх заалтын “тусгайлан батлах” гэснийг “батлах” гэж, 34.1.7 дахь заалтын “орчинд тавих шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд байлгаж” гэснийг “орчны стандартад нийцсэн талбайн хэмжээний дагуу газрын нөөцөд авч” гэж өөрчилж, мөн зүйлийн 34.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.5.насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “харьяа нутаг дэвсгэртээ” гэсний дараа “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна” гэж, 35.1.4, 35.1.9, 35.1.10, 35.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 35.1.12 дахь заалтын “сургуулиасаа хол амьдардаг” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн” гэж өөрчилж, 35.1.4 дэх заалтын “зохион байгуулах” гэсний дараа “, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 35.1.16, 35.1.17 дахь заалт нэмэх.

“35.1.16.орон нутаг дахь насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны болон тогтмол зардлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах.”

35.1.17.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр байгуулах, өөрчлөх байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн” гэснийг, мөн зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.5, 35.1.13, 35.1.14 дэх заалтыг төслөөс хасаж, 35.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4, 36.1.6 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 36.1.8 дахь заалтын “байгууллагын” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 36.1.1, 36.1.2, 36.1.4, 36.1.7, 36.1.9, 36.1.10 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 36.1.9, 36.1.10, 36.1.11 дэх заалт нэмэх.

“36.1.9.насан туршдаа суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;

36.1.10.сум, дүүргийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

36.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар 37.1.3, 37.1.4, 37.1.5 дахь заалтыг төслөөс хасаж, 37.1.2 дахь заалтын “сургалтад хамруулах арга хэмжээ авах” гэснийг “сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 37.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.1.1.тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.1.7 дахь заалт нэмэх:

“37.1.7.баг, хорооны боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2

Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг төслөөс хасаж, 38.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж,” гэж, 38.2 дахь хэсгийн “нийтлэг” гэснийг “тусгай” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийн “ректор” гэсний өмнө “проректор,” гэж, 38.2 дахь хэсгийн “боловсролын” гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад” гэж, 38.1 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 38.2, 38.3 дахь хэсэг, 38.2.2, 38.3.1, 38.3.2, 38.3.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 38.2.2 дахь заалтын “сургалтын менежер” гэсний дараа “, нийгмийн ажилтан” гэж нэмж, 38.3.3 дахь заалтын “хяналт тавих” гэснийг “тасралтгүй хөгжлийг хангах, үнэлэх, дэмжлэг үзүүлэх” гэж, 38.3.6 дахь заалтын “платформ” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.4, 38.5 дахь хэсэг нэмэх.

“38.4.Энэ хуулийн 33.5, 33.6-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага, 38.2-т заасан албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг хангаагүй иргэнийг томилохыг хориглох.

38.5.Энэ хуулийн 38.2.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 29, 33 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд холбогдох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 39.6 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 39.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж,” гэж, 39.2 дахь хэсгийн “сургуулийн болон цэцэрлэгийн” гэснийг “сургууль, цэцэрлэгийн” гэж, 39.3 дахь хэсгийн “Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “Цэрэг, цагдаагийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40 дүгээр зүйл.Боловсролын хяналт шалгалт, чанарын үнэлгээ

40.1.Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

40.2.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагч нь боловсролын болон холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавина.

40.3.Боловсролын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу энэ хуулийн 17.7-д заасан байгууллага суралцагч, эцэг эх, иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчийн төлөөллийг оролцуулан зохион байгуулна.

40.4.Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийг хөндлөнгөөс үнэлнэ.

40.5.Боловсролын үнэлгээг цахимаар зохион байгуулж болох ба суралцагчийн ахиц дэвшилд дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах үндэсний цахим системтэй байна.

40.6.Боловсролын чанарыг 3 жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ.

40.7.Боловсролын сургалтын байгууллага дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

40.8.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 40.7-д заасан чанарын баталгаажуулалтын үр дүнд үндэслэж, чанарын сайжруулалтын төлөвлөгөө батлан, хэрэгжүүлнэ.

40.9.Энэ хуулийн 40.8-д заасан төлөвлөгөө нь гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний хэсэг байх бөгөөд түүний ажлын үр дүнг хэмжих үзүүлэлт нь чанарын ахиц дэвшил байна.

40.10.Төрийн өмчийн бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадаад улсын хөтөлбөрийг магадлан итгэмжилнэ.

40.11.Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын магадлан итгэмжлэлийг холбогдох хуулиар зохицуулна.

40.12.Сургалтын хөтөлбөрийг гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжилж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ТАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийн “ЭДИЙН ЗАСАГ” гэснийг хасаж, 42.5 дахь хэсэг, 42.5.2, 42.5.3, 42.5.4, 42.5.5 дахь заалт, 42.7 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 42.5.5 дахь заалтын “шууд” гэсний дараа “өртөгт суурилсан” гэж, 42.5.2 дахь заалтын “эрдэм шинжилгээний” гэснийг “эндаументын сан болон эрдэм шинжилгээ, инновацын” гэж, 42.5.4 дэх заалтын “нэг суралцагчид ногдох сургалтын шууд зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хэсэг” гэснийг “хувьсах зардал” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 41.4, 42.9 дэх хэсэг нэмэх.

“41.4.Энэ хуулийн 41.1-41.3-т заасан этгээд боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалт болон нөөцийг хуваарилах, сургалтын байгууллага байгуулах, бүтэц, хамран сургах тойрог тогтооход хүн амын нягтаршил, суурьшил, дэд бүтэц, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулсан газарзүйн мэдээллийн системд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

42.9.Боловсролын сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг боловсролын болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42.4 дэх хэсгийн “Боловсролын байгууллага нь” гэснийг “Боловсролын санхүүжилт нь” гэж, “санхүүжнэ” гэснийг “бүрдэнэ” гэж, 42.5.3 дахь заалтын “цэрэг, цагдаа, аюулгүй байдлын дээд” гэснийг “цэрэг, цагдаагийн дээд болон мэргэжлийн” гэж, 42.5.5 дахь заалтын “суурьшлын ялгаанаас үүсэж буй боловсролын ялгааг багасгах Засгийн газрын бодлого, эцэг эх асран хамгаалагчийн амьдралын түвшинтэй” гэснийг “байршил, сургалтын төлбөрийн хэмжээтэй” гэж, мөн заалтын “хүсэлтийн дагуу эрэлтэд суурилсан хэлбэрээр” гэснийг “тоогоор” гэж, 42.6 дахь хэсгийн “Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн” гэснийг “Энэ хуулийн 17.2-т заасан” гэж, 42.7 дахь хэсгийн “аж ахуйн үйл ажиллагаа явуулж” гэснийг “сургалтын орчин, үйл ажиллагааг дэмжсэн туслах аж ахуйтай байж” гэж өөрчилж, 42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.8.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 42.4, 42.7-д заасан өөрийн орлого бүрдүүлсэн нь төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, 42.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 42.5.1 дэх заалтын “хуульд заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах зардлыг санхүүжүүлэх” гэснийг “холбогдох хуулиар зөвшөөрсөн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн гарчиг, 43.1.3 дахь заалт, 43.3 дахь хэсэг, 43.4.8 дахь заалт, 42.8 дахь хэсэг, 43.10 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4 дэх хэсэг нэмэх.

“43.4.Энэ хуулийн 43.1.2, 43.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “сургуулийн” гэснийг “сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн” гэж, “улсын” гэснийг “улсын болон орон нутгийн” гэж, мөн зүйлийн 43.1.1 дэх заалтын “ашиглалтын буюу суурь” гэснийг “байр ашиглалтын болон тогтмол” гэж, 43.1.3 дахь заалтын “гүйцэтгэл” гэснийг “болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар” гэж, 43.1.4 дэх заалтын “үдийн цай, хоол болон бусад нэмэлт зорилтот хөтөлбөрийг” гэснийг “үдийн хоол болон бусад арга хэмжээг” гэж, 43.1.5 дахь заалтын “багш нарын мэргэжил дээшлүүлэх” гэснийг “багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих” гэж, 43.3 дахь хэсгийн “үндэслэнэ” гэснийг “үндэслэх бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж, 43.4.3 дахь заалтын “байгууллагын” гэснийг “сургууль, политехник коллеж” гэж, мөн хэсгийн “суурь” гэснийг “тогтмол” гэж, 43.4.6 дахь заалтын “зардлын тодорхой хэсэг” гэснийг “зардал” гэж, 43.7 дахь хэсгийн “олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн” гэснийг “олон улсын түвшний” гэж өөрчилж, 43.1.2 дахь заалтын “шууд зардлын дундаж нормативт үндэслэн тооцох” гэснийг хасаж, мөн заалтын “төлөвлөгөө” гэсний дараа “нэмэлт хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, сургалтын цахим хэрэглээ, сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал,” гэж, 43.4.5 дахь заалтын “хэсэг” гэсний дараа “, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоолны зардал” гэж нэмэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, энэ хэсэгт доор дурдсан тайлбар нэмэх.

“43.2.Хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн боловсролын ялгаатай хэрэгцээтэй уялдуулан суралцах тэгш боломжийг хангах зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

Тайлбар. Шууд өртөгт суурилсан зардалд сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн, хичээл сургалтын үйл ажиллагааны зардал, багш, ажилтны цалин хөлс, түүнд ногдох нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал багтана.

Шууд бус өртөгт суурилсан зардалд багшийн мэргэжлийн хөгжил, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, цахим сургалтын программ хангамж, интернэтийн үйлчилгээ, сургалтын удирдлагын мэдээллийн систем, цахим контентын хэрэглээ, программ хангамжийн ашиглалтын зардал, сургалтад шаардагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, дотуур байрын нийт зардал багтана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.2 дахь заалтын “сургууль” гэсний дараа “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж” гэж нэмж, мөн заалтын “ажлын үр дүнгийн үнэлгээнд суурилсан нэмэлт зардал” гэснийг “гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан санхүүжилт” гэж, 43.4.3 дахь заалтын “байгууллагын” гэснийг “сургууль, политехник коллежийн” гэж, “хувьсах зардлын дунгаж норматив” гэснийг “хувьсах зардал” гэж, “суурь” гэснийг “тогтмол” гэж өөрчилж, 43.4.1, 43.4.4, 43.4.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ноогдох хувьсах зардал;

43.4.4.цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоол, сургуулийн суралцагчийн дотуур байрны хоолны зардал;

43.4.7.төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, анхны өртгийг харгалзан нэг хүүхдэд тухайн жилд ногдох элэгдлийн зардлыг тооцсон дундаж норматив зардлаар санхүүжүүлэх тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, ашиглалтын зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

73.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4.9, 43.4.10, 43.4.11, 43.4.12, 43.4.13, 43.4.14 дэх заалт, 43.11 дэх хэсэг нэмж, мөн зүйлийн 43.6, 43.9 дэх хэсгийг төслөөс хасах.

“43.4.9.цэцэрлэгийн хүчин чадал, бүлэг дүүргэлтээс шалтгаалан үндсэн сургалтад хамрагдаагүй хоёр настай хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших хувилбарт сургалтын хэлбэрээс сонгосон тохиолдолд олгох гүйцэтгэлд суурилсан хувьсах зардал;

43.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшийн мэргэжлийг дээшлүүлэх зардал;

43.4.11.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, наадгай, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн баяжилт.

43.4.12.үндэсний хэмжээнд нэвтрүүлэх суралцагч бүрийн сурлагын ахиц, үр дүнг илэрхийлэх цахим систем нэвтрүүлэлт, хөгжүүлэлт, ашиглалт, аюулгүй байдлыг хангах зардал.

43.4.13.энэ хуулийн 17.6.1-17.6.3-т заасан үйлчилгээ болон албан бус сургалтын зардлын тодорхой хэсэг.

43.4.14.урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн тусгайлан тодорхойлсон захиалгат хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэл, үр дүнд суурилсан сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний зардлын тодорхой хэсэг;”

43.11.Энэ хуулийн 43.1.2, 43.4.1-т заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд олгохдоо гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

74.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44.1, 44.3, 44.4, 44.5, 44.8, 44.9 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 44 дүгээр зүйлийн гарчгийн “Боловсролын байгууллагын орчин” гэснийг “Боловсролын сургалтын байгууллагын орчин” гэж, 44.7 дахь хэсгийн “нөөцийн газрыг” гэснийг “газрыг” гэж, 44.6 дахь хэсэг, 44.10.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.6.Энэ хуулийн 44.5-д заасан эзэмшил газар болон боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглана.

44.10.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн гэрээгээр 2 ба түүнээс дээш жилийн хугацаатай эзэмших, ашиглах, худалдан авах зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

75.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.10.2, 44.10.3 дахь заалтыг нэмэх.

“44.10.2.бүх түвшний боловсрол сургалтын байгууллагын цахим сургалтын орчныг бүрдүүлэх тоног төхөөрөмж, хатуу болон зөөлөн дэд бүтцийн сүлжээ ашиглалт, түүнтэй холбогдох засвар үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан түрээсийн болон лизингийн гэрээний үндсэн дээр ашиглах, эзэмших, худалдан авах зардал;

44.10.3.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж багатай, нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан сургалтын зориулалтаар барьсан барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

76.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн гарчиг болон 45.1, 45.2 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэснийг “асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж, 45.2.9 дэх заалтын “асран хамгаалагчийн” гэснийг “асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн” гэж, 45.2.10 дахь заалтын “43.5.5” гэснийг “43.4.5” гэж, 45.2.3 дахь заалтын “ариун цэврийн” гэснийг “сургалтын болон эрүүл ахуйн” гэж, 45.2.6 дахь заалтын “сургууль, багшаас” гэснийг “сургуулиас” гэж өөрчилж, 45.1.1, 45.1.4 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 45.2.1 дэх заалтын “хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь илрүүлэн, дэмжин хөгжүүлэх, эерэгээр хүмүүжүүлэх,” гэснийг, 45.2.7 дахь заалтын “багшийг өөрийг нь болон” гэснийг, 45.2.10 дахь заалтын “43.5.6” гэснийг, 45.2.4 дэх заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

77.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45.1.3, 45.1.5 дахь заалт, 45.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн болон энэ хуулийн 39.2-т заасан сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох;

45.1.5.сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан боловсролын болон сургалтын баримт бичигтэй танилцах;

45.3.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь боловсролын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд гэрээний загварыг энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

78.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.2, 46.1.3, 46.1.5 дахь заалтыг төслөөс хасаж, 46.1.1, 46.1.4 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын гэж нэмж, 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.2.1.гэрээний дагуу суралцагчийг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, бололцоогоор хангах, дагалдангаар ажиллуулах;

46.2.2.байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;

46.2.3.энэ хуулийн 46.2.2-т заасан сургалт зохион байгуулах зардлыг хариуцах;

46.2.4.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

79.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 47.2.5 дахь заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

80.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 42.2.9, 42.7.10 дахь заалт нэмэх.

“47.2.9.багш ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээг авах талаар зөвлөмж хүргүүлэх;

47.2.10.гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг төрийн бус өмчийн сургалтын байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

81.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ДОЛООДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, САН” гэж, 48 дугаар зүйлийн гарчгийг “Боловсролын цахим мэдээллийн сан, дэд бүтэц” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

82.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн “Монгол Улс иргэдийн” гэснийг “Иргэдийн” гэж, 48.6, 48.8 дахь хэсгийн “нэгдсэн сангийн” гэснийг “сангийн” гэж, 48.9 дэх хэсгийн “нэгдсэн сан” гэснийг “сан” гэж, 48.6 дахь хэсгийн “төрийн” гэснийг “боловсролын” гэж, 48.9 дэх хэсгийн “ажиллах” гэснийг “ажиллуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 48.4, 48.5, 48.10 дахь хэсгийг төслөөс хасаж, 48.1, 48.3, 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.1.Боловсролын салбарт боловсролын цахим мэдээллийн сантай байх бөгөөд тус сан нь төрийн мэдэлд байна.

48.3.Боловсролын цахим мэдээллийн сан нь бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн болон төсвийн мэдээллээс бүрдэнэ.

48.7.Боловсролын цахим мэдээллийн нөөц сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

83.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

84.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчилж, мөн зүйлийн 51.2 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

85.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэн тул хуулийн төсөлд тусгагдсан тодорхой зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацаа, нөхцөл, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах асуудлыг зохицуулах зорилготой дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

86.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

87.Ажлын хэсгийн гаргасан, Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

88.Ажлын хэсгийн гаргасан, Багшийн хөгжлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням татаж авав.

89.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн холбогдох зохицуулалттай холбогдуулан хариуцлага ногдуулах асуудлаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

90.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13.3 дахь заалтын “цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Боловсролын тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Дээд боловсролын тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

7.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9.Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

10.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

11.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

13.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

14.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

15.Монгол Улсын батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

16.Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

17.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

18.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

19.Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

20.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

21.Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг нь хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

22.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

23.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

24.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Батцэцэг, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Б.Даваацэрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Ууганбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Соёлын сайд Ч.Номин танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Соёлын сайд Ч.Номин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан үг хэлэв.

Г.Мөнхцэцэг: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 32 минут үргэлжилж, 16 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 81.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 50 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Мөнхцэцэг: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. БСШУС-ын Байнгын хорооны 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье. Байнгын хороонд хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулъя. 1.Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Анхны хэлэлцүүлэг явуулна. 2-т нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газраас 2023 оны 4 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийг орж иртэл ажлын хэсгийн гишүүний танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч,

Улсын Их Хурлын гишүүн Дамдинням танилцуулах юм байна. Дамдинням гишүүн танилцуулгаа хийе. Энэ дээр нэг бас нэг тайлбар хэлчихье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хорооны хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж ингэж заасан байгаа.

39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууна асууж болно гэсэн ийм тайлбар байна. Энэ тайлбарыг бас уншиж танилцуулж байна. Монгол Улс мөн бас нэгэн тайлбар байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1.2.-т гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух нь нэг минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалттай гэж гишүүн үзвэл нэг минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж тайлбар өгөх гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэнэ гэсэн заасны дагуу хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлахаас асуулт асууж болно гэсэн энэ тайлбаруудыг бас нэмж ингэж та бүхэнд сонсгоё. Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Боловсролын ерөнхий хуулийн төслийн, ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн танилцуулгыг хийе.

Г.Дамдинням: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 58, дэд ажлын хэсэг нийт 31 удаа хуралдлаа. Ажлын хэсэг, ажлын дэд хэсгээс бэлтгэсэн болон иргэд, ажлын хэсгийн

гишүүд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түнш салбар яам, агентлаг, ТББ-аас ирүүлсэн санал нэг бүрийг хуулийн төсөлд тусгах боломжтой эсэх асуудлыг судлан үзэж ажиглалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний суурь эрхийн нэг нь боловсрол эзэмших суралцах эрх гэж заасан байдаг. Энэ эрхийг хангах иргэн бүрд чанартай тэгш боломж бүхий боловсролын үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг юм. Энэ үүргийг хэрэгжүүлэх зохицуулалтыг Боловсролын хуулиар тодорхойлдог гэдгийг та бид бүгд мэдэх билээ. Өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн Боловсролын тухай хууль нь 2002 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан бөгөөд түүнээс хойш энэ хуульд Монгол улсын хөгжлийн бодлого бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд нийтдээ 31 удаа өөрчлөлт орсон. Боловсролын хуулийг дагалдан Дээд боловсролын тухай хуульд 11 удаа, Бага, дунд боловсролын тухай хуульд 14 удаа, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд 6 удаа, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд 2012, 15, 16 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж иржээ. Эдгээр шинэчлэл өөрчлөлтүүд нь хууль тус бүрээр дангаараа хийгдэж байсан бөгөөд энэ удаагийн шинэчилсэн найруулга нь багцаараа хийгдэж байгаа нь өмнө нь өмнөх шинэчлэлүүдээс онцлог юм.

Боловсролын тогтолцоонд албан боловсролоос гадна албан бус боловсрол, амьдралын орчинд суралцахуйг хүлээн зөвшөөрөх зэрэг суурь асуудлыг хамарсан эрх зүйн шинэчлэлийг хийх нь насан туршидаа суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх үндэс болох юм. 2019 оноос эхлэн ковидын цар тахал боловсролд багагүй сөрөг үр дагавартай байна. Монгол Улсын хүүхэд залуучуудын нэг үе энэхүү цар тахлын нөлөөгөөр суралцахуйн хоцрогдолд орж, ы энэ нь тэдний цаашидын боловсрол сургалт ажил мэргэжлийн бэлтгэл, замналд сөрөг өөр нөлөөлөх нөлөө үзүүлэх

төлөвтэй байна. Технологийн дэвшил ухаалаг төхөөрөмжүүдийн хөгжилтэй зэрэгцэн өсөж буй залуу үеийн хэрэгцээ, сонирхол, мэдээллийн олон янзын нээлттэй эх сурвалжийн нөлөөгөөр өөрчлөгдөж, тэднийг сургах, хөгжүүлэх арга хэлбэр аргачлалд өөрчлөлт хийх цаг нэгэнт болжээ.

Зөвхөн багшаас мэдээлэл авч, багш бүгдийг зааж сургадаг цаг үе өнгөрөө, үеэ өнгөрөөж, хүүхэд залуучууд өөрөө технологи ашиглан зах хязгааргүй виртуал орчинд мэдээллээ эрж олдог, байршилаас үл хамааран найз нөхөдтэй болж, хамтран сурдаг, түүнийгээ дэлхийн аль ч улсад хүлээн зөвшөөрүүлж чаддаг болсон байна. Боловсрол сургалтыг бид сургууль биш сурах бичиг гэсэн хязгаарлагдмал хүрээгээр хардаг байдлаа өөрчлөх хэрэгтэй байна. Сургууль, багш, сурах бичиг гэсэн хязгаарлагдмал хүрээгээр хардаг байдлаа өөрчлөх хэрэгтэй байна.

Ингээд Ажлын хэсгийн хэсгээс дараах зарчмын өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусган зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд, Боловсролын санхүү үйлчлэлийг авч үзэхдээ цэцэрлэг, ЕБС-ийн санхүүжилтийг хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн суурь хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийг шинээр тусгалаа. Төсвийн шинэчлэлийн хүрээнд боловсролын байгууллагын засаглалыг бэхжүүлж, сургууль, цэцэрлэгт төсвийн тодорхой эрх мэдлийг шилжүүлж, хагас бие даасан, олон талын оролцоог хангасан тогтолцоог хэрэгжүүлэх алхмыг бүрдүүлж дараах 4 чиглэлийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулна. Хувьсах зардлын санхүүжилтийн зарчмыг шинэчлэн сургалтын үйл ажиллагаа шууд хамааралгүй зардлыг хасаж, хувьсах зардлын нормативын бүрэлдэхүүнд багшийн хөгжил, танхимаас гадуурх сургалт, судлагдахуун тус бүрээр тооцсон хичээл практикийн зардал, ажил олгогчоос хариуцах эрүүл мэндийн урьдчилсан

сэргийлэх үйлчилгээний зардал, цахим хэрэглээний зардал зэргийг нэмэлтээр тооцож санхүүжүүлнэ. Ингэснээр сургалтын чанар ахиц гарахын зэрэгцээ өмнө урьд өмнө багш нарын халааснаас гардаг зардлыг бууруулж, бодит орлогыг нь хамгаалах давхар ач холбогдолтой байх юм.

Багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах, ажлын ачааллыг гүйцэтгэлд тооцох багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахын тулд хувьсах зардлын бүрэлдэхүүнд ангийн хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдлийг шинээр тусгаж, багшийн хөгжлийн зардлыг багш бүрээр тооцон олгоно. Хувьсах зардлын хэмжээг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн боловсролын авах тусгай хэрэгцээнд уялдуулан, хэрэгцээг уялдуулан сургалтын байгууллагын түвшин тус бүрээр ялгавартай тогтооно.

Боловсролын зээлийн санг илүү үр дүнтэй эргэлтэд оруулахыг зорьж, Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр сурлагын амжилт гаргасан суралцагсдыг хамруулахаар болж, Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөн зохион байгуулна. Хэн сайн суралцана тэр урамшуулал авна гэсэн сонгомол зарчим үйлчилж эхэлнэ гэсэн үг. Боловсролын хяналт шалгалт үнэлгээний тогтолцоо бий болгох зорилгоор боловсролын түвшин бүрд хөндлөнгийн үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг нэмж тусгалаа.

Багшийн чанар, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр багш бэлтгэх хувилбарт сургалт, мэргэжлийн хөгжлийн үндэсний бүсийн сургуульд суурилсан тогтолцоог бий болгож байна. Багшийн мэргэжлийн хөгжилд талууд тэгш оролцоотой байх, их, дээд сургууль төгсөгчийнхөө мэргэжлийн хөгжлийг хариуцдаг тогтолцоонд ишилжинэ. Боловсролын удирдлага засаглалд өөрчлөлт оруулж, чадахуйн зарчимд

суурилсан, шударга, мэргэшсэн томилгооны механизмыг нэвтрүүлэхээр тусгалаа. Боловсролын сургалтын байгууллагын удирдах албан тушаалтныг томилохдоо Төрийн албаны тухай хуульд заасан зарчмыг баримталж, цэцэрлэг, ЕБС-ийн эрхлэгч, захирал, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн хэлтсийн даргад тавих нийтлэг шаардлагыг тусгалаа.

Боловсрол, сургалт, боловсрол, сургалт, ажил амьдралын салиггүй хэсэг болсон цахим шилжилт, цахим боловсрол, цахим сургалтын байгууллагатай холбоотой уян хатан зохицуулалтыг шинээр тусгалаа. Боловсролын цахим шилжилтийн хүрээнд салбарын сургуулийн, салбарын СӨБ-ын байгууллага, ЕБС-ийн хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүнд анх удаа цахим хэрэглээний болон тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг тусгаснаар багшийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах дата хэрэглээний зардал, боловсрол, сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын систем, LMS, SMS зэрэг сургалтын зориулалттай программ хангамж, системийн эрх, лицензийг хэрэглээндээ нийцүүлэн хэрэглэх эрх зүйн болон санхүүгийн зохицуулалтыг бий болгон төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллах юм.

ЕБС-д олон улсын хөтөлбөрөөр байгалийн шинжлэл, англи хэл, математик, мэдээллийн технологи гэх мэт хичээлүүдийн цахим сургалтыг хэрэгжүүлнэ. Цахим сургалт нь багш нарын ажлын ачааллыг бууруулах, суралцагчид өөрийн түвшинд тохируулан суралцах, суралцахуйн ахиц дэвшлийг хянах, дэмжин туслах, хоцрогдлыг нөхөх, илүү сонирхолтойгоор суралцах боломжийг бүрдүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд бусад үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа

суралцах тэгш боломжийг бүрдүүлэх чиглэлээр шинэ заалтуудыг тусгалаа.

Тухайлбал, сонсогчдын бэрхиээлтэй хүүхэд, залуучууд сургалтын хэл, дохионы хэл болох тохирох орчин, сурах бичгээр хангахтай холбоотой зохицуулалт одоогийн хуульд байхгүй байсныг өөрчилж шинэ заалтуудыг нэмлээ. Боловсролын хөрөнгө оруулалтыг хэн нэгэн эрх мэдэлтний санал хүсэлтээр бус, сургалтын байгууллагын бодит хэрэгцээ, суралцагчийн тооны өсөлтийг харгалзан газар зүй мэдээллийн системд суурилсан хийдэг байх, хамран сурах тойргийг шинжлэх ухаан технологийн дэвшилийг ашиглан мэргэжлийн байгууллага хийдэг байх зохицуулалтыг тусгаад байна.

Хуулийн төсөл батлагдсанаар салбарын байгууллага, хүний нөөц, суралцагч, иргэнд дараах үр дүн гарах юм. Үүнд, сургуулиудын чанарын ялгаа арилгах ахиц арилгахад ахиц гарна. Хүүхэд хаана амьдарч, ямар сургуульд сурч байгаагаас үл хамаарч нэг ижил чанартай боловсрол эзэмших боломжтой болно. Нэгэнт сургууль бүр ижил стандарттай бас үр дүнтэй болсноор хамгийн сайн сургууль хамгийн ойрхон сургууль гэсэн агуулга үйлчилж эхлэх юм. Хүүхдүүдийг хүүхдийг дүнгээр бус ахиц дэвшилээр үнэлдэг болно. Би угаасаа л дунд сурлагатан гэсэн хэвшмэл ойлголтыг эвдэж, хүүхэд зөвхөн сайн дүн амжилтад хүлэгдэх биш ирээдүйд нийгэмд бие авч явах чадвартай, өөртөө итгэлтэй хувь хүн болж төлөвшихөд нь түлхэц болно.

Цэцэрлэг, сургуулийн удирдлагын томилолтоос шууд шалтгаалах буюу мэргэжлийн сонгон шалгаруулалт гэх эрүүл тогтолцоог бий болгож боловсрол сургалтыг улс төрөөс ангид байлгаж зөвхөн ур чадвар, чадавхаараа шалгарсан боловсон хүчинтэй болно. Ажлын гүйцэтгэл үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бэхжүүлнэ. Сургуулийг биш суралцагчийг

санхүүжүүлдэг болно. 20 хүүхэдтэй сумын төвд 200 хүүхдийн сургууль барьсан түүхийг давтахгүйгээр газар зүйн өгөгдөл, судалгаа, тухайн орон нутгийн суралцагчийн тооны өсөлт, бууралтын онцлогийг харгалздаг болно.

Багш ажлын байран дээрээ бодит хэрэгцээндээ нийцсэн байдалаар мэргэжлийн ур чадвараа хөгжүүлдэг, бие биеэсээ суралцдаг болно. Олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог бүрдүүлнэ. Цахим боловсролыг хөгжүүлнэ. Хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч сайн багшаас сайн хөтөлбөрт суралцах тэгш боломжтой болно. Боловсролын ерөнхий хууль болон дагалдах хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш олон нийт болон талуудад 42 удаагийн танхимаар болон онлайнаар хэлэлцүүлэг хийж, 1600 орчим санал зөвлөмжийг хүлээн аваад байна.

Хуулийн төслүүдтэй 37174 иргэн танилцсан ба үүнээс Боловсролын ерөнхий хуулийн төслийг 28442 иргэн судалж үзэж, 1568 санал ирүүлээд байна. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг иргэд, байгууллагаас ирүүлсэн санал болон холбогдох судалгаа, тайлан, мэдээллийг судлан, хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, нэр томъёог жигдлэх зэргээр бэлтгэсэн зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналуудыг та бүхэнд хүргүүллээ. Ажлын хэсгээс бэлтгэсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүнд баярлалаа. БСШУС-ын байнгын хорооны өнөөдрийн хуралдааны ирцийг танилцуулъя. Амгалангийн Адъяасүрэн Баянхонгор аймаг 3 дугаар тойрог ирж байгаа юм байна. Пүрэвжавын Ануужин СХД 28 дугаар тойрог одоогоор тодорхойгүй байна. Тилеуханы Аубакир Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог ирсэн байна.

Ёндонпэрэнлэйн Баатарбилиг Архангай аймаг 1 дүгээр тойрог чөлөөтэй байна. Балжиннямын Баярсайхан Завхан аймаг 9 дүгээр тойрог ирсэн байна. Энхбаярын Батшугар СХД 28 дугаар тойрог ирсэн байна. Хассуурийн Ганхуяг БГД 26 дугаар тойрог одоо ирж байгаа байх. Гонгорын Дамдинням Дархан-Уул аймаг 19 дүгээр тойрог ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа СХД 27 дугаар тойрог ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг СБД 24 дүгээр тойрог ирсэн байна. Чинбатын Ундрэм Сэлэнгэ 13 дугаар тойрог ирсэн байна. Ням-Осорын Учрал СХД 28 дугаар тойрог ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн БЗД 23 дугаар тойрог ирж байгаа. Содномзундуйн Чинзориг Өвөрхангай аймаг 10 дугаар тойрог ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. БСШУ-ы сайд Энх-Амгалан, Боловсрол шинжлэх ухааны дэд сайд Ганбаяр, Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга. Оюунаа БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга ирсэн байна. Хуяцогт БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. Хуяцогт дарга байхгүй байна. Нарантуяа БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч ирсэн байна. Ариунаа Монгол Улсын консерваторын сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, шинжлэх ухааны доктор, профессор Ариунаа багш ирсэн байна. Цогтгэрэл Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Цогтгэрэл дарга ирсэн байна. Номин Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Номин тэргүүн ирсэн байна. Ажлын дэд хэсгийн нарийн бичгийн дарга Баярмаа БШУЯ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Баярмаа. Цолмон БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч

Цолмон ирсэн байна. Чойсүрэн БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын ахлах шинжээч Чойсүрэн ирсэн байна. Адилбиш БШУЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн ахлах шинжээч Адилбиш. Өнөөдрийн хуралдаанд ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Боловсролын ерөнхий хуулийн төслүүдийн 1 дүгээр зүйл дээр санал хураалт тийм ээ, уншиж танилцуулъя.

1. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх. Энэ чинь бүр 1 дүгээр зүйлийг нь бүгдийг нь уншина шүү дээ. 2. 1 дүгээр зүйл саяын зүйл дээр 1 дүгээр санал дээр санал хураалт явуулъя. Санал хураалт 81.8 хувиар энэ санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх. Санал хураалт, санал хураалт. Энэ санал хураалт 81.8 хувиар дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт,” гэснийг “зорилго, зарчим, тогтолцоо” гэж, “холбоотой” гэснийг “холбогдсон” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ. 1 дүгээр зүйл дээр санал хураалт ингээд алга тогшсон.

Боловсролын ерөнхий хуулийн 2 дугаар зүйл дээр санал хураалт явуулъя.

4. Төслийн 2 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль болон түүнтэй” гэснийг “Сургуулийн өмнөх болон

ерөнхий боловсролын тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай, Дээд боловсролын тухай, Багийн хөгжлийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай” гэж өөрчлөх. Санал хураалт, энд чинь яах билүү? Асуулт байхгүй. Энэ санал дээр 63.6 хувиар дэмжигдлээ. Мөнхцэцэг гишүүн энэ саналыг дэмжсэн байна Ц.Мөнхцэцэг гишүүн, протокол дэмжсэнээр оруулъя. Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн энэ уншсан. Тэгж яах юм бэ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “нэр томъёо” гэснийг “нэр томъёоны тодорхойлолт” гэж, мөн зүйлийн 3.1.1 дэх заалтын “12 жилийн сургалтын агуулгын түвшинг” гэснийг “бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсролыг” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “төлөвшилийг” гэснийг “төлөвшилийн цогцыг” гэж, 3.1.3 дахь заалтын “мэргэжлийн болон дээд гэсэн ангиллыг” гэснийг “мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг” гэж, 3.1.5 дахь заалтын “танхимын бус хэлбэрээр явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 3.1.6 дахь заалтын “олгох” гэснийг “эзэмших” гэж, 3.1.7 дахь заалтын “бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ, сонирхолдоо” гэснийг “хүний хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө” гэж, мөн заалтын “албан бус” гэснийг “албан болон албан бус” гэж, 3.1.8 дахь заалтын “хэрэгцээг ханган, тухайн түвшиний” гэснийг “үр дүнг” гэж, 3.1.11 дэх заалтын “иргэнийг” гэснийг “хүнийг” гэж, 3.1.13 дахь заалтын “түүний үнэлгээ” гэснийг “зорилго, зорилт, үнэлгээ” гэж, мөн заалтын “багц” гэснийг “цогц” гэж, 3.1.15 дахь заалтын “хандлагыг” гэснийг “хандлага, эрхэмлэх үнэт зүйлийг” гэж, 3.1.16 дахь заалтын “иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшилийг” гэснийг “хүний

эзэмшсэн чадвар, чадамжийг” гэж, “эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг” гэснийг “эрэмбэлсэн бүтцийг” гэж, 3.1.18 дахь заалтын “мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан явуулах” гэснийг “цахим технологи ашиглан зохион байгуулах” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал хураалт 88.8 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.8, 3.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 3.1.8 дахь заалтын “хөтөлбөрийн” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 3.1.11 дэх заалтын “элсэн” гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтыг төслөөс хасах. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.10, 3.1.17, 3.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.9. “албан бус боловсрол” гэж иргэн, хуулийн этгээдээс хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.10. “амьдралын орчинд суралцахуй” гэж хүний ажил, амьдрал, нийгмийн орчинд бие даан чадвар, боловсрол эзэмших үйл ажиллагааг;

3.1.17. “хувьсах зардал” гэж сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэг суралцагчид ногдох шууд болон шууд бус өртөгт суурилсан зардлын дундаж хэмжээг;

3.1.19. “цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллага” гэж зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдлын мэргэжлийн чиглэлээр сургалт

эрхэлдэг хуулийн этгээдийг;” Төслийн 3 дугаар зүйл энэ болов уу. Санал хураалт. Энэ санал 90.9 хувиар дэмжигдсэн байна.

9.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.20-3.1.25 дахь заалт нэмэх: 9 дүгээр санал дээр явж байгаа шүү манайхан.

“3.1.20. “боловсролын үнэлгээ” гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг;

3.1.21. “чанарын баталгаажуулалт” гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг;

3.1.22. “хөндлөнгийн үнэлгээ” гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг;

3.1.23. “магадлан итгэмжлэл” гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж буй эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

3.1.24. “эндаументын сан” гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй ишлжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;

3.1.25. “ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.” Санал хураалт. Санал хураалтыг түр татгалзуулъя. Энэ санал

хураалт дээр гишүүд асуулт тавина. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Учрал гишүүн асуултаа асуугаад явчихъя.

Н.Учрал: Энэ Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль дээр 3.1.20-оос 25 гэсэн заалт нэмэгдэж байна. Энх-Амгалан сайд энийг сайн хараарай. Энэ чинь бүр өөр зүг рүү явлаа шүү дээ. Боловсролын үнэлгээ хөндлөнгийн үнэлгээ гэж юуг хэлээд байгаа юм бэ? Энийг нөгөө яг ямар хуулиас ингээд аваад, юу гэж ойлгоод байна вэ? Мониторинг хийх юм уу, аудит хийх гээд байгаа юм уу? Энэ хуулиар чинь дүүрэн л хяналт шалгалт боллоо шүү дээ.

2-т чанарын баталгаажуулалт гэдэг бол байгууллагыг баталгаажуулдаг шүү. Энх-Амгалан сайдын оруулж ирсэн хууль дээр бол стандартыг ярьж байна лээ шүү. Стандартын хэмжил зүйн газар Боловсролын стандарт гээд энэ хуульд орчихсон байгаа. Энэ хууль дээр 20-оос 25 дээр энэ Их Хурлын ажлын хэсэг чанарын баталгаажуулалт гэдэг үг оруулж ирж байна шүү. Энэ уг нь зөв. Гэхдээ энэ хуулийг чинь хэрэглэх бололцоогүй болно цаашидаа. Тэгэхээр чанарын баталгаажуулалт гэдэг бол тухайн боловсролын байгууллагыг үнэлдэг байхгүй юу. Баталгаажуулалтыг.

Магадлан итгэмжлэл гэдэг бол ингээд харахаар 3.1.23-ыг чинь харахаар чанарын баталгаажуулалт ороод ирчхэж байгаа учраас магадлан итгэмжлэл нь хөтөлбөр дээр байх юм уу гэхээр хөтөлбөр боловсролын сургалтын байгууллагыг хоёулан дээр нь магадлан итгэмжлэл явах гээд байгаа Европын тогтолцоо руу явж байгаа юм. Энийг чинь харахаар. Нөгөө талаараа харахаар энэ нэг барууны тогтолцоо. Тэгээд сургууль бол сургалт болон эрдэм шинжилгээний байгууллага байна гээд энэ хууль дээр анх орж ирсэн юм. Одоо эндаумент фанд гэдэг агуулга орж ирж байгаа. Тэгээд эндаумент фанд гэдэг бол ашиг олох зорилгогүйгээр бүрдүүлсэн сан хэдий ч хэрвээ Монгол Улс

Боловсролын ерөнхий хуульдаа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагыг л тэр боловсролын байгууллага гэж үзнэ гэж үзэж байгаа бол эндуймент фанд гэдэг ойлголт орж ирэх боломжгүй. Энэ чинь өөр байхгүй юу. Энэ инновацийн үйл ажиллагааг дэмжих чинь өөрөө судалгаанд суурилсан, commercial хийгдэх үйл явцаас чинь босож ирдэг эндаумент фанд бол өөр ойлголт.

Тэгэхээр би зүгээр юу гэж хэлэх гээд байна гэхээр Энх-Амгалан сайд наад хуулиа харахгүй бол цаашдаа та бүр энэ хуулиа танихгүй байх. Тэгээд ер нь нэг хаашаа явж байгаагаа их зөв яриад, энэ ажлын хэсгийнхэн та нар ер нь юу бодож байна вэ? Тэгээд энэ хуулиа уншаад ер нь та нар ойлгох уу? Энэ дотор чинь чанарын баталгаажуулалт, боловсролын үнэлгээ, боловсролын стандарт, магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, тэр байтугай мэргэжлийн хяналтын үүрэг орсон шүү дээ энэ хуульд. Судалгааны энэ эрдэм шинжилгээний эрх, эрх чөлөөг дэмжинэ гэж байгаа мөртөө сургалтын хөтөлбөрүүдийг гаднаас нөгөө хөтөлбөрийг articulation хийх үйл явцыг Боловсролын сайд баталж байгаа хууль шүү дээ энэ. Тэгээд та нар эндаумент фанд яаж бүрдүүлэх вэ?

Энэ бас манай энэ их дээд сургуульд багшилж байсан энэ хүмүүс байгаа шүү дээ. Энэ Мөнхцэцэг гишүүн, Ундрэм гишүүн энэ тэр хэлээч, энэ хуулиа хараач.

Г.Мөнхцэцэг: Дэгээрээ ажлын хэсгийн ахлагч хариулах ёстой. Асуулт хариулт хангалтгүй гэж үзвэл сайд нэмж хариулж болно.

Г.Дамдинням: Учрал гишүүн бас тодорхой байр суурь илэрхийлж байна. Ажлын хэсэг дээр бид нар энэ асуудлыг ярьсан. Монголын боловсрол ер нь муу, сайн гээд янз бүрээр хэлэгдээд яваад байгаа юм. Бид ер нь хаана яваагаа харах ёстой юм. Хаана яваагаа харахын тулд

олон улсын хөндлөнгийн үнэлгээ зайлиггүй оруулж ирэх ёстой. Ний нуугүй хэлэхэд бид нар 3 жил тутам Писагийн үнэлгээ буюу OECD-ийн Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын олон улсын үнэлгээгээр үнэлж, хаанаа болоод байгаа юм, хаанаа болохгүй байгаа юм бэ гэдгээ үнэлэх ёстой. Энд тэр чигтээ дагаад стандартын шаардлагуудтай цуг орж ирдэг. Та өөрөө энийг мэдэж байгаа. Кэмбрижийн стандарт гэж ярина эсвэл Финлянд стандарт гэж ярина бүгд л ярина.

Тэгэхдээ бид үндэсний боловсролын тогтолцоогоо олон улстай өрсөлдүүлэхийн тулд зэрэгцүүлж босгож ирэхийн тулд үндэсний боловсролын тогтолцоогоо олон улсын үнэлгээгээр үнэлж байж л хөндлөнгийн үнэлгээг явуулахаас сайжруулахаас өөр аргагүй. Тийм учраас хөндлөнгийн үнэлгээ гэдэг ойлголт орж ирж байгаа юм.

2 дугаарт эндаументийн сан. Эндаументийн сан бол ашиг хүртдэг ч байж болно, ашиг хүртдэггүй ч байж болно. Тийм учраас та нэг юмыг бас бодолцоорой. Энэ Боловсролын ерөнхий хууль Учрал гишүүнээ. Боловсролын ерөнхий хууль дээр эндаументийн сангийн ойлголтыг ерөнхий утгаар оруулж байгаа юм. Үүний дараа бид нар Дээд боловсролын хуулийг оруулж ирнэ. Дээд боловсролын хууль дээр нарийвчилсан таны яриад байгаа инновацийтай холбоотой, бизнестэй холбоотой старт аптай холбоотой, хамтын хөрөнгө оруулалттай ашиг хүртэж болдог эрдэм шинжилгээний бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт 2 нийлж бизнес болж үр өгөөжөө өгдөг энэ зохицуулалтыг нарийвчлан оруулж ирэх ийм төлөвлөгөөтэй байгаа юм. Боловсролын ерөнхий хуулийн хүрээнд бол бид ерөнхий утгаар нь оруулж ирсэн юм шүү гэдгийг танд хэлье. Тийм.

Г.Мөнхцэцэг: Хангалттай. Учрал гишүүн тодруулъя.

Н.Учрал: Би энэ ажлын хэсгийн ахлагчийг бас энэ хуулийг бас нэг олон улсын жишигт нийцүүлэх гээд оролдоод байгаа оролдлогыг бол хүндэлж байна. Гэхдээ энэ хууль чинь хэрэгжих байхгүй юу дараа нь. Тэгэхээр жишээ нь магадлалын итгэмжлэл accreditation гэдэг үг бол их дээд сургууль дээр гэдгийг нь ялгаж өгөхгүй бол энэ чинь ойлгомжгүй болно. Хөндлөнгийн үнэлгээ гэдэг чинь ерөнхий боловсролын сургуулиуд дээр тэр ПИСА-гийн үнэлгээг чинь тусдаа асуудал. Боловсролын үнэлгээ чинь аль шатны боловсролын байгууллагад хэрэгжих юм тусдаа асуудал. Тэгтэл энэ хууль дотор чинь дахиад боловсролын стандарт гэж юм яваад байгаа байхгүй юу. Тэр байтугай нөгөө татан буугдсан мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг байна. Одоо салбарын хяналтын газрын чиг үүрэг чинь энэ дээр ороод ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд ингээд түмэн юм орж ирчхээд байна шүү дээ. Та нар одоо энэ боловсролын ажлын хэсгийнхэн та нар энэ хуулийг хэрэгжүүлэхэд хүнд байдалд очно шүү. Би зүгээр анхааруулж протоколд үлдээж байна. Дараа нь тэгээд болохоо болилоо гээд нэг юм яриу.

Г.Мөнхцэцэг: Учрал гишүүний нэмэлт асуултад Дамдинням гишүүн хариулах уу?

Г.Дамдинням: Зөв, зөв тийм Учрал гишүүн их чухал юм хэлж байгаа юм. Тэгээд бид нар ажлын хэсэг дээр энийг ярьсан юм Учрал гишүүнээ. Тэгээд бас энэ хууль Монголын боловсролын бүхий л тогтолцоонд үйлчлэх хууль. Энэ удаагийн боловсролын шинэчлэлээр орж ирж байгаа ерөнхий хуулийн энэ багц хууль гэж нэрлэгдээд байгаа гол шалтгаан нь бол бид Ерөнхий хуулиар бүх ерөнхий агуулгуудаа оруулаад дагаж орж ирж байгаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль дээр таны яриад байгаа ерөнхий боловсрол, СӨБ-той холбоотой хэсгийг нь нарийвчлан зааж өгнө. Дээд боловсрол

дээр бас нарийвчлан зааж өгнө. Насан туршийн боловсрол дээр нарийвчлан зааж өгнө. Мэргэжлийн боловсрол дээр нарийвчлан зааж өгч зохицуулъя гэдэг ийм ерөнхий бүтцээр нь томоор нь харах юм бол их ойлгомжтой болоод явчихна. Тэгээд таны хэлж байгаа санааг бол дагалдаж орж ирэх хуулиуд дээр тодорхой тусгаад, тусгаад явчихна. Ерөнхий хууль учраас бүхий л түвшинд үйлчилнэ. Эндээсээ яг аль хэсэг нь хаанаа үйлчлэх нь дагалдаж орж ирэх хуулиудаараа зохицуулагдана л гээд ойлгоод явчихад болно тийм.

Г.Мөнхцэцэг: Энх-Амгалан сайд энэ дээр дахиад нэмэлт ялгааг тайлбарлаад нэг хариулт өгчих.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр манай энэ Засгийн газраас өргөн барьсан хууль манай ажлын хэсгийн гишүүдийн ажилласан энэ хуулиудын гол, гол б бид нар чинь энэ хуулиараа нөгөө б том шинэчлэл хийхээр л оролдоод байгаа шүү дээ. Тэрний шинэчлэлийн нэг нь бол энэ боловсролын чанарын асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар цаашидаа нэгэнт бид нар өнөөдөр Монгол Улсад байгаа бүх түвшний СӨБ, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын түвшинд энэ чанар гэдэг асуудал бол үнэхээр хоцрогдчихсон 1 дүгээрт.

2 дугаарт энэ чанарын тухай ойлголт ер нь боловсролын чанарын тухай ойлголтуудаа бид нар 1 дүгээрт нэг болгох ер нь чанарыг юу гэж ойлгох юм, яаж хэмжих юм, яаж үнэлэх юм, яаж баталгаажуулах юм гэдэг энэ тогтолцоогоо бид нар бэхжүүлэх гэж оролдсон ийм зүйл учраас энэ чанарын баталгаажуулалтууд, хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл гэсэн энэ юунууд томъёоллуудыг их зөв томъёолж оруулж ирж байгаа байхгүй юу. Яах вэ Учрал гишүүний болгоомжлоод байгаа хэрэгжилтийн явцад бол хүндрэл үүснэ шүү.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Санал хураалтдаа оръё. 10 дугаар зүйл дээр. Төслийн 4 дүгээр зүйлийн. Жаргалмаа гишүүн асуулт асууя, нэрээ өгч оруулна шүү.

Б.Жаргалмаа: Асуулт дарагдаагүй. Тэгээд би сая ажлын хэсэг рүү хэлээд хурлын ажлын алба руу хэлээд нэрээ оруулсан. Би энийг яагаад асуух гээд байгаа юм бэ гэвэл уг нь өчигдөр ажлын хэсэг дээр бид нар бас ярилцсан юм. Би зүгээр олон нийтдээ мэдээлэл өгөх зорилгоор энэ асуултыг асууж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бас протоколд үлдээх шаардлагатай байх гэж бодож байна.

Сая Учрал гишүүн ч гэсэн асууж байна. Ялгаатай хэрэгцээ гэж юу хэлээд байгаа юм бэ гэж. Өчигдөр ажлын хэсэг дээр асуухдаа би Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль батлагдаагүй байна одоо орж ирнэ, Хүртээмжтэй байдал, тэгш байдлын тухай хууль орж ирнэ. Бид нар хөгжлийн бэрхшээл гэдэг үгтэй байх уу, үгээр тодорхойлох уу эсвэл ялгаатай хэрэгцээтэй хэрэгцээт байдал гэдэг үгээр тодорхойлох уу гэдэг асуудал яригдаж байгаа энэ цаг мөчид бид нар Боловсролын ерөнхий хуульдаа ялгаатай хэрэгцээ гээд ороод ирж байгаа. Тэгээд энийг бас олон нийтэд тайлбарлаж явахгүй бол чуулган дээр би бас ажлын хэсэгт орсон гишүүний хувиар бас тайлбар сонсох боломжгүй болно. Олон нийтдээ мэдээлэл өгөх зорилгоор энийг асууж байгаа юм. Ялгаатай хэрэгцээ гэдэг байдал дээр тайлбар өгөөч гэж?

Г.Мөнхцэцэг: Жаргалмаа гишүүний асуултад ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн хариулья. Өчигдөр ажлын хэсэг дээр бас нэлээн ярьсан.

Г.Дамдинням: Манай Жаргалмаа гишүүн манай ажлын хэсгийн гишүүн. Тэгээд бас өчигдөр асууж байсан асуултаа ажлын хэсэг дээр асууж байсан асуултаа олон нийтэд мэдээлэл

өгөх зорилгоор асууж байгаа учраас би бас мэдээлэл өгөх зорилгоор хариулья. Боловсрол эзэмшихтэй холбоотой л ялгаатай хэрэгцээ.

Өөрөөр хэлбэл Боловсролын ерөнхий хуулийн төслийн 3.1.25 дээр ялгаатай хэрэгцээ гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг гэж томъёолсон байгаа юм. Үүгээрээ бид нар юу оруулж ирэх гээд байгаа вэ гэхээр энэ хууль дээр нэг тодорхой агуулга тусчихсан байгаа юм. Юу вэ гэхээр энэ ялгаатай хэрэгцээ саяын дурдагдсан энэ ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулагдсан хувьсах зардлын хэмжээг нэмэлттэйгээр илүү болгож өгье гээд байгаа юм.

Баян-Өлгий аймагт байгаа хүүхэд Улаанбаатар хотод байгаа хүүхдээс илүү зардал авч байж сурна гэсэн үг. Өөрөөр хэлбэл гаргаж байгаа. Яагаад гэвэл тэр чинь аягүй алс хол байгаад байгаа байхгүй юу, нэмэлттэй байгаад байгаа юм. Эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байх юм бол тэр хүүхдийн хэрэгцээнд зориулсан тусгай хэрэгцээний санхүүжилтийг гаргаж өгөх ёстой. Соёлын хэрэгцээ байна. Хэл соёлтой холбоотой асуудлууд байна. Эд нар дээр нь бид нар хувьсах зардлын энэ зохицуулалтаа оруулахын тулд ийм томъёолол шинээр оруулж ирж байгаа юм шүү. Энэ бол бас хэрэгтэй зүйл юм байгаа юм гээд тийм. Тэгш хамран сургах орчныг л бүрдүүлэх гээд байгаа юм. Бүгдтэй нь ижилхэн хэрэгцээгээ хангах тэгш боломжийг л бүрдүүлж байгаа юм. Тийм.

Г.Мөнхцэцэг: Хариулт хангалттай гэж үзэж байна. 10, 10 дугаар төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. 4.1 Монгол Улсын боловсролын зорилго нь. Төслийн 3 дугаар зүйл дээр 9 дүгээр санал хураалт явуулья. Саяын 9

дүгээр саналаар санал хураалт. Ажлын хэсэг дээр ярьсан юмаа цагаа хожъё л доо, цагаа хожъё л доо энэ чинь 81 санал байгаа шүү дээ. Тийм шүү дээ. Санал хураалт 70 хувиар дэмжигдсэн байна.

Энэ дугаарласнаараа бол 10. 4 дүгээр зүйл дээр санал хураалт. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршидаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оришино.” Санал хураалт. Өөрөө санал хураалтад оролцохоо мартчихсан сууж байна. Энэ санал 80 хувиар дэмжигдсэн байна.

11 дүгээр дугаартай. Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “шинжлэх ухаан, олон улсын” гэснийг “шинжлэх ухааны” гэж, 5.1.5 дахь заалтын “оролцоо” гэснийг “оролцоог хангасан” гэж, 5.1.7 дахь заалтын “үндэслэсэн” гэснийг “нийцсэн” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.3 дахь заалтын “уялдаатай” гэсний дараа “уян хатан” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.11 дэх заалт нэмэх.

“5.1.11.хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх;” Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

12 дугаар санал дээр. Төслийн 5.1.1, 5.1.8, 5.1.9 дэх заалтыг төслөөс хасаж, 5.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг нэмэх:

“5.1.Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх бөгөөд бодлого, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил, тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.” Санал хураалт. Санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшний” гэж, 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ техник зохион байгуулагч байна уу? Хуралдаан зохион байгуулагч хувь гарахгүй байна. Техникийнхэнд хэлээч. Энэ санал 80 хувиар дэмжигдсэн байна.

14.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.6, 6.7 дахь хэсэг нэмэх:

“6.6.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.7.Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна.” Санал хураалт. Санал хураалт техник, одоо техник ажиллаж эхэлж байна. Саналаа өгчих одоо болж байна. Энэ саналыг цуцлаад дахиад санал хураалт явуулъя. Техник ажиллахгүй байгаад байгаа учраас санал хураалтыг дахин явуулъя. Дахин санал хураалт явуулъя. Сая техник гацсан учраас. Санал хураалт, дохиолол

дуугарахаар л. Энэ санал 70 хувьтай дэмжигдлээ.

15.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “албан бус” гэсний дараа “боловсрол” гэж нэмж, мөн 7.1 дэх хэсгийн “орчноос суралцах боловсролоос” гэснийг “орчинд суралцахуйгаас” гэж, 7.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “шаттай” гэснийг “түвшинтэй” гэж, 7.3 дахь хэсгийн “орчноос” гэснийг “орчинд” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал хураалтын өмнө Учрал гишүүн үг байна, санал байна. Үүний дараа санал хураалтаа явуулъя. Учрал гишүүний микрофоныг өгье.

Н.Учрал: Энэ 7.1 дүгээр заалт боловсролын тогтолцоо нь албан ба албан бус болон амьдралын орчинд суралцах боловсролоос бүрдэнэ гэж. Тогтолцоо буюу систем орчноос бүрддэггүй юм. Наадах чинь утгагүй өгүүлбэр байна. Энийгээ янзлахгүй бол наадах чинь болохгүй нь. Боловсролын тогтолцоо орчноос бүрдэх бололцоогүй шүү дээ.

Г.Мөнхцэцэг: Энийг бас найруулга дахиж эргэж харах хэрэгтэй байна. Учрал гишүүний санал бас зөв зүйтэй санал байна. Ингээд санал хураалт. Сая техникийн тийм. Санал хураалт. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу ганцаарчилсан сургалт явуулж болно. Санал хураалт. Микрофон солиод суучхаач дээ. Ийш нь суучих. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ. Тэгээд байна уу?

17.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5, 8.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 8.3 дахь хэсгийн “дэмжигч болон явуулын багшийн, цахим” гэснийг “хувилбарт болон цахим, дадлага” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.7 дахь хэсэг нэмэх.

“8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь энэ хуулийн 8.1-д зааснаас гадна хосмог болон ажлын байрны сургалтын хэлбэртэй байж болно.” Санал хураалт. Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ.

18.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “мэргэжлийг” гэснийг “мэргэжил болон чадамжийн түвшнийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Суурь, бүрэн дунд боловсрол эзэмисэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмисэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмисэн төгсөгчид диплом олгоно.” Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Боловсролын” гэсний дараа “болон сургалтын гэж, “олгох” гэсний өмнө “түүнийг хөтлөх,” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “ хувийн хэрэг” гэснийг “бүртгэл мэдээлэл” гэж, 9.6 дахь хэсгийн “боловсролын” гэснийг “боловсролын болон сургалтын” гэж, 9.7 дахь хэсгийн “болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс” гэснийг “эсхүл, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас” гэж, “сургалтын баримт бичгийг” гэснийг “суралцагчийн эзэмисэн чадамжийг үнэлж,” гэж, 9.8 дахь хэсгийн “шатлалын” гэснийг “түвшиний” гэж, “олгохыг хориглоно” гэснийг “олгохгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн

9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай
9.10 дахь хэсэг нэмэх.

“9.10.Боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна.” Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя, санал хураалтыг цуцалъя. Учрал гишүүнд санал байна, саналыг сонсьё.

Н.Учрал: 9.10 дээр бол тэр боловсролын баримт бичиг цаасан болон цахим хэлбэртэй байна гэж нэмж байгаад их талархалтай байна. 9.7 дээр санал байгаа юм. 9 дүгээр зүйл дээр гадаад улсын болон олон улсын сургалтын хөтөлбөрөөс Монгол улсын боловсролын байгууллагад шилжин суралцах тохиолдолд сургалтын баримт бичгийг дүйцүүлэх багц цаг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална гээд. Боловсролын ерөнхий газар энийг батлахгүй. Энэ чинь дэлхийн жишиг нь өөрөө хөндлөнгийн ийм байгууллагууд байдаг байхгүй юу. Жишээ нь энэ Дамдинням гишүүн мэдэж байгаа шүү дээ. Канадад сургууль төгслөө. Тэр хөтөлбөрийг тэр кредитүүдийг зөвшөөрөөд дүйцүүлдэг байгууллага нь Америкт олон янз байгаа. Европт олон янз байгаа. Тэд нар зөвшөөрснөөрөө дараагийн сургуульд шилждэг.

Тэрнээс биш төрийн захиргааны байгууллага программыг, кредитийг шилжүүлэх ажлыг хийдэггүй шүү дээ. Та нар боловсролын салбарт чинь өөрөө академик эрх чөлөө олгох гээд байгаа биз дээ. Юу гэж Боловсролын ерөнхий газар төрийн захиргааны байгууллага нь тэгээд та нар хаашаа юм. Гадаадын сургуулийн диплом дээр тавигдсан кредитүүдийг зөвшөөрөөд нийцүүлээд сууж байгаа юм уу? Тийм юм байхгүй шүү дээ. Тийм эрх ч байхгүй, тийм боломж ч байхгүй. Тэгэхээр наад ажлаа ингэж өөр дээрээ авах бол бололцоогүй. Наад сургуулиуд чинь өөрөө яадаг вэ гэхээр тухайн сургууль хэдэн оронд тухайн программыг зөвшөөрсөн бэ гэдгээсээ шалтгаалаад тухайн оронд

ямар байгууллагууд тэр кредитийг нь баталгаажуулдаг вэ гэдгээс шалтгаалдаг байхгүй юу.

Жишээ нь Англид бол Малайз, Сингапурын сургуулиудын кредитүүдийг нь шилжүүлээд зөвшөөрөөд Америк руу шилжүүлэхдээ хэрэглэдэг тийм нөгөө хөндлөнгийн байгууллагууд байдаг байхгүй юу. Түүнээс төрийн захиргааны байгууллагууд биш. Та нар тэр дэлхийн том их дээд сургуулиудын кредитийг ингэж зөвшөөрөөд суухгүй шүү дээ. Тэгээд Ням-Очир дарга бас энийг хэлсэн нь дээр шүү дээ. Та нар ийм ажил хийж чадахгүй шүү дээ.

Г.Мөнхцэцэг: Учрал гишүүний хэлээд байгаа энэ олон саналуудыг бид нар бас эргэж харах хэрэгтэй байгаад байна. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн хариулт өгөөд, дээр нь нэмж тодруулж ажлын хэсгийн 5 дугаар микрофон дээр байгаа Ганбаяр дэд хэсгийн ажлын хэсгийн ахлагч нэмж хариулаарай. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Тийм ээ юу Учрал гишүүнээ энэ дээр нэг ийм асуудал үүсээд байгаа юм. Би тантай бол санал нэг байгаа юм. Энэ хоорондын аккредитаци хийдэг байгууллагуудаараа дамжуулаад л хийчихдэг юм байна лээ. Тэгээд хамгийн харамсалтай нь манай их дээд сургуулиуд гаднын байгууллагуудтай холбогдох нь битгий хэл хоорондоо холбогддоггүй юм байна лээ. Нөгөө кредитээ тооцох дээрээ. Тэгэхээр бид юу хийх гээд байгаа вэ гэхээр тэр олон улсын байгууллагуудын зөвшөөрчихсөн байгаа аккредитацийг зөвшөөрчээ гэдэг зохицуулалтыг нь хийж өгөхгүй бол нэг сургууль нь зөвшөөрөөд, нөгөөдөх нь зөвшөөрөхгүй хоорондоо шилжүүлэхгүй ингээд иргэдийг хохироогоод байдаг асуудал үүсээд байдаг байхгүй юу. Тухайн 2 сургуулийн хоорондын харилцааг нь баталгаажуулж өгөхгүй бол манайх авахгүй, нэг бол тэдийг илүү төлнө гэдэг

ийм юмнууд яригдаад байна гэдэг ийм л асуудлыг нь зохицуулж өгөх гэсэн юм.

Түүнээс биш тантай бол санал нэг байгаа. Тэгээд түүнээс биш тэр аккредитацийг нь энэ төрийн захиргааны байгууллага батална гэж бол байхгүй. Зүгээр хоорондоо та нар энийг заавал хий гэдгийг нь л хийх гээд байгаа юм. Тийм.

Г.Мөнхцэцэг: Нэмэлт тодруулга хариултыг 5 номерын микрофонд Боловсролын дэд сайд Ганбаяр.

Г.Ганбаяр: Учрал гишүүнээ энэ 9.7 гэдэг заалт бол тэр дүйцүүлэх үнэлэх тохиолдол бүрийг нь бол Боловсролын ерөнхий газарт хамаагүй. Энэ зөвхөн нэг удаагийнх нь журмыг л баталж өгөх гээд байгаа юм. Тэр эрхийг нь л Боловсролын ерөнхий газарт өгөөд, энэ харилцааг зохицуулсан журмыг л энэ заалтаар Боловсролын ерөнхий газар нэг удаа л журам батална. Тэр журмын дагуу сургууль хоорондоо дүйцүүлэх, шилжих тэр үйл ажиллагаагаа л явуулна л гэсэн ийм л ойлголт явж байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Санал хураалт, санал хураалтдаа оръё. Санал хураалт. Энэ санал 54.5 хувиар дэмжигдлээ.

20.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтын “байгууллага” гэсний өмнө “сургалтын гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.12, 10.1.13, 10.1.14, 10.2.7, 10.2.8 дахь заалт нэмэх.

“10.1.1.эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;

10.1.12.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш, боломж нөхцөлөөр хангагдах;

10.1.13.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон суралцагчийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, сорилд хамрагдахгүй байх;

10.1.14.ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах.

10.2.7.ерөнхий боловсролыг заавал эзэмших;

10.2.8.бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх; Санал хураалт. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

21.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмисэн мэдлэг, ур чадвар хандлагаа” гэснийг “чадамжаа” гэж, 10.1.6 дахь заалтын “төлөөллийн” гэснийг “өөрийн удирдлагын” гэж, 10.2.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилтэй холбоотой боловсролын байгууллага, багшаас тавьсан” гэснийг “багш, ажилтны” гэж, 10.2.4 дэх заалтын “багш, суралцагч, анги” гэснийг “багш, ажилтан, суралцагч,” гэж өөрчилж, мөн төслийн 10.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 10.2.1 дэх заалтын “хугацаанд нь бүрэн” гэснийг, 10.2.5 дахь заалтын “сургуулийн дотоод журам” гэснийг хасаж, мөн төслөөс 10.1.4, 10.1.10, 10.2.2 дахь заалтыг хасах. Санал хураалт. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

22.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “ерөнхий боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад” гэж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “нэн шаардлагатай”

гэснийг эрэлттэй” гэж, “тэтгэлэг” гэснийг “хөнгөлөлт, тэтгэлэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “зардлын дундаж нормативт “ гэснийг хасаж, 11.3, 11.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.3.Гадаад болон дотоодын мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.

11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно.” Санал хураалт. Энэ санал 63.6 хувиар дэмжигдлээ.

23.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “Хууль тогтоомжид” гэсний өмнө “Холбогдох” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 11.7 дахь хэсэг нэмэх.

“11.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат хэрэглэгдэхүүн, дэмжих үйлчилгээгээр хангагдана.” Санал хураалт. Саналаа. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

24.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

12.1.Багш, ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн

сонгон бүлэг ажиллуулж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ. Багш мэргэжлийн сонгон бүлэг ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.3.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, багш бэлтгэх хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандарт болон энэ хуулийн 5.1.4-д заасан тэгш хамруулан сургах зарчимд үндэслэсэн байна.

12.6.Багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон бусад хэлбэрийн дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Аймаг, сум, дүүргийн захиалга, эсхүл өөрөө хүсэлт гаргаж 3 буюу түүнээс дээш жил багш дутагдалтай боловсролын сургалтын байгууллагад багшийн мэргэжлээр ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.9.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, багш, мэргэжлийн бүлэг, судлаач, эрдэмтдийн оролцоотой зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системтэй байна.

12.20.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-д заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.9-д заасан сургуулийн түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөрөө зөвшөөрсний шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-д заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багшлах хүний нөөц хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.” Санал хураалт. Санал хураалтыг түр цуцалъя. Өчигдөр ажлын хэсэг дээр энэ заалтууд дээр бас найруулгын засвар хийхээр ингэж чиглэл өгсөн байгаа. Энэ найруулгууд бас ороогүй байна, ороогүй байна. Дамдинням гишүүн ажлын хэсэг, Учрал гишүүн саналаа хэлье.

Н.Учрал: Энэ хууль боловсруулах нэг техник гэж байна шүү дээ. Тэгэхээр тэр Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг манай Энх-Амгалан сайд ажлын хэсгийг ахалж батлуулсан. Тэгээд олон заалтууд ингээд давхцаад, агуулга нь ижилхэн юмнууд ороод ирчхэж байгаа юм. Яах вэ миний хувьд Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль дээр Боловсролын их сургуулийг багшийн мэргэжлээр төгссөн бол тусгай шаардлага тавихаа больё л гэдэг ийм өөрчлөлтийг хийсэн юм. Энд олон мянган багш нар баярладаг юм. Яагаад вэ гэхээр арай гэж нэг Боловсролын их сургуулийг сурган хүмүүжүүлэх ухаан 4 жил сураад төгсдөг. Төгсөөд гараад ирэхээр нь нөгөө уйтгартай хэдэн нөхдүүд ирж нэг баахан кредит цагийн төлбөр авч сургадаг. Нөгөө л заадгаа заадаг. Тэгээд дараа нь нэг сүртэй шалгалт авдаг. Тэгээд тусгай шаардлага тавьчихна. Багш олдохоо больчихсон шүү дээ юун шаардлага.

Багшийн мэргэжлээр яаж энэ боловсролын их сургуульд хэдэн хүүхэд оруулах вэ гэж зүдэрч байна шүү дээ. Улс орон даяараа. Цалин хөлс, нийгмийн баталгаа нь ийм бага юм чинь багш мэргэжлийг сонгохгүй биз дээ. Муу мэргэжил нь муудаа биш байхгүй юу. Цалин хөлс, нийгмийн баталгаандаа байна гээд байна шүү дээ. Тэгэхээр дахиж нэмээд тусгай шаардлага тавиад, шалгалт аваад. Хуульд өнөөдөр багш бэлтгэх их, дээд сургууль болон багш бэлтгэх хөтөлбөрт тавих тусгай шаардлагыг тусгаад, дээрээс нь баахан хөндлөнгийн үнэлгээ хийгээд, тэгээд суралцагчаас тэр нөгөө багшлах эрхийн шалгалтын нэгдсэн шалгалтыг хуульд заавал тавьж өгөөд. Үгүй ээ тэгээд ингэх тийм их шаардлага байгаа юм уу. Түүнийхээ оронд Боловсролынхоо их сургууль тэр багшийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулиудынхаа л чанар луу л анхаар л даа. Дахиад 4-ийн 4 жил үзчихээд гарч ирж байгаа шүү дээ.

Тэрнээс бусад их дээд сургуулийг өөр мэргэжлээр төгссөөд тэр нэг 2 сарын ч байна уу курст сураад багшийн сертификат аваад явж байгаа хүнтэй чинь 4-ийн 4 жил МУБИС-д багш гэдэг мэргэжлээр төгссөн хүн чинь шал өөр байхгүй юу. Би бас энэ сургуулийг төгссөн учраас би мэдээд байна л даа. Сурган хүмүүжүүлэх ухааныг 4-ийн 4 жил заалгаж сурчхаад дахиад гараад ирэхэд нь 2 сарын кредитийн төлбөр нэхэж байдаг. Тэгээд нэгдсэн шалгалт зохион байгуулж байдаг. Та хуульчлаад өгчихсөн. Баахан хөндлөнгийн үнэлгээ гээд ингээд тавьчихсан. Тэгээд одоо ингээд цаашаа багшийг яаж бэлтгэх юм бэ? Мэдээж салбарын сайд ч гэсэн энэ багшийнхаа мэргэжлийг дэмжье, хөгжлийг дэмжье гээд яриад байгаа. Гэхдээ яг өнөөдрийн нөхцөл байдалд бол багш мэргэжлээр л төгсөж байгаа бол заавал тэр тусгай шаардлага нэмж тавих шаардлага байхгүй шүү дээ. Тийм бол яг үнэхээр энэ дээр ингээд ийм тусгай шаардлага тавиад ийм зохицуулалт хийх гэж байгаа бол Багшийн хөгжлийг дэмжих тухай миний санаачилж, Энх-Амгалан сайдын ахалсан хуулиас тэр заалтуудыг нэг бүрчлэн хасах хэрэгтэй. Энэ хуулиас. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг дагуулж орж ирээд хасах ёстой. Тэгэхгүй бол би дахиад л хэрэгжилт дээр чинь санаа зовж байна шүү дээ. Та нар дахиад 2 хуультай болно шүү.

Нэг хуулийг нь харахаар тусгай шаардлагатай, нэг хуулийг нь харахаар нэгдсэн шалгалттай. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нь болохоор шалгалт байхгүй, тусгай шаардлага байхгүй багш мэргэжлээр төгссөн бол болно гэж. Үгүй энэ чинь магадлан итгэмжлэл багш чинь юу гэлээ Багшийг магадлан итгэмжилсэн хөтөлбөр бэлтгэнэ гэж. Угаасаа л магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрөөр бэлтгэх боломжгүй шүү дээ. Тэгэхээр ийм нөгөө салбарын сайдын түвшинд, Засгийн газрын түвшинд хийх бололцоотой ажлуудыг заавал ингэж нэг хууль дээр

нэг үг, үсэггүй оруулахаар боловсрол чинь өдөр бүр өөрчлөгдөж байхад ийм зүйлийг хууль нь хуульд оруулаад явах нь цаашидаа маш их хүндрэлтэй байдлыг бий болгоно л гэж би хэлэх гээд байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Өчигдөр уул нь бас ажлын хэсэг дээр ярьж байсан. Тийм ээ. Багшийг бэлтгэх багшийн хэрэгцээ бол шаардлага их өндөр байна. Энэ дээр бол онцгойлон анхаарах ёстой. Ялангуяа тэр Багшийн хөгжлийн тухай батлагдсан хуультай зөрчилдөхгүйгээр, дээрээс нь давахгүйгээр энэ хуулийн зохицуулалтуудыг бас хийх ёстой гээд ингээд найруулгын чанартай засваруудыг бас хийхээр өчигдөр ажлын хэсэг дээр ярьж байсан. Энэ заалтууд найруулгаар бас ороогүй байгаад байх шиг байна. Энэ дээр Энх-Амгалан сайд нэмж хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ үгүй, ийм байгаа юм. Одоо би бас Монгол Улсыг үргэлж нэг ийм эдийн засгийн хувьд чадавх тамир муутай, Монголын багш нарын ажлын байр бол ингээд өнөөдрийнх шиг ийм үнэлэмж муутай байна гэж ерөөсөө бодохгүй байгаа шүү дээ Учрал гишүүнээ. Бид нар энэ хууль бол би ирээдүйгээ харсан урт настай хууль байгаасай л гэж би бодож байгаа юм. Тэгэхээр одоо ингээд бид нар цаашидаа бол энэ боловсролын чанарыг дээшлүүлнэ гэх юм бол бид нар багш нарынхаа чанарыг дээшлүүлэхдээ л хамт энэ тогтолцоог хийж байж л бид нар цаашиа явна. Ер нь Кембридж гэдэг чинь та сайн мэдэж байгаа шүү дээ. Кембриджийн амин сүнс нь яг юу юм. Бид нар өнөөдөр төрийн өмчийн гуравхан сургуулийг Кембридж гэж зарлаад явах уу эсхүл төрийн өмчийнхөө 700 орчим сургуулиуд дээр тэр Кембриджийн элемент болсон багшийн хөгжлийн тасралтгүй хөгжлийн тогтолцоог ажлын байран дээр нь бий болгож байдаг нөгөө PDCQ гэж нөгөө professional qualification center билүү PDCQ гэж. Тэгэхээр энэ тогтолцоог бид нар ер нь хийж байж л ерөөсөө энэ

багшийн чанарын асуудлууд дээшлэх ёстой юм байна л гэдэг ийм юугаар 1 дүгээрт яаж байгаа.

2 дугаар асуудал бол бид нар цаашидаа ер нь энэ багш нарын багшлах эрхийн асуудлуудыг бол бид нар сэргээхээс өөр арга байхгүй. Өнөөдөр энэ ЕБС, энэ цэцэрлэг, сургуулиуд дээр яаж хүний эрх, хүүхдүүдийн эрх зөрчигдөж байна, ямар энэ сэтгэл эмзэглүүлсэн энэ үйл явдлууд гарч байна. Энэ чинь яг мэргэжлийн ёс зүйтэй холбоотой. Энэ асуудлуудыг бид нар өнөөдөр хөндөж тавих ийм цаг хугацаа нь болчихсон байхгүй юу. Тэгэхээр бид нар өнөөдөр Монгол Улс өнөөдөр багш нарын хомсдолд орчихсон байгаа, тэгээд юу гэдэг юм багшийг дураараа ажиллуулахын тулд дурын хүнийг багш болгохын тулд бид нар ерөөсөө энэ бүх багш болох гэж байгаа босгооч доошлуулаад тавьж байгаа, шаардлагаа ч доошлуулаад ингээд байх юм бол бид нар энэ Монгол Улсад яаж энэ боловсролын чанар дээшлэх юм бэ?

Ерөөсөө урьд нь бид нарын байдаг байсан хамгийн том давуу тал бол урьд нь хамгийн шилдгүүд нь багш болдог байсан шүү дээ, хамгийн шилдгүүд нь. Гэтэл өнөөдрийн энэ зах зээлийн 30 жилд бид нарын юу алдсан гэхээр тэр тогтолцоогоо өнөөдөр алдчихсан байж байгаа байхгүй юу. Тэгэхээр цаашаа бол бид нар энэ дуурайх гээд байгаа боловсролын чанарын чанарынх нь түвшинд хүрэх гээд байгаа тэр Финлянд, энэ Нордикийн энэ орнууд чинь ерөөсөө яг энэ загвараар л явж байна шүү дээ. Ер нь цаашидаа бол бид нар энэ багш нарын тавих шаардлагуудыг бид нар өндөрсгөх ёстой. Ахлах сургууль дээр бол би магистр зэрэглэлийн багш нар багшлуулж байж ингэж байж бид нар боловсролын чанар дээр ялгаа гаргах ёстой л гэж би ойлгоод байхгүй юу.

Тэрнээс биш юу гэдэг юм баахан тусгай зөвшөөрлүүдээр, баахан тусгай шаардлага тавиад ингээд одоогийн

байдлаасаа тийм хүнд суртал үүсгэж байгаа ийм хэлбэрүүд биш Учрал гишүүнээ. Би бас надад нэг Багшийн хөгжлийн тухай хуулийг та санаачилж, би бас Улсын Их Хурал дээр ажлын хэсгийг нь ахалж ажиллуулсан гишүүний хувьд, өнөөдөр энэ салбарыг удирдаж байгаа сайдын хувьд энэ 2 хуулийн хэрэгжилт заалтуудыг би бүгдийг нь харсан. Харин ч энэ нөгөө Багшийн хөгжлийн тухай хуулийг энэ хуультайгаа нэгтгэе гэж ярьж байгаад ямар ч байсан Багшийн хөгжлийнхөө хуультай улс орнууд цөөхөн учраас энэ дэвшил ололтоосоо ухраад яах вэ. Ямар ч байсан тусгайлсан энэ хуулиараа явъя.

Гэхдээ энэ хууль дотор тэр хууль Багшийн хөгжлийн хууль дотор чинь бол яг энэ өнөөдрийн энэ багшийн ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих энэ тогтолцооны асуудлууд чинь ерөөсөө хөндөгдсөн юм байхгүй байгаа байхгүй юу. Багш хөгжлийн төв гэдгийг бид нар ерөөсөө ганц танхим гэж ойлгоод байгаа байхгүй юу. Нөгөө хуучнаар багш нарын нөгөө танхим гэдэг шиг нэг ийм нөгөө нэг өрөө тасалгаа зохицуулчихаар л багш нар хөгжчих юм шиг, дэвшчих юм шиг гэж ойлгоод байхгүй юу. Гэтэл тэр Багш хөгжлийн төв гэдэг чинь яг тэр Кембриджийн тэр олон улсынхаа тогтолцоогоор бол багш л ажлын байран дээрээ тасралтгүй хөгждөг энэ тогтолцоонуудыг л бид нар бий болгоё.

Тийм ч учраас бид нар нөгөө Багшийн мэргэжил дээшлүүлэх институт гэдэг үеэ өнгөрөөсөн байгууллагуудыг татан буулгаж, энэ багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс олгож байгаа энэ сургалтуудыг яг багшийн өөрсдийнх нь хөгжил дэвшил тэр хэрэгцээ шаардлагад нь өгдөг энэ сургалтуудыг өгдөг энэ тогтолцоонд бол бид нар шилжүүлж байгаа шүү дээ. Тийм учраас би ухарсан зүйлийг одоо хиймээргүй байна. Ирээдүйгээ харсан ийм хууль баталмаар

байна. Ийм зохицуулалтууд хиймээр байна.

Г.Мөнхцэцэг: Дамдинням гишүүн ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя.

Г.Дамдинням: Би нэмж хариулахаасаа гадна бас нэг ажлын хэсэг дээр ярьсан юм. Энэ нэг найруулгын юм хийх ёстой болчихоод байна. Ер нь яах вэ Учрал гишүүний тэр шалгалт багийн, багшлах эрхийн шалгалт авдаг дахин ингээд чанаржуулах гээд байна гэдэг дээр Энх-Амгалан сайд тодорхой хариулт өгчих шиг боллоо. Багш бэлтгэх хөтөлбөрүүдийг магадлан итгэмжилнэ гээд их шаардлагагүй гэдэг юм бол бас байж болохгүй юм байна лээ Учрал гишүүнээ. Одоогийн байдлаар бол багш бэлтгэх хөтөлбөрүүд магадлан итгэмжлэл хангалттай хийхгүй байна. Ялангуяа тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сурган сэтгэл судлалын багшгүйгээр хийж байна, хэрэгжүүлээд явж байна одоо сургуулиуд. Тэгэхээр энийг зайлшгүй бүрэн хэмжээнд магадлан итгэмжлэх ёстой юм байна лээ. Тэгж байж бид нар багшаа чанаржуулж байж боловсролоо дээшлүүлнэ. Гэхдээ багийнхаа цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах замаар нэр хүндийг нь өсгөж байж явна гэдэг нь бол ойлгомжтой. Сая бол Энх-Амгалан сайд хэллээ.

2 дугаар юм бол энэ манай ажлын дэд хэсэг бас энэ дээрээ та хэд дахиад энэ найруулгын хувьд нь нэг хэдүүлээ ойлголцчихмоор байна. Энэ 12.13 дугаар зүйл байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн сургуулийн өмнөх ерөнхий боловсрол мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш удирдах ажилтныг өөрөө зөвшөөрсний дагуу шилжүүлэн ажиллуулж болно гээд. Энэ дээр бол ямар асуудал яриад байсан бэ гэхээр богино хугацаагаар бол өөрөөс нь өөртэй нь ярилцаж байгаад явуулчихъя, мэдээж өөрт нь дуулгана. Урт хугацаагаар бол өөртэй нь зөвшилцөж байж явуулъя

гэдэг ийм цогц асуултыг хийе. Энийгээ журамдаа тусгаад явъя гэдгээр оруулж ирээч гэж уг нь ажлын дэд хэсэгт хэлсэн юм сан.

Яагаад вэ гэвэл энэ, тэгэхдээ өөрийнх нь хамран сургах тойргийн хүрээнд. Өөрөөр хэлбэл Дархан-Уул аймгийн багш Дархан-Уул аймгийнхаа Боловсролын газрын хийх үүрэг нь бол Дархан-Уул аймгийн боловсролыг сайн байлгах ёстой. Тэгэхээр тэр аймгийнхаа нутаг дэвсгэр буюу хамран сургах тойргийнхоо хүрээнд өөрийнхөө хамаарлынхаа хүрээнд, хамаарал бүхий нутаг дэвсгэрийнхээ хүрээнд боловсролын бодлогыг жигд тэгш хэрэгжүүлж явах нь төрийн үүрэг байхгүй юу. Тэгэхээр манай Улаанбаатар хотод ч гэсэн байгаа. 11 дүгээр сургууль, 1 дүгээр сургууль бүгдээрээ онц сурлага юу математикийн сайн хүүхдүүд байдаг гээд бүгд ийшээ түгжрээд бүх хүүхдүүдээ энд авчраад байдаг. Захын хорооллын БЗД-ийн ч гэдэг юм уу, БЗД-ийн цаад талд эсвэл СХД-ийн цаана байгаа хүүхэд хүүхдүүдэд математикийн хамгийн сайн багш 1 дүгээр сургуулиас очоод нэг улиралд заачхаг л дээ. Энийг нь богино хугацаанд зөвшөөрдөг энэ боломжийг нь нээж өгье гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр та нар энэ найруулгыг нь энэ утгаар нь ойлгоод саналаа хураачихвал яасан юм бэ л гэж хэлэх гээд байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Учрал гишүүн тодруулах гэж байна уу? Тодруулъя.

Н.Учрал: Энэ 30 мянга гаруй багш нарын дунд хэлэлцүүлсэн хамгийн нэгээр гарч ирсэн санал юм байгаа юм. МУБИС болон багийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулийг төгссөн хүмүүс бусад сургуулийг төгсөөд 2 сарын хугацаанд сертификат аваад шалгалт өгснөөс илүү 4 жилийн боловсрол эзэмшсэн шүү. Сурган хүмүүжүүлэх ухааны. Тэр хүмүүсээс битгий тусгай шаардлага

аваач гээд байгаа юм. Ухралт хийх гээд байна шүү дээ бид нар ухралт.

Тэгээд ер нь яах вэ амьдрал бол их өөр байгаа шүү. Яг багш нарын дунд бол шал өөр нөхцөл байдал бол. Яах вэ бид ирээдүйг хараад ингээд хийнэ гээд. Үгүй ээ үгүй яаж дэмжихээ ярих ёстой болохоос биш яаж нэмж шаардлага тавихаа яриад яах вэ дээ одоо. Тэгэхээр энэ бол том дэвшил байсан энэ Багшийн хөгжлийн хуулийн. Тэгэхээр энийг бол хэзээ ч ухарч болохгүй.

Г.Мөнхцэцэг: Учрал гишүүний саналыг ер нь сонслоо. Тэгээд энэ нөгөө өчигдөр ажлын хэсэг дээр яриад байсан шүү дээ. Түрүүн ажлын хэсгийн ахлагч яриад байсан энэ хамран суралцах тойргийн хүрээнд гээд бас тодосгоод оруулаад ир гээд ингээд найруулгын чанартай засвар хийе гээд өчигдөр ярьсан. Энэ санал утга бол ороогүй байна гэж ингэж ойлгож байна. Энийг нэмж оруулна гэж ойлгоод ингээд энэ санал хураалт. Санал хураалт. Энэ санал 45.5 хувиар энэ чинь дэмжигдсэнгүй шүү дээ, уначихлаа. Энэ санал чинь ингээд бүтэн 12 дугаар зүйл. Энэ сая санал дэмжигдээгүй учраас энэ санал чинь бүр бүтэн 12 дугаар зүйлээрээ уначихлаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах хүн байна уу? Үгүй ээ тэгэхгүй бол зүйл дээр нь бид нар санал хурааж байгаа учраас. Санал гаргах хүн байна уу?

Учрал гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргая. Тэгээд энэ хэрвээ одоо ингээд энд санал дэмжигдэхгүй бол энэ чинь бүтэн зүйлээрээ ингээд багшийн хөгжлийн тогтолцоо чинь уначхаж байна. Тийм учраас тусгайлаад энэ зүйл заалтууд дээрээ заалт дээрээ найруулгын чанартай засвар хийгээд, Учрал гишүүн. Учрал гишүүний микрофоныг өгье.

Н.Учрал: Багшийн мэргэжлээр их дээд сургуулийг төгссөн хүн багшлах эрхтэй байна гэж Багшийн хөгжлийн дэмжих тухай хуульд заасан заалтыг л

яг тэр хуулийг мөрдмөөр байна л гэж байгаа шүү дээ. Тэгэхээр 12.6 дээр багш бэлтгэх хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид биш, тийм 12.7 дээр сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн болон сургалтын байгууллагын багш нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5 хүчинтэйгээр үлдэнэ гэж. 8.5-даа нийцүүлж санал хураая л гэж байгаа.

Г.Мөнхцэцэг: Дахин горимын санал гаргаж санал хураах шаардлагагүй юм байна. Дахиад шууд санал хураагаад явчих ийм боломжтой юм байна дэгээрэй. Тэгэхээр 12.7 дээр найруулгын засвар өөрчлөлт оруулахаар болж байна. 12.13 дээр мөн тэр өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан найруулгын засварыг нэмж оруулах шаардлагатай боллоо. Ингээд энэ 12 дугаар зүйлийг тэр чигт нь санал хураалт. Дахин санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ. Учрал гишүүн дэмжсэнийг протоколд бас оруулчхаарай. Ингээд 25. Дахиад хураах билүү? Энэ чинь бас 3 удаа, 3 дахь удаагаа бас санал хураах ёстой юм байна шүү дээ. Нэг унаад, нэг босчихсон тийм ээ? Дахиад энэ зүйл дээр дахиад санал хураалт. Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ. Дахиад тусад нь хураалгах юм уу?

Энд 12 дугаар зүйлийн 16 дээр тийм ээ. Учрал гишүүнээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирүүлсэн байгаа. Энийг хураалгачихъя. Эцэг, эх суралцагчийн хүсэлтэд үндэслэн ажлын бус цагаар бүх шатын багш нь нэмэлт орлого олж болно. Учрал гишүүн саналаа тайлбарлая.

Н.Учрал: Би энэ төрийн өмчийн сургуулиудад багшилж байгаа энэ ЕБС-д багшилж байгаа багш нарыг дэмжих л ийм л, зөвхөн төсвөөс санхүүжиж, цалин хөлсний урамшуулал авахаас илүүтэйгээр эцэг, эхчүүд нь ингэдэг юм байна ерөнхий боловсролын сургуулиуд дээр эцэг, эхчүүд нь сайн багшийг орой

ингээд гэрээр хичээл манай хүүхдэд 2 цаг зааж өгөөч, даалгаврыг нь хийлгэж өгөөч, хичээлийн бус цагаар гэрийн багшаар ажиллаач гэж хүсэлт тавьдаг юм байна. Тэгэхээр багш бол тухайн эцэг, эх нь өөрөө зөвшөөрөөд хүсэлт тавьсных нь үндсэн дээр цагийнхаа хөлсийг аваад ажлын бус цагаараа оройн цагаар ч юм уу гэрийн багшаар ажиллах бололцоог бид нар бол зүгээр нээж л өгөх ёстой. Тийм.

Тэгэхээр одоо болохоор энийг зөвшөөрдөггүй юм байна. Одоо болохоор ЕБС-ийн багш нарыг яадаг вэ гэхээр гадуур ингээд цагийн даалгавар өгөөд цагийн хичээл заагаад явахаар та нар өөр ажил хийлээ, давхар орлого олоо гээд ингээд хийлгэдэггүй гэж байгаа юм. Тийм учраас зүгээр хуулиараа зүгээр нэг ийм үндэслэл тавьчихъя. Эцэг, эх суралцагчийнх нь өөрсдийн хүсэлтэд үндэслээд бүх шатны багш нар нь ажлын бус цагаар нэмэлт орлого олж болно. Судалгаа хийж болж байна, тэр дадлагын ажлууд юмнуудыг нь удирдаж болж байна, бие даалтыг нь хийлгэж болж байна. Цагийн багшаар ажиллаж болж байна шүү дээ. Тэгэх юм бол төр заавал ингээд багш нарыг дэмжихээс илүүтэйгээр илүү их эрх чөлөө олгочих юм бол ажлынхаа бус цагаар багш нар маань ядаж бас цагийн багш хийгээсэй л гэж хүсэж байгаа юм. Тийм учраас хуулиар нь ингээд нээгээд өгье. Одоо бол нөхцөл байдал дээр бол багш нарыг зөвшөөрдөггүй, сургуулийн удирдлагууд нь чи ингээд давхар хуулиар зөвшөөрөгдөөгүй нэмэлт орлого олж болохгүй л гээд байдаг.

Их дээд сургуулиудын хувьд бол мэдээж нөгөө эрдэм шинжилгээний ажил удирдах, судалгааны ажил удирдах дээр нээлттэй. Ерөнхий боловсрол сургууль тэгддэггүй. Тэгээд дандаа нөгөө хуулийн гадуур нөгөө хүмүүс чинь яадаг вэ гэхээр зар тавиад л орой цагийн багш хийчихдэг. Тэгээд захирал удирдлагуудаа мэдэгдэхээсээ эмээдэг. Тэгэхээр үүнийг нь нээгээд л өгчихье л дөө. Ажлын бус

цагаар орой үдэш, амралтын өдрүүдээр нэг хүүхдийн хоцрогдлыг арилгахад хоорондоо л тохиролцсон бол бололцоотой байхгүй юу. Тэгэхээр ингээд нээгээд л өгчихвөл нөхцөл байдал бас илүү их өөрчлөгдөх бололцоотой.

Г.Мөнхцэцэг: Ойлголоо. Ингээд 12.16 бол саяын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр санал хураалт явуулъя. Саналаа хураачихъя. Санал хураалтыг цуцалъя. Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн үг хэлнэ, хариулт байна. Ц.Мөнхцэцэг гишүүн бас үг хэлнэ, асуулт тийм ээ.

Г.Дамдинням: Тэгэхээр манай Боловсролын ерөнхий хуулийн нэг бас нэг үндсэн концепц бий байгаа юм. Юу вэ гэхээр одоо манай ерөнхий боловсролын салбарт ялангуяа сургууль, цэцэрлэг, СӨБ-ын салбарт ажиллаж байгаа багш нарын ачаалал бол асар өндөр. Энэ нь сургахуйн үйлээсээ өөр захиргааны шинжтэй ажлууд асар их хийж байгаа. Судалгаа тооцоо цуглуулах, багшлах ажлаас өөр ажлууд асар ихээр хийгээд байгаа юм. Энийг нь хуулиар хатуу бид нар хорьж өгч байгаа энэ хуулиар. Нэмэлт ачаалал багшид үүрүүлэхийг хуулиар хориглоно. Одоо бол маш их тийм дарамттай, ачаалал өндөртэй орчинд ажилладаг гэсэн судалгаа ч байна, багш нартаа очоод хэлэлцүүлэг хийгээд уулзахад ч гэсэн ярь ярьдаг. Тэгэхээр бид нар бол энийг хуулиараа хорьж өгч байгаа юм.

Тэгэхдээ зүгээр яах вэ нэг болгоомжлол байна Учрал гишүүнээ. Ер нь бол одоо хуулиар бол хорьсон юм юу ч байхгүй. Багш бол ажлын бус цагаар юу хийх нь өөрийнх нь дурын асуудал. Гэхдээ хэрвээ энэ таны оруулж ирж байгаа шинэ заалтыг оруулчихвал ашиглаад бас нэмэлт ачаалал өгөөд байх асуудал гарах вий дээ. Сайн дурын гэдэг утгаар нь бол ажлын хэсгийн ахлагчийн хувьд татгалзаад байх зүйл бол алга.

Г.Мөнхцэцэг: Ц.Мөнхцэцэг гишүүн асуулт, санал.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ манай боловсролын хөтөлбөрийн дагуу багшийн бол танхимын цагийн ачаалал бас маш өндөр байгаа. Багш бол зөвхөн сургалтын танхимд хичээл заахаас гадна маш олон төрлийн ажил хийдэг. Бид нар энэ Боловсролын ерөнхий хууль хэлэлцүүлгийн явцад бол удаа дараа бас багш нартай хэлэлцүүлэг хийж, багшийн ачааллыг бодитой үнэлэх, багшийн ажлын байран дээр хөгжих асуудлаар төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг саналуудыг бол авсан.

Тэгэхээр зэрэг яах вэ Учрал гишүүн ингээд нөгөө багш ингээд ажлын бус цагаар ингээд чөлөөтэй мөнгө олох эсвэл сургалтын академик чөлөө хэрэгжүүлэх ажлуудыг дэмжье гэдэг санал оруулж байгааг ер нь бол зарчмын хувьд бол эсэргүүцэхгүй. Тэгэхдээ багш бол ерөөсөө яг бас үндсэн үйл ажиллагааныхаа дагуу суралцах сургалтын удирдлагыг эрхлэх үйл ажиллагаа явуулж түүндээ тохирсон хангалттай цалин хөлсийг төрөөс авах ёстой. Тийм учраас бид нар энэ төрийн үүрүүлэх ачааг багш нарт үүрүүлж, багш хичээлээс гадуур нэмэлт орлого олох нэрийдлээр илүү ачаалал үүрэхийг ер нь бол хуулиар нээж болохгүй юм байгаа юм.

Тийм учраас ерөөсөө төр бол боловсролын үүргийг бүх нийтэд үнэ төлбөргүй олгох энэ үүргээ хангалттай биелүүлж, төсвийн хөрөнгө оруулалтыг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх боловсролын санхүүжилтийг цаашдаа нэмэх шаардлагатай. Тийм учраас бид нар бол энэ заалтыг бол одоо байгаа энэ төслийнхөө хүрээнд явуулах нь зүйтэй болов уу. Ерөөсөө манай багш нар бол хангалттай өндөр ачаалалтай ажиллаж, гагцхүү түүндээ таарсан төсвийн хөрөнгө оруулалт, урамшуулал, цалин хөлсийг авахгүй байгаа. Тийм учраас төр өөрийн үүргээ илүү хүчтэй

хийж, багш нарын ачааллыг багасгах, багшийн ачаалалд нийцсэн энэ санхүүжилтийг олгох ёстой. Тийм учраас бид нар энэ үндсэн төслөөрөө явах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Г.Мөнхцэцэг: Санал хураалт 12.16 дугаар санал хураалт. Энэ санал 63.6 хувиар дэмжигдлээ.

25.Төслийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.11 дэх заалт нэмэх.

“13.1.11.цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах.” мэргэжлийн хөгжлийн орчин нөхцөлөөр хангагдах гэж юу вэ? Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

26.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “албан тушаалын тодорхойлолтод” гэснийг “хууль тогтоомжид” гэж, “ажлын үр дүн, гүйцэтгэлд” гэснийг “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ” гэж, 13.2.7 дахь заалтын “эрхэмлэн, ажил амьдрал үйл ажиллагаагаараа үлгэрлэх” гэснийг “эрхэмлэх” гэж, 13.2.9 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийг” гэснийг “цахим технологи, хэрэглэгдэхүүнийг” гэж, мөн заалтын “платформыг” гэснийг “цахим системийг” гэж, 13.2.10 дахь заалтын “багшийн мэргэжлээ дээшлүүлэх” гэснийг “ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж” гэж, 13.2.3 дахь заалтын “мэдлэг, чадвар, дадлыг” гэснийг “чадамжийг” гэж, 13.2.11 дэх заалтын “цэцэрлэг, сургуулийн” гэснийг “сургалтын” гэж, 13.3.3, 13.3.15 дахь заалтын “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 13.3.4 дэх заалтын “дэмжлэг үзүүлэх” гэснийг “ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 3.3.5 дахь заалтын “сургуулийн

захирал” гэснийг “ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал” гэж, 13.3.6 дахь заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, 13.3.5 дахь заалтын “5” гэснийг “эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь” гэж, 13.5 дахь хэсгийн “бүх шатны” гэснийг “бүх түвшний” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2, 13.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.2.суралцагчийн ялгаатай хэрэгцээ, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх;

13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх; Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Ундрам гишүүнд асуулт байна. Ундрам гишүүн асуулт асууя. Ундрам гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундрам: Энэ Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл бол маш чухал хэсэг байгаа юм. Багшийн эрх, үүрэг багш ажилтны нийгмийн баталгаа гээд өнөөдөр манай боловсролын салбарт сайн багш нар үлдэх, энэ мэргэжлийг сонгоход хамгийн их эергээр нөлөөлж болохуйц заалтууд энд орсон байгаад байгаа юм. Тэгээд энэний энэ 13.3.6 дээр төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын багш ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох гээд 36 сарын буцалтгүй тусламж олгодог энэ заалт байгаа юм. Тэгээд манай хуучин энэ боловсролын одоо яг хэрэгжиж байгаа хууль дээр болохоор их сургуулийн багш нар энд ерөөсөө хамрагддаггүй. Яагаад

гэвэл их сургуулиуд нь өөрөө аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар гээд ийм статустай байгаад байдаг.

Тэгэхээр энэ 13 дугаар зүйл заалтад бүх шатын буюу ЕБС, СӨБ, МСҮТ их сургуулиуд төрийн өмчийн болон орон нутгийн өмчийнх бүгдээрээ хамрагдах уу, үгүй юү гэдэг дээр бас манай ажлын хэсэг нэлээн сайн анхаарах ёстой гэж бодоод байна. Тэгэхээр энд яг хамрагдах уу, үгүй юү гэдгийг бас асуумаар байна?

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн гишүүн асуулт асуугаад байдаг. Тийм. Дэд ажлын хэсэг дээр тэгэх үү? Ер нь бол санал та бол хэлчихсэн байгаа шүү дээ, өгчихсөн байгаад байгаа тийм ээ. Энх-Амгалан сайд нэмэлт тодруулга өгье.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ яах вэ энэ төрийн өмчит их дээд сургуулиудтай л хамааралтай л заалтууд л даа. Бусдууд нь бол угаасаа тэр одоо явж байгаа хуулиудаараа зохицуулчхаж байгаа юм. Тэгээд яах вэ энэ чинь саяхныг хүртэл бол ерөнхийдөө нөгөө их дээд сургуулийн санхүүжилтийг төрөөс хийж явж байсан нөгөө урсгал зардлуудыг санхүүжилт хийж явж байсан үед бол энэ зохицуулалт байсан. Тэгээд төрөөс хийхээс больсноос хойш ингээд нөгөө яг их дээд сургуулиуд чинь төрийн өмчтэй мөртөө яг нөгөө юунууд нь зохицуулалтууд нь тэнд ажиллаж байгаа багш нар, ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудад бол яг нөгөө нэг бусад боловсролын байгууллагад олгогддог энэ тэтгэвэрт гарахдаа авдаг нэг удаагийн тэтгэлэг байхгүй болчихсон нэг ийм л зохицуулалт л даа.

Яах вэ энийг тэгээд бид нар яаж болно шүү дээ. Яг ажлын хэсэг дээрээ ажиллаад, тэгээд санал хураалгаад энэ. Тэгэхдээ миний ойлгож байгаагаар бол энэ төрийн болон төрийн өмчийн боловсролын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай

хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох гээд ингээд орчихсон. Энэ бол олгохгүй гэсэн үг байхгүй, үг биш байхгүй юу, энэ чинь байгаа байхгүй юу энэ дотроо ороод явж, нэг ойлгогдоно. Тийм.

Г.Мөнхцэцэг: Тийм энэ заалт дээр дээд сургуульд бол өгөхгүй гэж байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр харин ажлын хэсгийн ахлагч ажлын хэсэг дээр юу гэж ярьсныг тийм. Дамдинням гишүүн нэмэлт хариулт тодруулга өгье.

Г.Дамдинням: Энэ дээр маш тодорхой заалт оруулж байгаа. Их дээд сургуулиуд дээр бол их дээд сургууль өөрөө орлогоо олно, төрөөс бол дэмждэг асуудлыг бол Дээд боловсролын хууль дээр бид нар оруулж ирье гэж ярьж байгаа. Тэгэхээр энэ ерөнхий хууль учраас бид нар 13.3.7 гэдэг заалтаар дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох гээд үүрэг болгоод заачихсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл тухайн байгууллага нь өөрөө төсөвтөө суулгаад явах эрх зүйн зохицуулалтыг нь хийгээд өгчхөж байна гэсэн үг. Тухайн байгууллага өөрөө энэ зардлаа тооцоод явна л гэсэн үг. Хөдөлмөрийн гэрээнийхээ дагуу. Тэгээд ингээд хийчхэж байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Ажлын дэд хэсгийн ахлагч Ганбаяр дэд сайд нэмэлт тодруулгад хариулт өгчих.

Г.Ганбаяр: Ундрам гишүүний асуултад тодруулъя. Энэ нөгөө төрийн өмчийн ер нь их дээд сургуулиуд дээр 36 сар гээд заачихъя гэхээр төрийн өмчийн сургуулиудын цалингийн бүтэц нь төрийн албанаас хамаагүй өндөр байгаа буюу өөрсдөө тогтоож байгаа юм. Тэгэхээр 36 сараар олгоно гэхээр сургууль өөрөө эдийн засгийн хувьд, санхүүгийн хувьд боломжгүй гээд. Бид нар их дээд

сургуулиудын удирдлагуудтай санхүүжилттэй энэ төслийг ярьж байхдаа бол тэтгэмж бол олгоно. Тэгэхдээ тухайн байгууллага олгоно гэдгээр ийм байдлаар л томъёолол оруулсан. Тэтгэвэртээ гарахдаа бол тодорхой хэмжээний мөнгөн тэтгэмжээ бол авна. Тэгэхдээ тэрийг хэмжээг нь сургууль нь өөрөө ажил олгогч өөрөө л тогтооно. Яагаад гэхээр тэр их дээд сургуулиуд дээр багш авч байгаа багш нарын цалингийн шатлал бүтэц нь төрийн албанаас хамаагүй өндөр байгаа учраас.

Г.Мөнхцэцэг: Хариулт ойлгомжтой байх тийм ээ. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

27.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, “саад учруулах” гэсний өмнө “зориуд” гэж нэмж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9, 13.10, 13.11 дэх хэсэг нэмэх.

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш,

ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшийг хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.”

13.10.Багшийн үндэс нь энэ чинь нээрээ энэ ажлын хэсгийн ахлагчаас энэ 13.10 13.11 дээр саналыг татаж байгаа. Тийм ээ. Энэ 13.10, 13.11 дээр нэмэгдсэн энэ саналыг ажлын хэсгийн ахлагч тайлбарлаад татаж байгаа шалтгаанаа бас хэлчих үү?

Г.Дамдинням: Манай ажлын хэсгээс уг нь бол санал хураагаад, багшийн цалинтай холбоотой, багшийн тэтгэврийн настай холбоотой маш чухал ийм заалтыг оруулж ирсэн юм. Тэгээд ер нь бол бид нар Монголын боловсролыг аврах, Монголын боловсролыг өөд нь гаргах, эх орныхоо ирээдүйг гэрэл гэгээтэй харъя гэвэл багшаа л дэмжих ёстой. Багшийн цалин хамгийн өндөр байх ёстой, багшийн нийгмийн баталгаа хамгийн сайн байх ёстой. Энэ утгаараа бид нар энэ цалин урамшуулалтай холбоотой тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой заалтуудыг оруулж ирсэн юм.

Тэгээд яах вэ УАБЗ-ийн зөвлөмж, ЗГ-аас гаргаж байгаа бодлогын хүрээнд бид нарт бас хүсэлт тавьсан. Юу вэ

гэхээр аливаа тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой, цалин урамшуулалтай холбоотой асуудлыг салбарын хуулиар шийдэж болохгүй. Нэгдсэн хууль зохион байгуулалттайгаар хийх нь зүйтэй юм гэсэн одоо бас энэ зарчим нь зөв ингэж санал гаргаад байгаа учраас бид энэ 13.10, 13.11 гэсэн энэ 2 төслийн заалтаа татан авч байна. Тийм.

Г.Мөнхцэцэг: Энэ 13 дугаар зүйл дээр Чинбүрэн гишүүн тодруулга асуулттай байна. Чинбүрэн гишүүний микрофоныг өгье.

Ж.Чинбүрэн: Ажлын хэсгээс нэг зүйлийг л асуух гэсэн юм. 13.2.11-тэй холбоотой энэ хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчигдөж байгаа зүйл байна уу? Тэрэндээ нэг тодруулж хариулт хэлж өгөөч? Бид чинь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй юмаа заасан байдаг. Тэгээд энэ дээр энэ ингээд орчхоод байгаа юу, үгүй юү? Яаж уншигдаж байгаа вэ? Тодруулж асууя.

Г.Мөнхцэцэг: 13-ын 13.2.11 дэх тэр ажил хаялт эрхийг хүний эрхийг зөрчих, суралцагчийн эрхийг зөрчих гэсэн хэсэг дээр нэмэлт тодруулга асуулт асууж байна Чинбүрэн гишүүн. Ажлын дэд хэсгийн ахлагч дэд сайд Ганбаяр тодруулга хариулт өгье.

Г.Ганбаяр: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ 13.2.11 гэдэг заалт хуулиар олгогдсон хүний үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвсэн нэгдэх, жагсаж цуглах эрхэд бол халдаагүй. Харин суралцагчийн эрхийг зөрчиж байгаа, хичээл сургалтын үйл ажиллагаа тасалдуулж байгаа ямар нэг ийм үйл ажиллагааг л бид нар илүү тодотгож, ийм үйл ажиллагааг хэрвээ үүсгэх юм бол хуулиар хориглосон ийм заалтыг оруулж байгаа юм. Ийм тохиолдлууд бол амьдрал дээр сүүлийн үед нэлээн ихсэх

ийм хандлагатай байна. Сургууль дотор, сургуулийн удирдлага томилгоотой холбоотой гэдэг юм уу, ямар нэгэн байдлаар суралцагчийн сурах явцад саад учруулж байгаа ийм үйл ажиллагаанууд гараад байгаа учраас Боловсролын хуульд суралцах эрхийг хөндсөн тохиолдолд бол хориглоно гэдэг ийм асуудлыг оруулж ирж байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Чинбүрэн гишүүн асуулт хариулт хангалттай юу? Чинбүрэн гишүүн хариулт асуулт тодруулга асуулт тавья гэж байна. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Ганбаяр дэд сайдын хариулт бол тийм оновчтой би санагдахгүй байна. Тэр сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг чинь үйлдвэрчний эвлэлээрээ дамжуулаад үг хэлэх, жагсаал цуглаан тайван жагсаал цуглаан хийх бүрэн эрх нь байгаа шүү дээ. Тэгээд хичээлийг нь тасалдуулаа гэдэг тайлбараар үг хэлэх эрхийг нь хорино гэдэг чинь өөрөө харин буруу байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ 13.2.11-д заавал ийм заалт орох хэрэг байгаа юм уу? Энэ чинь нөгөө жагсаал цуглаан бусад зүйлээрээ явчхаж болдоггүй юм уу? Энэ дээр бол бүр яг салбарын Энх-Амгалан сайд та одоо бол ерөөсөө яг ингээд салбарын ажилчдаа үг хэлэх эрхгүй болгож байна л гэдэг. Тэгээд танд тайлбар олдоно шүү дээ. Хичээл хийлгэхгүй та нар ажлаа хаялаа л гэдэг ийм тайлбар очно шүү дээ. Тэгэхээр энэ чинь хэр оновчтой зөв байх юм бэ?

Г.Мөнхцэцэг: Энэ, Энх-Амгалан сайд тодруулж хариулъя.

Л.Энх-Амгалан: Иргэнийхээ хувьд Үндсэн хуулиар олгогдсон энэ эрхүүд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх энэ бүх эрхүүд нь мэдээж бид нар нэг салбарын хуулиар хааж болохгүй шүү дээ. Ойлгомжтой. Хамгийн гол юу бол энэ чинь Үндсэн хууль. Тэгэхээр Үндсэн

хууль тэгээд Хөдөлмөрийн хууль энэ Хөдөлмөрийн хуулиар энэ ажил хаялтуудыг чинь зохицуулдаг хөдөлмөрийн юу үйлдвэрчний эвлэлтэй холбоотой асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг учраас яг одоо ингээд энэ өнөөдрийн хэлэлцүүлж байгаа энэ хуулиар Үндсэн хуулиар олгогдсон ирэх болон Хөдөлмөрийн хууль дээр хийсэн зохицуулалттай холбоотой юунаас бол муутгасан тийм зүйл байхгүй гэдгийг би хариуцлагатайгаар хэлье Чинбүрэн гишүүнээ.

Г.Мөнхцэцэг: Санал хураалтад орёе. Төслийн 13 дугаар зүйл дээр 13.9 хүртэл ингээд зүйлүүд дээр санал хураалт явуулна. 13.10, 13.11 дээр ажлын хэсгийн ахлагч саналаа татсан учраас санал хураалтыг 13 дугаар зүйл дээр явуулъя. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

28.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, 13.1.7, 13.2.13, 13.3.1, 13.3.2 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 13.1.8 дахь заалтын “нийгмийн сайн сайхны төлөө” гэснийг, 13.2.3 дахь заалтын “суралцагчийг идэвхжүүлсэн сургалтын арга зүйг сургалтад ашиглах,” гэснийг хасах. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

29.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 дэх заалтын “хэл зохиол” гэснийг “монгол хэл, уран зохиол” гэж, 14.4.4 дэх хэсгийн “ёс зүйн” гэснийг “ёс зүйн болон зан төлөвийн” гэж, “14.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын” гэж, 14.3 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол болон” гэснийг “мэргэжлийн болон техникийн,” гэж, “нарийвчилсан харилцааг” гэснийг “харилцааг” гэж, 14.5, 14.9 дэх хэсгийн “шатны” гэснийг “түвшиний” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.4, 14.6, 14.7, 14.8 дахь хэсэг, 14.4.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.4.Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын сургалтын байгууллага хэрэгжүүлнэ:

14.4.6.хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;

14.6.Гадаад улсад монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, боловсрол нөхөн эзэмших сургалт зохион байгуулах, Монгол хүний хөгжлийг дэмжих зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг байгуулж болно.

14.7.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулгын мөрдөх хугацаа нь батлагдсанаас хойш ерөнхий боловсрол эзэмшүүлэх хугацаагаар тогтвортой байна.

14.8.Цахим сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 14.2-т заасан хөтөлбөрт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлнэ.” Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ. Дамдинням гишүүний техник ажилласангүй протоколд дэмжсэнээр оруулаарай.

30.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Боловсролын сургалтын байгууллага нь” гэж, 14.4.3 дахь заалтын “жендэрийн” гэсний өмнө “хүний эрхийн боловсрол,” гэж, 14.4.9 дэх заалтын “сэргийлэх” гэсний дараа “талаар” гэж, 14.9 дэх хэсгийн “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж нэмэх. Санал хураалт. Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ.

31.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “албан боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмэх.

“15.3.Албан бус боловсролын сургалтыг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага бүртгэж, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.” Санал хураалт. Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ.

32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “багшийн” гэснийг “эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

33.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмэх.

“16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дадлага сургалтад хөгжлийн бэрхиээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.” Санал хураалт. Энэ санал хураалт 90.9 хувиар дэмжигдлээ.

34.Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА” гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь

боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллага нь боловсрол судлалын ёс зүйн хороо, боловсролын сургалтын байгууллага, ажил олгогчийн түншлэл хамтын ажиллагааг хариуцсан төвтэй байна.

17.4.1.энэ хуулийн 17.4-д заасан ёс зүйн хороо орон тооны бус байх бөгөөд ажлын албатай байна. Ёс зүйн хорооны ажлын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

17.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг шалгах, турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.5.1.энэ хуулийн 17.4-д заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас тохирц, нийцлийг шалгах, турших үед сонгосон цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх;

17.6.Насан туршийн суралцахуйн төв нь хүний насан туршийн суралцахуйг чиглүүлэх, түгээн дэлгэрүүлж, дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.6.1.энэ хуулийн 17.6-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах;

17.6.2.эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг энэ хуулийн 17.6-д заасан байгууллага, эсхүл төрийн бус байгууллага гэрээгээр гүйцэтгэж болох бөгөөд шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

17.6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших, тасралтгүй сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллуулж болно.

17.6.4.Дэмжих төвийн хүний нөөц болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

17.6.5.энэ хуулийн 17.6-д заасан төв нь сургалт, үйлчилгээний хамрах чиглэлээс хамаарч салбар дундын санхүүжилттэй байх;

17.7.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.8.Энэ хуулийн 17.8-д заасан үнэлгээ болон элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.9.Боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага нь сургалтын

байгууллага болон хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

17.10. Энэ хуулийн 17.9-д заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсын магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, дүйцүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

17.11. Энэ хуулийн 17.9-д заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” Санал хураалт. Энэ зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна. Нэрсээ өгье. Учрал гишүүн асуултаа асууя. Асуулт санал нэг байна. Санал тусдаа.

Н.Учрал: Энэ 19 дүгээр зүйлийг хасаж байгаа юм байна тийм ээ Дамдинням гишүүнээ? Би тэгж ойлгож байна шүү дээ. 19 дүгээр зүйлийг бүхэлд нь хасаад 17 дээр нэгтгээд оруулчхаж байгаа юм байна мөн үү? Би бас хууль санаачлагчаас, ажлын хэсгээс бас асуумаар байна. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага гэж яг ямар байгууллага хэлээд байна вэ? Энэ олон байгууллагуудыг яг учрыг нь сайн олохгүй байна.

Дээрээс нь Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын дэргэд Ёс зүйн хороо ажиллана гэж. Судалгаа юу гэсэн бэ, судалгааны ёс зүйн хороо гэсэн үү? Нэг тийм ёс зүйн хороо байх юм байна. Тэгэхээр Боловсрол, арга зүйн байгууллагын дэргэд судалгааны ёс зүйн хороо байна гэж юу гэсэн үг юм бэ? Одоо бас нэг ёс зүйн хороо гарч ирж байгаа. Тэгэхээр наад яг энэ байгууллага чинь яг юу хийх юм бэ гэдэг асуулт байна.

2-т боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага нь бүх шатны байгууллагыг сургалт арга зүйгээр хангана гээд байгаа юм. Үгүй ээ тэгээд энэ чинь нөгөө их дээд сургуулиудын академик эрх чөлөө байхгүй болчхож байгаа юм уу? Энэ чинь МУИС ч гэсэн өөрөө академик эрх чөлөөтэй шүү дээ. Тэгээд яахаараа тэр төрийн захиргааны байгууллага юм уу, юу юм нэг эрдэм шинжилгээний сургалт арга зүйн байгууллага гэдэг нэг байгууллага гарч ирээд дэргэдээ бүр Ёс зүйн хороо байгуулаад, тэгээд бүр бүх шатын байгууллагыг сургалт, арга зүйгээр хангана гэххэж байгаа юм. Тэгээд чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага нь магадлан итгэмжилнэ. Үнэлгээний төв гээд байгаа нь бол мэдээж нөгөө элсэлтийн шалгалт зохион байгуулж байгаа нь байх л даа. Тэгээд Насан туршийн боловсрол нь ерөнхий газрынхаа доор гээд. Энэ нэг олон байгууллагынхаа нэг учир утгыг жоохон ярьж өгөхгүй бол энэ олон байгууллагыг үнэхээр ойлгохоо болилоо.

Судалгааны ёс зүйн хороо гэж байхгүй шүү нөхөд өө. Судалгааны ёс зүйн хороо. Ер нь та нар өөрсдөө энэ ажлын хэсэг ер нь юу ойлгож байна вэ? Хууль батлагдана. Та нар тэгээд хэн юу хийхээ ер нь мэдэж байна уу? Та нар өөрсдөө нэг хариулаач. Юун дээр гацаа гаргах гээд байгаа юм гээд. Тэгэхгүй бол ингээд Их Хурал дээр бол яах вэ ингээд ярьж байна. Батлаад явуулчихдаг. Яг амьдрал дээр энэ чинь их төвөгтэй байхгүй юу. Хууль хэрэгжихэд. Тэгээд

Дамдинням гишүүнээ та энийг л анхаар, 19 дүгээр зүйлийг чинь хассан чинь их сайн байна. Тэгээд их сайн ажил болсон байна шүү дээ. 19 зүйлээр бүр нэг байгууллагын эрх мэдлийг тавьж өгснийг хасчихсан юм байна. Гэхдээ Боловсролын эрдэм шинжилгээний арга зүйн байгууллага гэж юу ямар байгууллагыг хэлээд байгаа юм, юу гэж ойлгож ажлын хэсэг ажилласан юм бэ?

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн. Тийм асуултад хариулъя. Дээр нь нэмээд.

Г.Дамдинням: Би тэр Ёс зүйн хороотой холбоотой хэсэг дээр нь хариулъя. Ер нь бол дэлхийн шинжлэх ухааныг үнэлдэг өндөр хөгжилтэй орнуудад их сургуулиудын дунд, судалгаа шинжилгээний байгууллагуудын дунд хуулалтын эсрэг ажилладаг судалгааны арга зүйг нь хянадаг ёс зүйн ийм оффис байдаг. Байдаггүй биш байдаг. Жишээ нь Канад улс, Америк улс жишээ нь хэрвээ тухайн оюутан хулгай оюуны хулгай хийсэн байгаа нь Ёс зүйн хороогоор батлагдах юм бол сургуулиас нь хөөгөөд зогсохгүй тухайн улсад оруулахгүй насан туршийн banн-даг. Өөрөөр хэлбэл визийг нь цуцлаад, хөөгөөд гаргачихдаг. Манай улсад жалгаар нэг доктор, жалгаар нэг судлаач, жалгаар нэг эрдэмтэн гарч ирчхээд байна. Хэн нь хэнийхээ юмыг хуулаад, хэн нь хэнийхээ юмыг нийтэд ингээд ашиглаад яваад байгаа нь мэдэгддэггүй. Зөндөө л юм яригддаг.

Тэгэхээр бид нар Монголын шинжлэх ухааныг, Монголын их дээд сургуулиудын судалгааг сайжруулъя л гэж бодож байгаа бол энэ эрх зүйн зохицуулалтыг бид нар зайлиггүй хийх ёстой. Японд ч байдаг, энэ өндөр хөгжилтэй орнууд бүгдэд нь байдаг юм. Их сургуулиудад өөрсдөд нь байдаг юм. Би бол өөрөө энэ Ёс зүйн хороогоор орж байж бас судалгаагаа хамгаалж л байсан, байдаг. Энэ бол манайд хэрэгтэй байгаа. Бидний судалгаа сайжрах ёстой, хуулалтыг зогсоох ёстой.

Г.Мөнхцэцэг: Тэр ёс зүйн хороотой хэсэг дээр нь Боловсролын сайд хариулаарай. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Хэн Учрал гишүүнээ тэгээд Учрал гишүүнээ гарах гээд байна уу, сонсох гээд байна уу? Тэгээд асуулт асуучаад тэгээд яах юм? Тэгэхээр яах вэ энэ хуулиар энэ Боловсролын энэ ерөнхий хуулиар бид нар энэ боловсролынхоо байгууллагуудын чадавхжуулах, үндэсний чадавхыг бий болгоход л нэг тодорхой дэвшил гаргая, эрх зүйн дэвшил гаргая л гэж бид нар бүгдээрээ зорьж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бид нар энэ Боловсролын Үндэсний Хүрээлэнг энэ дээр боловсролын үндсэн хүрээлэн байхгүй юу энэ чинь нэг таны асуугаад байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт бол магадлан итгэмжлэхийг бол дан ганц нэг ийм төрийн ч юм шиг, төрийн ч бус юм шиг нэг ийм сонин явж ирсэн. Энийг бол бас тодорхой статусынх нь хувьд бэхжүүлж байгаа. Ганцхан одоо ингээд нэг ийм магадлан итгэмжлэл хийх гэж байгаа сургуулиасаа мөнгө авчхаад л магадлан итгэмжлэх хийж байна гээд ингээд суугаад байж ерөөсөө болохгүй шүү дээ. Энэ тохиолдолд бол бид нар энэ боловсролын чанар баталгаажуулалтын асуудлыг ярих үндсэндээ бололцоогүй. Тийм учраас бид нар энэ магадлан итгэмжлэх байгууллагаа чадавхжуулах ганцхан магадлал хөтөлбөрийн магадлан итгэмжлэл биш цаашидаа мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийнхээ асуудлууд, 3 дугаарт нь бол энэ олон улсад олон улсын нөгөө дипломын хооронд нь хүлээн зөвшөөрүүлэх энэ мэдээллийн сан байгуулах гээд чиг үүргүүдийг нь бид нар нэлээн өргөжүүлж бэхжүүлэх чиглэлээр нь нэлээн эрх эрхийг нь нэлээн нээж өгч байна гэж ойлгож болно.

3 дугаар асуудал бол бид нар энэ боловсролын үнэлгээнийхээ төвийг

ганцхан ЕЭШ зохион байгуулдаг гэж ойлгож болохгүй. Энэ бол жаахан үе өнгөрөөсөн ойлголт байна. Цаашидаа бид нар энэ боловсролын чанарын асуудал бол үндэснийхээ үнэлгээний тогтолцоог бид нар бэхжүүлэх асуудал байгаа юм. Тийм учраас бол бид нар энэ Боловсролын үнэлгээний төвөө ганцхан ЕЭШ зохион байгуулдаг биш, ерөөсөө бүх шатын боловсролын чанарын болон ахиц дэвшлийн үнэлгээнүүд хийдэг энэ үндэсний чадавхуудыг бий болгох энэ боломжуудыг л олгож байгаа гэж ойлгож болно.

Г.Мөнхцэцэг: Харин тийм, тэр бас томъёолохдоо байна шүү дээ. Боловсролын үндэсний хүрээлэн гэдгээр нь ойлгуулаад тэгж томъёололд оруулбал тайлбарлаад явбал тийм. Ерөнхийд нь бол бас тийм том яг нэршлийг нь бас зөв томъёолоод оруулбал зүгээр юм байна гээд. Санал хураалтдаа оръё. Санал хураалт саяын зүйл дээр санал хураалт. 34 дүгээр саналын хураалт явуулж байна. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

35.Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 18.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.4.Боловсролын сургалтын байгууллага нь төрийн, орон нутгийн өмчийн, хувийн болон холимог өмчийн хэлбэртэй байна.” Санал хураалт. Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

36.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их,” гэж, 18.3, 18.5, 18.6 дахь хэсгийн “Боловсролын байгууллага” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “зорилгодоо” гэснийг “чиг үүрэгт” гэж өөрчилж, тус зүйлд доор

дурдсан агуулгатай 18.3.1 дэх заалт, 18.8, 18.9 дэх хэсэг шинээр нэмэх.

“18.3.1.ашигийн төлөө, ашигийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-т заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

18.8.Боловсролын цахим сургалтын байгууллагыг эрх бүхий байгууллагаас баталсан шаардлагын дагуу байгуулж болно.

18.9.Гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоод, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид тайлагнана.” Дэмжигчид тайлагна. Энэ дээр Ундрам гишүүн, Мөнхцэцэг гишүүдийн нэрсийг оруулаад, үг хэлнэ. Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Яг энэ 18.3-тай холбоотой асуудлыг үндсэндээ бараг 2, 3 жил бид нар ярьж явж байгаа. Тэгээд ерөнхийдөө бид нар хэлэлцүүлгүүд ч зохион байгуулсан, хувийн сургуулиудтайгаа ч уулзсан. Ер нь бол бид нар боловсролоор ер нь ашиг хийх нь буруу. Цаашид бид нар урт хугацаандаа нэлээн урт хугацаандаа хүүхэд болгонд амьдралын тэгш гарааны боломжийг олгохын тулд мэдээж маш сайн орчин нөхцөлтэй, сайн хөтөлбөртэй, сайн сурах бичигтэй тийм улсын сургуулиуд Финлянд улс шиг ингэж явах юм бол зөв гэдэг энэ урт хугацааны чиг баримжаагаа бол бид нар мэдээж байгаа гэж үзэж байна. Одоо мэдээж өнгөрсөн хугацаанд улсын төрийн энэ хүүхэд сургах тодорхой ачааг хувийн сургуулиуд бас үүрээд ирснийг бол огт үгүйсгээгүй.

Гэхдээ яг өнөөдрийн бид нарын энэ бий болсон байгаа нөхцөл байдалд хувийн сургуулиуд байгаа учраас хүүхдүүд маань амьдралын тэгш гарааны нөхцөлтэй байж чадахгүй байна. Нэг хэсэг нь бол англи хэлтэй сайн хөтөлбөр мөнгөөр авчраад цалинжуулаад ажиллуулж байгаа хамгийн сайн багш, сайн орчин хангагдаад, тэгээд хамаагүй сайн их сургууль гадаадын ИҮҮ-гийн их сургуулиуд орох боломжууд нь шууд хангагдчихаад байна. Нэг хэсэг нь бол огт хангагдахгүй байна. Тэр захын хорооллуудаар байгаа, тэр хязгаарын сумдад байгаа хилийн цэргийн хүүхдүүдэд гэхэд энэ нь огт хангагдахгүй байгаа учраас ерөөсөө манай энэ одоогийн боловсролын тогтолцоо хүүхдүүдэд ялгаатай хандаж байна гэдэг энэ асуудлыг маш олон сар, жилийн хугацаанд энэ асуудлыг тавьж явсан.

Тэгээд бид нар мэдээж энэ хувийн сургуулиудын холбоотой уулзаж ярилцаж байна. Тэгээд ашигийн төлөө хэрвээ ажиллах юм бол тодорхой хэмжээнд татвараа төлөөд явъя. Ашигийн бус ажилладаг бас олон сургуулиуд байдаг юм байна лээ. Зүрх сэтгэлээрээ энэ салбарт хайртай учраас энэ хувийн сургууль байгуулаад тэтгэвэртээ гарчихсан багш нар үүсгэн байгуулсан ч гэдэг юм уу ийм сургуулиуд байдаг юм байна лээ. Эд нар нь ашигийн бус явах юм бол Төрийн бус байгууллагынхаа хуулиар явъя гээд ийм зүйл дээр бид нар нэгдээд, тэгээд энэ 18.3.1 нь орж ирж байгаа гэж би үзэж байгаа шүү. Энэ зөв биз дээ.

Цаашид бид нар яваандаа энэ Татварын тухай хууль дээр бас ажиллах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл энэ боловсролын байгууллагууд хувийн боловсролын байгууллагууд татварын олон хууль дээр татвараас чөлөөлөгддөг юм байна. Жишээлэх юм бол ААНОАТ-ын тухай хууль байна. Энэний 21.1.9 дээр боловсролын байгууллагууд татвараас чөлөөлөгддөг юм байна. Нэмэгдсэн

өртгийн албан татварын тухай хууль байна энэний 13.5.9 дээр боловсролын байгууллагууд чөлөөлөгдөж байна. Газрын төлбөрийн тухай хууль дээр 8 дугаар зүйл дээр бас 8.5 дээр бас ингээд чөлөөлөгдөж байна. Тэгэхээр энэ асуудлыг бид нар яваа яваандаа урт хугацаандаа ярих ёстой шүү гэдгийг би протоколд бүр цохон тэмдэглүүлмээр байна. Тэгээд энэтэй холбоотой бас улс төржүүлээд одоо хүртэл ингээд л гадаа худлаа жагсаал цуглаан хүчээр зохион байгуулаад байж байгаад нь би бол харамсаж байна. Яг одоо ингээд гадаа.

Ёс зүйн асуудал яриад энэ хууль дээр ажиллах ёстой гишүүн, ажиллахгүй байх ёстой гишүүн гэж ярих юм бол бид нар бүхлээр нь бас ярих зөндөө юмнууд байгаа шүү. Жишээлбэл хувьдаа хувийн сургууль, цэцэрлэг, их сургууль ажиллуулдаг ашиг сонирхлын зөрчилтэй Их Хурлын гишүүд жишээлбэл санал хураалтад орох ёсгүй гэж би үзэж байна. Гэх мэтчилэн ийм ёс зүйн асуудал ярих юм бол өргөн хүрээнд нь бид нар ярих ёстой.

Г.Мөнхцэцэг: Энэ тийм зүйл, заалттай холбоотойгоор асуултад нь нэгмөсөн хариулья. Уул нь ажлын хэсгийн гишүүдэд байгаа шүү дээ тийм ээ. Өөрсдөө байгаад байгаа. Протоколд энэ сая Ундрам гишүүний хэлснийг протоколд үлдээе. Мөнхцэцэг гишүүн уул нь ажлын хэсгийн гишүүн тийм ээ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ манай боловсролын шинэчлэлийн олон нийтийн хүсэн хүлээж байгаа хамгийн том нэг агуулга бол энэ боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах. Өнгөрсөн 30 жил боловсролоор бизнес хийсэн. Үүний улмаас эцэг, эхийн орлого, эцэг, эхийн гарал ямар байгаагаас хамаараад хүүхэд болгонд чанартай боловсрол олж авах тэгш бус боломж бий болчихсон. Үүнийг бид нар хязгаарлах ёстой. Хувийн сургуулиуд маань боловсролын салбарын хийгээгүй асар их хүндхэн ачааг үүрч, олон хүүхдэд чанартай боловсрол

Кэмбрижийн хөтөлбөрийг олгож байгаа нь сайшаалтай. Тэгэхдээ бид нар хувийн сургуулиудын хийж байгаа энэ ачааг энэ чигээр нь үүрүүлээд, Монголын төр боловсрол дахь энэ бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгох энэ үүргээсээ татгалзаж болохгүй.

Дэлхийн чиг хандлага ч гэсэн ашигийн бус боловсрол гэдэг рүү явж байна. Боловсрол бол хүний эрх, нийгэмд амьдрах цаашдын ирээдүйн хөгжлийн гол түлхүүр учраас төр бол энэ дээр гол үүргээ хүлээх ёстой. Тийм учраас энэ боловсролыг бизнес болгож байгаа энэ 30 жилийн алдаагаа бид нар засах ёстой. Боловсрол бол ашигийн бус байх, хэрвээ тухайн боловсролын салбар дахь тодорхой сургалтын байгууллага ашиг олж байгаа бол татвараа төлөөд, Иргэний хуулийн, Улсын бүртгэлийн хуулийн дагуу явах ёстой. Түүрүүн Ундрам гишүүн бас хэллээ. Нэлээд олон сургалтын байгууллагууд сургалтын бүх шатын байгууллагууд бол татвар төлдөггүй. Гэтэл тухайн өндөр төлбөр аваад тухайн төлбөрөөс ашиг хувь хуваарилдаг. Эсвэл сургалтын төлбөрөөс дахин өөр бизнес хийдэг. Жил болгон төлбөрөө нэмдэг ийм асуудал их байна.

Өнгөрсөн 2, 3 жилийн хугацаанд Боловсролын хуулийн энэ хэлэлцүүлгийн явцад маш олон эцэг, эхчүүд сургуулиуд, мөн багш нар энэ дотор төрийн өмчийн, төрийн бус өмчийн ч гэсэн саналууд ирсэн. Ялангуяа энэ жилийн хувьд үнийн өсөлт нэмэгдсэн энэ хүнд байдалд ихэнх хувийн сургууль төлбөрөө нэмсэн байна. Бид нар дээр бол их олон саналууд ирж байгаа шүү. Тэгвэл тэр төлбөр нэмж байгаа үндэслэл юу вэ, үнэхээр тухайн төлбөрийг цэвэр сургалтын зорилгодоо ашиглаж байгаа юм уу эсвэл тухайн үүсгэн байгуулагчид бизнесээ өргөжүүлэх гэж байгаа юм уу энэ тал дээр Монголын төр ялгаатай бодлого барих ёстой.

Тийм учраас ажлын хэсэг дээр сарын өмнө хураалгасан боловсролыг

боловсролын сургалтын байгууллага нь ашигийн төлөө байгаа бол Компанийн хуулиар явах ёстой. Өөрөөр хэлбэл татвар төлөх ёстой. Хэрвээ ашигийн бус байгаа бол боловсрол зөвхөн боловсролынхоо зорилгод буюу тухайн сургалтын төлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд зарцуулж байгаа бол энэ татвараа чөлөөлөх ёстой гэдэг энэ заалтаар явах ёстой байсан.

Гэтэл өчигдөр энэ ажлын хэсгийн хуралдаан дээр энэ заалтуудыг маань унагасан байгаа. Гэтэл бид нар энэ хуулийн маань нийцэл буюу энэ Их Хурлаас баталж байгаа хууль маань бусад хуулиудтайгаа уялдах ёстой. Тэгээд энэ 18.3.1 дээр ашигийн төлөө, ашигийн төлөө бус сургалтын байгууллага гээд шинэ заалт оруулаад бүртгүүлэх нь Иргэний хуулийн 33 дугаар зүйлийг зөрчиж байна. Монгол Улсад Иргэний хуулиар хуулийн этгээд зөвхөн 2 төрлийн статустай байх ёстой. 33.1-ээр ашигийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр, 33.2 дээр ашигийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хориооны төв байгуулах ёстой байгаа юм. Тийм учраас бид нар яг энэ заалт дээр эрх зүйн дүн шинжилгээ дүгнэлт гаргуулах ийм зарчмын зөрүүтэй саналыг бол оруулж байна.

18.3.1 бол эрх зүйн хувьд маргаантай буюу бусад хуулийг зөрчсөн байх магадлалтай байна. Тийм учраас энэ саналыг хэлэлцүүлж санал зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Ер нь бол бодит байдал дээр ялгаварлан гадуурхсан эцэг, эхийн орлогоос хамаарсан ашигийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ийм сургалтын байгууллагуудыг бол төрөөс дэмжиж, төрөөс татвараас чөлөөлөх үндэслэл байхгүй байгаа. Энийг бол маш олон эцэг, эхчүүд, Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхчүүдийн холбоо, Бүх нийт боловсролын төлөө зэрэг маш олон байгууллага эрдэмтэд явуулж байна. Та бүхэн бас харж байгаа бол сүүлийн хэдэн сар нийгмийн сүлжээнд ч гэсэн боловсролын ашигийн төлөө бус байх энэ

төрийн үүргийг илүү хангалттай гүйцэтгэх ёстой. Монголын төр ачаагаа хэн нэгэнд үүрүүлээд, эдийн засгийн энэ нөхцөл байдалд бид нар дунд сургуулиудыгаа ашиг олох байдлаар ажиллахыг зөвшөөрч болохгүй. Тийм учраас бид нар энэ 10.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Горимын санал гаргаж байгаа юм байна. Мөнхцэцэг гишүүнд нэмж нэг минутын.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргуулах шаардлагатай байна. 38.2.1 дээр энэ тухайн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээж байгаа эсэх хэрвээ тухайн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээгүй гэж эрх зүйн дүгнэлт гаргасан бол ямар хуулийн аль заалтад нийцэхгүй байгааг, түүнчлэн тэдгээрийн үндэслэлийг тайлбарлах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл ашгийн ба ашгийн бус гэдгийг ялгаатай зааж өгөхгүй бол энэ маань Иргэний хуулийн болон бусад хуулийг зөрчиж байна. Энэ дээр дүгнэлт гаргуулахаар энэ санал оруулж байна. Манай Байнгын хорооны гишүүд энийг дэмжих шаардлагатай байгаа. Бид нар хууль зүйн маргаангүй, тэгээд бүх нийтийн ерөнхий боловсролыг нийтийн сайн сайхны төлөөх хуулийн заалтууд маань гарах ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн бас гишүүдийн саяын гаргасан санал дээр нэмэлт тайлбар өгөх нь зүйтэй байх. Дамдин гишүүнд микрофоныг өгье.

Г.Дамдинням: Тэгэхээр ийм байгаа юм. Ажлын хэсгийн хуралдаан дээр энэ асуудлууд бол нэлээн удаан хугацаанд яригдсан. Тэгэхээр Улсын Их Хурлын даргын ч үүрэг болгосноор энэ ашгийн болон ашгийн бус гэдэг дээр

Улсын Их Хурлын мэргэжлийн экспертний дүгнэлт бол гарчихсан. Мэргэжлийн эрх зүйн дүгнэлт бол гарчихсан. Эрх зүйн дүгнэлтийн гол тайлбар нь бол ийм л юм хэлээд байгаа юм. Тайлбар.Боловсролын байгууллага нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байж болно гэж гэсэн энэ заалтыг өмнө нь бид нар ажлын хэсэг дээр оруулаад ирчихсэн байсан боловч өнөөгийн Монгол Улсын Үндсэн хууль дээр таарахгүй байгаад байгаа юм.

Яагаад гэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж зааснаар энэ заалтын агуулга нь өөрөө өнөөдөр ерөөсөө болохгүй болчихоод байгаа юм.

2 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3-д хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нийгмийн зайлиггүй хэрэгцээг Үндсэн хуулийг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор олгоно. Үүнийг төлнө гэсэн байдаг.

Цаана нь дахиад 16 дугаар зүйлийн 7-д сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гээд заачихсан байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар гарц үлдэж байгаа вэ гэхээр хэрвээ бид нар ингээд бүх нийтийн бүгдээрээ улсын сургуулиуд, хувийн сургуулиуд байх ёсгүй гэж шийдээд, хувийн хэвилийн эсрэг л шийднэ гэсэн үг л дээ. Тэгээд ашиг олж болохгүй гэж үзэх юм бол бид нар зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд ишлэжчихсэн, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулна гээд явж байгаа манай улсын үндсэн зарчимд

нийцэхгүй. Тэгэхээр Үндсэн хуулиа л өөрчлөх ёстой болно гэсэн үг.

Дараачийн асуудал нь боловсрол сургалтын байгууллага гэдэг ойлголт энэ улсын бүртгэлээрээ бид нар энэ 18.1-ээрээ заагаад өгчхөж байгаа юм. Өөрөөр хэлбэл 18.3.1.ашигийн төлөө, ашигийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-д заасан үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно гээд заагаад өгчихсөн. Төсөл дээр бол энэ орчихсон явж байгаа. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бид нар боловсрол сургалтын байгууллага гэдгийг Бүртгэлийн хууль дээр энэ Ерөнхий хуулийг дагаж орох өөрчлөлтөөр шинээр бүртгэж байгаа юм. Тэгэхгүй бол сургалтын байгууллагыг бол янз бүрээр бүртгээд байгаа юм. Хориоо дээр бүртгэж байна, ТББ дээр бүртгэж байна, УУГ гээд бүртгэж байна. Ингээд замбараагаа алдчихаад байгаа учраас энэ хяналт зохицуулалт нь байхгүй болчихож байгаа юм.

Тэгэхээр бид нар боловсрол сургалтын байгууллага гээд Бүртгэлийн тухай хуульд оруулаад явчихвал татвараа төлнө, татвараа төлөхгүй. Ашигийн бол татвараа төлөөд өөрөө явчихна, тэнд өөрөө сонгоно. Ашигийн бус байх юм бол явдаг замаараа яваад, ашиг олсон байх юм бол Зөрчлийн хуулиараа татвар хураамж нь ноогдоод л явчихна. Үндсэн зарчмаараа таны яриад байгаа асуудал уг нь бол суучихаад байгаа юм. Тэгэхээр бид бол ардчилал, хувийн өмч, чөлөөт зах зээлийг дэмжсэн энэ бодлогоосоо ухарч болохгүй Манай улс орон. Тэгэхээр би бол энэ зарчмын зөрүүтэй саналыг битгий дэмжээч гэж гишүүдээсээ хүсье. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр ирүүлсэн тэр нэг хууль зүйн санал бол яг Улсын Их Хурлын тухай хуулийн Хуралдааны дэгийн тухай

хуулийн 38.1, 38.3, 4 гээд энэ заалтад нийцсэн эрх зүйн дүгнэлт бол биш. Тэр бол зөвлөмж төдий байсан. Тийм учраас бид нар яг энэ холбогдох Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад хуулийн талаар үүссэн маргаантай асуудлаар Улсын Их Хурлаас хууль зүйн эрх зүйн дүгнэлт гаргуулах буюу албан ёсны хүчинтэй эрх зүйн үндэслэл бүхий асуудлаар энэ заалтыг барих нь зүйтэй.

Тэгээд мөн Үндсэн хуулийн 16.7-гоо мөн барих ёстой. Ажлын хэсгийн ахлагч маань бас энийг ташааруулан тайлбарлаад байна. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллаж болно гэж байгаа юм. Тэгвэл Үндсэн хуульдаа төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулж болно гэдэг учраас бид нар энэ шаардлагуудаа тодорхой болгох ёстой. Төлбөрийн жишигээр дээд хэмжээг тогтоох юм уу эсвэл тухайн сургалтын байгууллагад ашигийн төлөө бус.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Мөнхцэцэг гишүүний гаргаж байгаа одоо хэрвээ энэ зарчмын зөрүүтэй саналаар санал горимоор санал хураагдаад ингээд явах юм бол түрүүн яг үндэслэлээ 38.2.1 нь Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 38.2.1-ийг үндэслэлээ бол хэлчихсэн. Тийм ээ. Хэрвээ энэ Мөнхцэцэг гишүүний гаргаж байгаа энэ санал дэмжигдээд явах юм бол бид нар энэ Дэгийн тухай хуулийн 38.3-д заасны дагуу Хуулийн асуудал хариуцсан газар нь энэ хуулийн 38.2-т заасан эрх зүйн дүгнэлтийг ажлын 7-14 өдрийн дотор гаргах бөгөөд тус газрын дарга гарын үсэг зурж баталгаажуулна гээд ингээд явчих юм байгаа юм. Дахиад энэ хойшилно гэсэн үг.

Тийм учраас ямар ч байсан Мөнхцэцэг гишүүний гаргаж байгаа энэ горимоор бол саналаа хураах нь бол эхлээд зөв. Тийм учраас энэ Мөнхцэцэг гишүүний гаргаж байгаа горимоор санал

хураалт явуулъя. Санал хураалт. Мөнхцэцэг гишүүний гаргаж байгаа саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулж байгаа шүү. Энэ санал дэмжигдсэнгүй. Ингээд энэ хуучнаар үйлдэнэ гэсэн үг.

Ингээд тийм 18 дугаар зүйл, 35 дугаар, 36 дугаар санал хураалтыг түрүүн 18 дугаар зүйлээр хураасан, хураах гээд санал гаргасан. Ингээд энэ 18 дугаар зүйл буюу 36 дугаар дугаартай байгаа энэ саналаар түрүүн саналыг бол саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Энэ саналынхаа дагуу санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Жаргалмаа гишүүн микрофон юу ажилласангүй тийм ээ, техник ажилласангүй. Дахиж санал хураалт. Энэ саналыг энэ санал хураалтыг цуцлаад цуцалъя гэдэг томъёоллоор санал хураана тийм үү. Шууд хурааж болох юм уу? Энэ санал хураалт 58.3 хувиар дэмжигдлээ. 3 дахиа бас хурааж баталгаажуулах нь зүйтэй. Тийм учраас саяын энэ 18 дугаар зүйл дээр түрүүчийн миний унисан томъёоллуудаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Манайхан энийг хураачхаад, чуулган руу орж ирцдээ орчхоод, буцаж эргэж ирээд. Мөнхцэцэг гишүүн саналыг саналаа хэлье. Протокол бүртгээд явчих.

Ц.Мөнхцэцэг: Энэ саяын санал хураалт дээр миний төхөөрөмж гацсан. Би уг нь дэмжиж байсан учраас протокол дээр дэмжиж байгаарай авч өгнө үү.

Г.Мөнхцэцэг: Мөнхцэцэг гишүүн Ц.Мөнхцэцэг гишүүний саяын санал хураалтад төхөөрөмж нь ажиллаагүй. Тийм учраас протоколд миний саналыг дэмжсэнээр оруулж өгөөч гэдэг ийм саналыг сая хэллээ. Ийм учраас бол саяын санал хураалт 51.1 хувиар дэмжигдсэн гэж ингэж тооцож болно. Ингээд санал хураалт дэмжигдлээ.

15 цагаас чуулган зарлачихсан байгаа. Тийм учраас гишүүд орж ирцдээ

орчхоод, буцаж эргэж хурч ирж саналыг нь санал хураалтаа үргэлжлүүлнэ.

Чуулганы нэгдсэн хуралдаан эхлэх цаг болсон тул хуралдаан 15 цаг 10 минутаас 15 цаг 36 минутад түр завсарлав.

Г.Мөнхцэцэг: Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлье. Ажлын дэд хэсэг байраа эзлээрэй. Бид завсарлахын өмнө 37 дугаар дээр буюу 18 дугаар зүйлээр санал хураагаад завсарласан байж байгаа. Одоо 37. 37 дээр.

37.Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

21 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 16, 22 дугаар зүйлд заасан стандартын шаардлага хангасан хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнээр хангагдсан, зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавигдах шаардлагыг хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг эрх бүхий этгээд Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Санал хураалт. Энэ санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ. Дамдинням гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

22 дугаар зүйл. Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавигдах шаардлага

22.1. Зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

22.1.1. боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгчдийн гэрээг үндэслэл, танилцуулгын хамт;

22.1.2. сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, тэдгээрийн боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3. стандартын шаардлага хангасан, зориулалтын хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын бүтээгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заасан шаардлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4. санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5. боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд зориулан гаргасан хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа, боловсролын сургалтын байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6. шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7. сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байхыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын байгууллага нь нийт багш нарын 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байхыг нотолсон бичиг баримт, баримт бичиг;

22.1.8. цэрэг цагдаа, төмөр замын чиглэлээр мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт явуулах тохиолдолд холбогдох байгууллагын санал, дүгнэлт, ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан бичиг баримт, баримт бичиг;

22.1.9. сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн дипломтой байх бөгөөд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй буюу зөрчил гаргаж байгаагүй талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10. татвар, нийгмийн даатгалын байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу гарсан алдагдалгүй, нөхөн төлбөргүй талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2. Энэ хуулийн 21.2-т заасан эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн байгууллага, бусад байгууллагад шилжүүлж болно.

22.3. Энэ хуулийн 22.2-т заасан үндэслэлээр эрх хүлээн авагч нь тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

22.4. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

22.5. Боловсролын сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 21.1 нэгээс, 21.1.3-21.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх сургалтын үндэслэл, танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох бүхий эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа хүсэлт, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7. Тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжил нээх хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ хуулийн 21.2-т заасан хугацаа харгалзахгүй хүлээн авч шийдвэрлэж болно. Санал хураалт. Энэ санал 61.5 хувиар дэмжигдлээ.

23 дугаар зүйл. Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1. Эрх бүхий этгээдээс олгох ерөнхий боловсролын сургууль байгуулахад олгох зөвшөөрлийн хугацаа 12 жил байх бөгөөд сургуулийн өмнөх болон дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд олгох зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн хугацаанаас доошгүй байна.

23.2. Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3. Энэ хуулийн 21.1.19-д заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах үндэслэл болно. Санал хураалт. Энийг униих байсан юм уу? Хаалгыг хаачхаач. Энэ санал 69.2 хувиар дэмжигдлээ.

23 дугаар зүйл. Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1. Эрх бүхий этгээдээс олгох ерөнхий боловсролын сургууль байгуулахад олгох зөвшөөрлийн хугацаа 12 жил байх бөгөөд сургуулийн өмнөх

болон дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд олгох зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн хугацаанаас доошгүй байна. Сая хураасан билүү?

23.2.Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3.Энэ хуулийн 21.1.19-д заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах үндэслэл болно гэж.

24 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

24.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

24.1.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон;

24.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

24.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

24.3.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг Иргэний хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

24.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахад суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр тухайн хичээлийн жилтэй уялдуулж үүсгэн байгуулагч

шийдвэрлэнэ.” Санал хураалт. Энэ санал 69.2 хувиар дэмжигдлээ.

38.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.3 дахь хэсгийг төслөөс хасах.

“27.1.Боловсролын удирдлага нь Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллагын удирдлагаас бүрдэнэ. Санал хураалт. Энэ санал 61.5 хувиар дэмжигдлээ.

39.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.4, 27.5, 27.6 дахь хэсэг нэмэх.

“27.4.Боловсролын үндэсний зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд мэргэжлийн зөвлөлтэй байна. Үндэсний зөвлөл нь ажлын албатай байх бөгөөд ажлын албаны даргын чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ.

27.5.Энэ хуулийн 27.4-т заасан Боловсролын үндэсний зөвлөл нь боловсролын бодлого, хэрэгжилт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж чиглэл гаргах, боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа, судалгаа шинжилгээнд дэмжлэг үзүүлэх болон багш, судлаач, эрдэмтэн, төрийн бус байгууллага, ажил олгогчийг албан ёсоор төлөөлөх байгууллага, мэргэжлийн холбоо тэдгээрийн хамтын ажиллагаа,

түншлэлийг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

27.6.Энэ хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Мэргэжлийн зөвлөлд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг энэ хуулийн 27.4 дэх хэсэгт заасан ажлын алба хэрэгжүүлнэ.” Санал хураалт. Энэ санал хураалт 53.8 хувиар дэмжигдлээ. Өөрийнх. 17.1, нэг нэмэлт тайлбар бас өгөөдөхье. Тэгье өмнө нь 17.4.1 дээр дэмжигдсэн энэ санал саяын хураасан санал руу шилжих юм байна. Энийг микрофонд хэлээд протоколд тэмдэглүүлчихье.

40. Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтын “боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн” гэснийг “энэ хуулийн 17.2, 17.7-д заасан” гэж, 28.1.4 дэх заалтын “батлах” гэснийг “баталж, хэмжээг тогтоох” гэж, 28.1.7 дахь заалтын “мэргэжлийн болон дээд боловсролын” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын” гэж, 28.1.9 дэх заалтын “болон ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол” гэснийг “, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол” гэж, “хувьсах зардлын дундаж норматив зардал” гэснийг, “суурь, хувьсах зардлын дундаж норматив зардал” гэснийг тус тус “хувьсах зардал” гэж, 28.1.10 дахь заалтын “хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг” гэснийг “хувьсах зардлын хэмжээг 2 жил тутамд шинэчлэн” гэж өөрчилж, 28.1.16 дахь заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “буцалтгүй тусламж олгох” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.1.19, 28.1.20 дахь заалт нэмэх.

“28.1.19.боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл,

мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг батлах;

28.1.20.энэ хуулийн 12.6, 12.8-д заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх журмыг батлах;” Санал хураалт. Энэ санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

41.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, 28.1.3, 28.1.8, 28.1.12 дахь заалтыг төслөөс хасаж, 28.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.1.14.боловсролын үндэсний зөвлөл байгуулах, бүрэлдэхүүн, дүрмийг батлах;” Санал хураалт. Энэ санал хураалт 61.5 хувиар дэмжигдлээ.

42.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна” гэж нэмж, 29.1.3 заалтын “боловсролын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, 29.1.8 дахь заалтын “нэн шаардлагатай мэргэжлийн” гэснийг “мэргэжлийг тодорхойлох аргачлал,” гэж, 29.1.9 дэх заалтын “ажлыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчилж, 29.1.1, 29.1.2, 29.1.4, 29.1.5, 29.1.6 дахь заалт, 29.2 дахь хэсгийг төслөөс хасах. Санал хураалт. Энэ санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

43.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.4, 30.1.5, 30.1.11, 30.1.16, 30.1.17, 30.1.19, 30.1.21 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлийн 30.1.1, 30.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 106.3-т заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативыг батлах;

30.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам батлах;" Санал хураалт. Энэ санал хураалт 49.2 хувиар дэмжигдлээ.

44.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын "ерөнхий боловсролын сургууль" гэсний дараа "мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн" гэж, 30.1.10 дахь заалтын "мэргэжлийн болон" гэсний дараа "техникийн," гэж, 30.1.15 дахь заалтын "сургалт зохион байгуулах" гэсний дараа ", эзэмисэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх" гэж, 30.1.18 дахь заалтын "бэлэн байдлыг хангах," гэсний дараа "гамшигийн нөхцөл байдлыг харгалзан хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаанд" гэж, 30.1.20 дахь заалтын "боловсролын хэлтсийн" гэсний дараа ", насан туршийн суралцахуйн төвийн" гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 30.1.25-30.1.35 дахь заалтыг шинээр нэмэх."

"30.1.25.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоог энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн тогтоох;

30.1.26.Төрийн албаны тухай хуулийн 57.14-д заасан төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн доод хэмжээг салбарын онцлог, гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлэх асуудлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх;

30.1.27.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг

үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;

30.1.28.аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн бүтэц, орон тоог тухайн нутаг дэвсгэрийн суралцагчийн тоо, төвөөс алслагдмал байдлыг үндэслэн батлах;

30.1.29.боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

30.1.30.боловсролын сургалтын байгууллагад олгох зөвшөөрлийн гэрчилгээний загварыг батлах;

30.1.31.мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлтийн журам, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал батлах;

30.1.32.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалт, аргачлалыг хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

30.1.33.боловсролын чанарын баталгаажуулалтын журам, аргачлал батлах;

30.1.34.боловсролын салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбоотой санал боловсруулах, салбарын холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон шаардлагатай дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

30.1.35.энэ хуулийн 17.6.3-т заасан төвийн бүтэц, орон тоо, үлгэрчилсэн дүрмийг эрүүл мэндийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;" Санал хураалт. Энэ санал 76.9 хувиар дэмжигдлээ.

45.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.8 дахь заалтын "сургалтын хэрэглэгдэхүүнд" гэснийг "сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд" гэж, 30.1.9 дэх заалтын "боловсролын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер" гэснийг "цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер," гэж, мөн зүйлийн 30.1.12 дахь заалтын "дээд боловсролын байгууллага" гэснийг "мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага" гэж, 30.1.13 дахь заалтын "боловсролын эрдэм шинжилгээ, үнэлгээ, арга зүйн байгууллагын бүтэц, орон тоо" гэснийг "энэ хуулийн 17.2, 17.6, 17.7-д заасан байгууллагын бүтэц" гэж, 30.1.14 дэх заалтын "боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн" гэснийг "энэ хуулийн 17.217 гэж юу гэж байгаа юм бэ? 17-ын тасалсан, юу гэж байгаа юм бэ? 17.2.17 юу? 17.2, 17.7, 17.9-д заасан" гэж, 30.1.22 дахь заалтын "багш бэлтгэх их, дээд сургуулийн суралцагчаас улсын нэгдсэн болон багшлах эрхийн шалгалт авах" гэснийг "багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох бусад үйл ажиллагааны" гэж өөрчилж, 30.1.23 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"30.1.23.боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг батлах;
Санал хураалт. Энэ санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ. Өөрөө харахгүй байгаа юм байна шүү дээ?"

46.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.1, 31.1.5, 31.1.6, 31.1.9, 31.1.10, 31.1.12, 31.1.13 дахь заалтыг төслөөс хасаж, 31.1.2 дахь заалтын "сургалтын

хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж" гэснийг "сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл," гэж өөрчилж, мөн зүйлийн 31.1 дэх хэсгийн "төрийн захиргааны байгууллага нь" гэсний дараа "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна" гэж, мөн зүйлийн 31.1.8 дахь заалтын "олимпиад" гэсний дараа "мэргэжлийн болон техникийн боловсролын ур чадварын уралдаан" гэж, 31.1.11 дэх заалтын "тайланг" гэсний дараа "статистикийг" гэж, "хуульд" гэсний өмнө "холбогдох" гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 31.1.16-31.1.20 дахь заалт нэмэх.

"31.1.16.гадаад улсад насан туршийн суралцахуйн төвд санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг батлах;

31.1.17.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт батлах;

31.1.18.аймаг, нийслэлийн насан туршийн суралцахуйн төвийн захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

31.1.19.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд ашиглах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагыг батлах;

31.1.20.Сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалт батлах." Санал хураалт. Би өөрөө мартчихаад байгаа юм байна. Энэ санал 69.2 хувиар дэмжигдлээ. Ц.Мөнхцэцэг гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

47.Төслийн 32 дугаар зүйлийг төслөөс хасах. Санал хураалт. Энэ санал 61.5 хувиар дэмжигдлээ.

48.Төслийн 33 дугаар зүйлийн нэрийг “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага” гэж цаашид тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх.

“33.1.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.” Санал хураалт. Энэ санал 88.3 хувиар дэмжигдлээ.

49.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын “тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг” гэснийг “хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ” гэж өөрчилж, мөн зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт, 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг төслөөс хасаж, 33.1.5, 33.5.1, 33.6.1 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.5.1, 33.6.1 дэх хэсгийн “удирдах” гэсний дараа “эсхүл, нийгмийн” гэж нэмж, мөн зүйлийн 33.5.1 дэх заалтын “ажилласан” гэсний дараа “, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар, 33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмэх. Тайлбар нь яах юм бэ? Тайлбар байгаа юм байна шүү дээ. Тайлбарыг уншаад танилцуулъя.

“Тайлбар:Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 33.1.4-т заасан “Сургуулийн орчин” гэдэгт бүх түвшний боловсролын сургалтын байгууллагыг хамааруулна.”

33.1.19.зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах

үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

33.7.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нь сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.8.Нийслэлийн боловсролын газрын дарга нь дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтаар үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.”

33.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.” Санал хураалт. Энийгээ мартчихсан байна шүү дээ. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ. Батиугар гишүүний техник ажиллагаагүй учраас дэмжсэн протоколд тэмдэглүүлье.

50.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэснийг “хяналт-шинжилгээ” гэж, 33.1.12 дахь заалтын “боловсролын байгууллагын орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарах, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” гэснийг “сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан” гэж, 33.1.13, 33.1.15 дахь заалтын “орон нутгийн боловсролын” гэснийг “орон нутгийн өмчийн боловсролын сургалтын” гэж, 33.1.16 дахь заалтын “боловсролын байгууллагатай” гэснийг “суралцахуйн төвтэй” гэж, 33.5.2 дахь заалтын “үнэлгээний” гэснийг “үнэлгээ, нийгмийн ажил, сэтгэл зүйн” гэж, 33.6.1 дэх заалтын “10” гэснийг “9” гэж, “3-аас” гэснийг “4-өөс” гэж өөрчилж, 33.1.3,

33.1.8, 33.1.11, 33.6.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.1.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6, 7.7-д заасан зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;

33.1.8.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, зөвлөн туслах;

33.1.11.өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохируулгат орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

33.6.2.энэ хуулийн 33.5.2-д заасан шаардлагыг хангасан байх;” Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Саяын цуцалсан санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Хэдээр гэнэ? Дэмжиж зүйл дээрээ л ярина байна шүү дээ 35, 33 дугаар зүйл дээр. Энэ санал 33.3 хувиар дэмжигдлээ. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

Энэ саяын 50 дугаар 33 дугаар 33.5 дугаар зүйл дээр 33.6.1-д найруулгын найруулгын 2 санал байгаа юм байна. Учрал гишүүнээс, Учрал гишүүнээс санал гаргаж байна.

33.5.1 дээр боловсролын байгууллагад “10-аас доошгүй жил ажилласан байх.” тус тусад нь хураалгах уу? 33.6.1 дээр “боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх.” гэсэн ийм санал оруулж байна. Саналыг Учрал гишүүн гаргаснаар тайлбарлаад, дараа нь санал хураалт.

Н.Учрал: Ер нь энэ боловсролын салбарт ажиллаж байсан туршилагатай сайн багш нарыг аймаг, дүүргийн, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн даргаар тавих бол маш зөв зарчим юм байна гэдгийг жишээ нь хотын Боловсролын даргаар тэр Амартүвшин даргыг тавиад ажиллаж байгааг харахад бол харагдаад байгаа юм.

Тэгэхээр төрийн алба бол нөгөө хуультай. Жишээ нь тайлбарлахад дүүргийн боловсролын хэлтсийн дарга гэдэг албан тушаалд хэн очдог вэ гээд. Төрийн албаны хуулиараа дүүргийн боловсролын хэлтсийн дарга бол төрийн захиргааны албан тушаал. Дээрээс нь дэс түшмэл, дэс түшмэл. Сая Засгийн газраас төрийн үйлчилгээний албан тушаалыг дүйцүүлэх журам гаргасан. Дүйцүүлэх журам дээр зөвхөн захирлуудыг дүйцүүлж байгаа юм. Төрийн захиргаатай шүү. Багш нарыг биш. Тэгэхээр дүүргийн боловсролын хэлтсийн дарга нь Төрийн албаны хувьд нийтлэг шаардлагыг биелүүлнэ. Дэс түшмэл байна. Төрийн захиргаанд ажилласан байна.

Дээрээс нь энэ хуулиар нэмээд боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан гэж байгаа юм. Түүн дотроосоо боловсролын байгууллагын багш, удирдах ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан гэж байгаа юм. Тэгэхээр багшаар ажилласан жилүүд нь ТЗ-тэйгээ дүйцэхгүй, ямар ч орох бололцоо байхгүй. Тэгээд нутгийн захиргааны байгууллагууд 3-аас доошгүй жил ажилласан гэхээр дүүргийн боловсролын хэлтэст хэдэн хүн байдаг юм 5, 6 хүн байдаг юм уу. Тэгээд хаашаа юм тэр 5, 6 л цаашаа дарга болох юм уу? Энэ чинь бүр хэн ч давахгүй бараг супер хүнийг хайгаад байна шүү дээ энэ хуулиар. ТЗ, дэс түшмэл, боловсролын байгууллагад 15 жил ажилласан, бүр 10 жилд нь багш удирдах ажил хийсэн. Тэгээд бүр дээр нь нутгийн захиргааны байгууллага буюу аймгийнхаа боловсролын газар мэргэжилтэн заавал

хийж байсан байх. Үгүй ээ ийм хүн ер нь дэлхий ертөнцөд байна уу нэг?

Ингээд харах юм бол тэтгэвэрт гарах насан дээр энэ болзлыг хангах юм байна лээ. Аймгийн боловсролын дарга больё гэвэл. 10-аас 15 жилтэй мэргэжилтэн хийчихсэн, ТЗ-тэй дэс түшмэлтэй. Үгүй ээ энэ чинь одоо ийм өндөр босгыг давж, зүгээр одоо нэг тэр Кембриджийн сургуульд багшилж байсан үнэхээр туршилагатай хүнийг авчраад хотын боловсрол, аймгийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсээ удирдуулж болно шүү дээ. Тэгээд бид нар чинь ийм салхи сэвэр орулдаггүй Төрийн албаны хуулиа яая гэж байхад, дахиад дээрээс нь нэмэлт шаардлагатай. Хүн олдохоо болилоо шүү дээ. Тэгэхээр ерөөсөө ядаж бүр хасахаа больё, ядаж ТЗ-ийн дэс түшмэл байг, ингээд 10 жил боловсролын байгууллагадаа багшаа хийнэ үү, захирлаа хийнэ үү ямар нэгэн байдлаар ажилласан байхад л тэгээд л Төрийн албаныхаа зөвлөл дээр очоод л шалгалтаа өгөөд л тэгээд л орно л биз дээ гэдэг ийм л санал юм ерөнхий байдлаар.

Г.Мөнхцэцэг: Учрал гишүүний саналыг сонслоо, саналаа тайлбарлачихлаа. Тэгээд энэ санал дээр санал хураалт. Сая тайлбарлачихлаа шүү дээ саналаа, саналаа тайлбарлачихсан учраас санал хураалтаа шууд явуулчихъя тэгэх үү Дамдинням дарга. Санал хураалт. Үгүй шүү дээ сая зарчмын зөрүүтэй, энэ саналыг нь дэмжээд, дэмжээд явуулчихъя. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ. 51. Хоёуланг нь тус тусад нь хураах юм уу. Боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан гэдэг нь 33.5-аар, 3.5-аар хураагдсан. 33.6-ын 33.6.1-ээр санал хураалт явуулъя. Учрал гишүүний гаргасан 33-ын зарчмын. Санал хураалт. Учрал гишүүний гаргасан саяын зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Энэ

санал 83.3 хувиар дэмжигдлээ. Учрал гишүүний санал дэмжигдлээ.

51.Төслийн, гишүүдээ анхаарлаа хандуулъя. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, 34.1.2 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 34.1 дэх хэсгийн “тухайн” гэснийг “харьяа” гэж, 34.1.3 дахь заалтын “боловсролыг” гэснийг “боловсролын сургалтын байгууллагыг” гэж, 34.1.4 дэх заалтын “тусгайлан батлах” гэснийг “батлах” гэж, 34.1.7 дахь заалтын “орчинд тавих шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд байлгаж” гэснийг “орчны стандартад нийцсэн талбайн хэмжээний дагуу газрын нөөцөд авч” гэж өөрчилж, мөн зүйлийн 34.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.1.5.насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлах;” Санал хураалт, гишүүд анхаараарай. Юу тараагаад байгаа юм бэ? Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

52.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “харьяа нутаг дэвсгэртээ” гэсний дараа “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна” гэж, 35.1.4, 35.1.9, 35.1.10, 35.1.11 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 35.1.12 дахь заалтын “сургуулиасаа хол амьдардаг” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн” гэж өөрчилж, 35.1.4 дэх заалтын “зохион байгуулах” гэсний дараа “, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх” гэж, төсөлд доор дурдсан агуулгатай 35.1.16 дахь заалт нэмэх.

“35.1.16.орон нутаг дахь насан туршийн суралцахуйн төвийн үйл

ажиллагааны болон тогтмол зардлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах.”

35.1.17.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр байгуулах, өөрчлөх байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;” Санал хураалт, гишүүд анхаарлаа хандуулаарай. Их л онцгой заалтууд ороод байна шүү дээ. Ямар боловсрол түгээгээд байгаа юм бэ? Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

53.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн” гэснийг, мөн зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.5, 35.1.13, 35.1.14 дэх заалтыг төслөөс хасаж, 35.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.1.3.орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;” Санал хураалт. Та нар тараагаад байгаа юмаа өгөхгүй бол. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

54.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4, 36.1.6 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 36.1.8 дахь заалтын “байгууллагын” гэсний өмнө “сургалтын” гэж нэмж, 36.1.1, 36.1.2, 36.1.4, 36.1.7, 36.1.9, 36.1.10 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 36.1.9, 36.1.10, 36.1.11 дэх заалт нэмэх.

“36.1.9.насан туршидаа суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;

36.1.10.сум, дүүргийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

36.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал хураалт. Би яг энийг авах гэсэн чинь камер хараад. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

55.Төслийн 37 дугаар 37.1.3, 37.1.4, 37.1.5 дахь заалтыг төслөөс хасаж, 37.1.2 дахь заалтын “сургалтад хамруулах арга хэмжээ авах” гэснийг “сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 37.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.1.1.тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;” Санал хураалт санал хураалт. Алхаараа юу? Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

56.Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.1.7 дахь заалт нэмэх:

“37.1.7.баг, хорооны боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;” Санал хураалт. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

57.Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг төслөөс хасаж, 38.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж,” гэж, 38.2 дахь хэсгийн “нийтлэг” гэснийг “тусгай” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийн “ректор” гэсний өмнө “проректор,” гэж, 38.2 дахь хэсгийн “боловсролын” гэсний өмнө

“мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад” гэж, 38.1 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 38.2, 38.3 дахь хэсэг, 38.2.2, 38.3.1, 38.3.2, 38.3.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 38.2.2 дахь заалтын “сургалтын менежер” гэсний дараа “, нийгмийн ажилтан” гэж нэмж, 38.3.3 дахь заалтын “хяналт тавих” гэснийг “тасралтгүй хөгжлийг хангах, үнэлэх, дэмжлэг үзүүлэх” гэж, 38.3.6 дахь заалтын “платформ” гэснийг “систем” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 38.4, 38.5 дахь хэсэг нэмэх.

“38.4.Энэ хуулийн 33.5, 33.6-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага, 38.2-т заасан албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг хангаагүй иргэнийг томилохыг хориглох.

38.5.Энэ хуулийн 38.2.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 29, 33 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд холбогдох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал хураалт. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

58.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 39.6 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 39.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв” гэснийг “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж,” гэж, 39.2 дахь хэсгийн “сургуулийн болон цэцэрлэгийн” гэснийг “сургууль, цэцэрлэгийн” гэж, 39.3 дахь хэсгийн “Цэрэг, цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “Цэрэг, цагдаагийн” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

59.Төслийн 40 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40 дүгээр зүйл.Боловсролын хяналт шалгалт, чанарын үнэлгээ

40.1.Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

40.2.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагч нь боловсролын болон холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавина.

40.3.Боловсролын чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу энэ хуулийн 17.7-д заасан байгууллага суралцагч, эцэг эх, иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчийн төлөөллийг оролцуулан зохион байгуулна.

40.4.Сургалтын байгууллагын болон багийн ажлын гүйцэтгэлийг хөндлөнгөөс үнэлнэ.

40.5.Боловсролын үнэлгээг цахимаар болон цахимаар зохион байгуулж болох ба суралцагчийн ахиц дэвшилд дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах үндэсний цахим системтэй байна.

40.6.Боловсролын чанарыг 3 жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ.

40.7.Боловсролын сургалтын байгууллага дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

40.8.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 40.7-д заасан чанарын баталгаажуулалтын үр дүнд

үндэслэж, чанарын сайжруулалтын төлөвлөгөө батлан, хэрэгжүүлнэ.

40.9.Энэ хуулийн 40.8-д заасан төлөвлөгөө нь гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний хэсэг байх бөгөөд түүний ажлын үр дүнг хэмжих үзүүлэлт нь чанарын ахиц дэвшил байна.

40.10.Төрийн өмчийн бус илэрхийлэл, ерөнхий боловсролын сургуулийн гадаад улсын хөтөлбөрийг магадлан итгэмжилнэ.

40.11.Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын магадлан итгэмжлэлийг холбогдох хуулиар зохицуулна.

40.12.Сургалтын хөтөлбөрийг гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран магадлан итгэмжилж болно.” Санал хураалт. Энэ санал нь 83.3 хувиар дэмжигдлээ.

60.Төслийн ТАВЬДУГААР БҮЛЭГ нэрийн ЭДИЙН ЗАСАГ, 60.Төслийн “ТАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийн “ЭДИЙН ЗАСАГ” гэснийг хасаж, 42.5 дахь хэсэг, 42.5.2, 42.5.3, 42.5.4, 42.5.5 дахь заалт, 42.7 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 42.5.5 дахь заалтын “шууд” гэсний дараа “өртөгт суурилсан” гэж, 42.5.2 дахь заалтын “эрдэм шинжилгээний” гэснийг “эндаументын сан болон эрдэм шинжилгээ, инновацын ” гэж, 42.5.4 дэх заалтын “нэг суралцагчид ногдох сургалтын шууд зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хэсэг” гэснийг “хувьсах зардал” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 42.4, 42.9 дэх хэсэг нэмэх. 42-ын.

“41.4.Энэ хуулийн 41.1-41.3-т заасан этгээд боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалт болон нөөцийг хуваарилах, сургалтын байгууллага байгуулах, бүтэц, хамран сургах тойрог

тогтооход хүн амын нягтаршил, суурьшил, дэд бүтэц, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулсан газарзүйн мэдээллийн системд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

42.9.Боловсролын сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг боловсролын болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” Санал хураалт. Сургууль хандив гэж байгаа юм уу, хөгжүүлэх сантай байж болох гээд энэ. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

61.Төслийн 42.4 дэх хэсгийн “Боловсролын байгууллага нь” гэснийг “Боловсролын санхүүжилт нь” гэж, “санхүүжнэ” гэснийг “бүрдэнэ” гэж, 42.5.3 дахь заалтын “цэрэг, цагдаа, аюулгүй байдлын дээд” гэснийг “цэрэг, цагдаагийн дээд болон мэргэжлийн” гэж, 42.5.5 дахь заалтын “суурьшлын ялгаанаас үүсэж буй боловсролын ялгааг багасгах Засгийн газрын бодлого, эцэг эх асран хамгаалагчийн амьдралын түвшинтэй” гэснийг “байршил, сургалтын төлбөрийн хэмжээтэй” гэж, мөн заалтын “хүсэлтийн дагуу эрэлтэд суурилсан хэлбэрээр” гэснийг “тоогоор” гэж, 42.6 дахь хэсгийн “Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн” гэснийг “Энэ хуулийн 17.2-т заасан” гэж, 42.7 дахь хэсгийн “аж ахуйн үйл ажиллагаа явуулж” гэснийг “сургалтын орчин, үйл ажиллагааг дэмжсэн туслах аж ахуйтай байж” гэж өөрчилж, 42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.8.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 42.4, 42.7-д заасан өөрийн орлого бүрдүүлсэн нь төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.” Энэ дээр Ундрам гишүүн үг хэлье.

Ч.Ундрам: Энэ хуулийн төслийн 42.5.5 энэ хувьсах зардалтай холбоотой заалт байгаа. Тэгээд энэ дээр бид нар ажлын хэсэг дээр юу гэж тохирсон бэ гэхээр үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хувийн сургуулиудад яамны боловсруулж баталсан журмын дагуу энэ хувьсах зардлыг олгоё гэж тохирсон гэж би ойлгож байгаа. Гэтэл энэ томьёолол дээр яг тэр нь бас яг сайн харагдахгүй байна л даа.

Г.Дамдинням: Байж байгаа биз дээ байгаа шүү дээ. Байгаа байгаа. 43.11 шүү.

Ч.Ундрам: Хэддүгээр санал дээр?

Г.Дамдинням: 43.11 хойшоо, дахиад хойшоо байгаа.

Ч.Ундрам: дээр явж байгаа, окэй.

Г.Мөнхцэцэг: Энэ томьёолсон хэсгийг нь бол ойлгочихсон тийм ээ Ундрам гишүүн? Санал хураалт. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

62.Төслийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, 42.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 42.5.1 дэх заалтын “хуульд заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагчаас хариуцах зардлыг санхүүжүүлэх” гэснийг “холбогдох хуулиар зөвшөөрсөн” гэж өөрчлөх. Санал хураалт. 62, 68 дээр. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

63.Төслийн 43 дугаар зүйлийн гарчиг, 43.1.3 дахь заалт, 43.3 дахь хэсэг, 43.4.8 дахь заалт, 42.8 дахь хэсэг, 43.10 дахь хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх. Санал

хураалт. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

63.Төслийн 43 дугаар зүйлийн гарчиг, 43.1.3 дахь заалт, 43.3 дахь хэсэг, 43.4.8 дахь заалт, сая униссан тийм ээ? 64 юм байна.

64.Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4 дэх хэсэг нэмэх. 64 дүгээр явж байгаа шүү.

“43.4.Энэ хуулийн 43.1.2, 43.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно.” Санал хураалт, энэ чинь харин яг болж байгаа. Энэ заалт чинь харин хэрэгтэй болоод явж байгаа. Энэ санал 83.3 хувиар дэмжигдлээ.

65.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “сургуулийн” гэснийг “сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн” гэж, “улсын” гэснийг “улсын болон орон нутгийн” гэж, мөн зүйлийн 43.1.1 дэх заалтын “ашиглалтын буюу суурь” гэснийг “байр ашиглалтын болон тогтмол” гэж, 43.1.3 дахь заалтын “гүйцэтгэл” гэснийг “болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар” гэж, 43.1.4 дэх заалтын “үдийн цай, хоол болон бусад нэмэлт зорилтот хөтөлбөрийг” гэснийг “үдийн хоол болон бусад арга хэмжээг” гэж, 43.1.5 дахь заалтын “багш нарын мэргэжил дээшлүүлэх” гэснийг “багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих” гэж, 43.3 дахь хэсгийн “үндэслэнэ” гэснийг “үндэслэх бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж, 43.4.3 дараах, 43.4.3 дахь заалтын “байгууллагын” гэснийг “сургууль, политехник коллеж” гэж, мөн хэсгийн “суурь” гэснийг “тогтмол” гэж, 43.4.6 дахь заалтын “зардлын тодорхой хэсэг” гэснийг “зардал” гэж, 43.7 дахь хэсгийн “олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн” гэснийг “олон улсын түвшиний” гэж

өөрчилж, 43.1.2 дахь заалтын “шууд зардлын дундаж нормативт үндэслэн тооцох” гэснийг хасаж, мөн заалтын “төлөвлөгөө” гэсний дараа “нэмэлт хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, сургалтын цахим хэрэглээ, сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал,” гэж, 43.4.5 дахь заалтын “хэсэг” гэсний дараа “, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоолны зардал” гэж нэмэх.” Энэ санал дээр, энэ санал дээр тодруулга Энх-Амгалан сайд тодруулга хийе.

Л.Энх-Амгалан: Тийм тайлбар. Энэ юу юу хэн Болороо энэ дээр энэ 43.1 дээр чинь бид нар чинь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг сургууль гэж явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр чинь улсын гээд яагаад ороод ирэв? Одоо уг нь төрийн болон орон нутгийн гэдэг явах нь л зөв биз дээ. Үгүй ээ энэ дээр чинь харин ингээд энэ 43.1 дүгээр хэсгийн сургуулийн гэснийг сургууль мэргэжлийн боловсрол гэхээд, улсын гэснийг улсын болон орон нутгийн гэж гээд ингээд ороод ирэх юм. Төрийнх төрийн гэдгээр явж байгаа биз дээ. Улсын гээд хаанаас ороод ирэв энэ? Улсын гэж хаана ч байхгүй шүү дээ. Харин тийм. Та сая уншихад одоо энэ дээр надад өгсөн энэ юун дээр улсын гэснийг улсын болон орон нутгийн гэж гээд уншихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг төрийн гэж. Төсөв үү? Улсын төсөв, ойлголоо, ойлголоо. Энэ 43.1 дээр над дээр өгсөн энэ юун дээр чинь болохоор нөгөө юу байгаа байхгүй юу. Төрийн болон орон нутгийн. Энэ бол өмчлөл нөгөө энэ 43.1 нь энэ дээр над дээр өгсөн хууль дээр бол өмчийн зохицуулалтууд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр орж ирсний 43.1 гээд уншихаар чинь нөгөө нэг төсөв. Уг нь бол төсвийн зохицуулалт юм байна л даа. Орон нутгийн болон улсын төсөв өгөх ёстой юм байна л даа тэгээд. Энийг сайн Болороо энийг яг бүр ялгаатай яахгүй бол. Дараа нь нөгөө нэг яачих вий. Нэг нь бол өмчлөлийн асуудал, нөгөөдөх нь болохоор санхүүжилтийн хэлбэрийн

асуудал байгаа шүү дээ. Энэ харин тэгж яг яг уншигдаад байна шүү. Окэй.

Г.Мөнхцэцэг: Хууль дээрээ яг орсноороо бол маргаангүй байгаа байх. Ингээд саяын санал дээр санал хураалт. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

66.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, энэ хэсэгт доор дурдсан тайлбар нэмэх.

“43.2.Хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн боловсролын ялгаатай хэрэгцээтэй уялдуулан суралцах тэгш боломжийг хангах зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална. Тайлбарыг уншиж өгье.

Тайлбар.Шууд өртөгт суурилсан зардалд сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн, хичээл сургалтын үйл ажиллагааны зардал, багш, ажилтны цалин хөлс, түүнд ногдох нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал багтана.

Шууд бус өртөгт суурилсан зардалд багшийн мэргэжлийн хөгжил, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, цахим сургалтын программ хангамж, интернэтийн үйлчилгээ, сургалтын удирдлагын мэдээллийн систем, цахим контентын хэрэглээ, программ хангамжийн ашиглалтын зардал, сургалтад шаардагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, дотуур байрын нийт зардал багтана.” Санал хураалт. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

67.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.2 дахь заалтын “сургууль” гэсний дараа “мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж” гэж

нэмж, мөн заалтын “ажлын үр дүнгийн үнэлгээнд суурилсан нэмэлт зардал” гэснийг “гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан санхүүжилт” гэж, 43.4.3 дахь заалтын “байгууллагын” гэснийг “сургууль, политехник коллежийн” гэж, “хувьсах зардлын дунгаж норматив” гэснийг “хувьсах зардал” гэж, “суурь” гэснийг “тогтмол” гэж өөрчилж, 43.4.1, 43.4.4, 43.4.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ноогдох хувьсах зардал;

43.4.4.цэцэрлэгт

хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хоол, сургуулийн суралцагчийн дотуур байрны хоолны зардал;

43.4.7.төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, анхны өртгийг харгалзан нэг хүүхдэд тухайн жилд ногдох элэгдлийн зардлыг тооцсон дундаж норматив зардлаар санхүүжүүлэх тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, ашиглалтын зардал; Санал хураалт. Мөнхцэцэг гишүүн саналтай байна.

Ц.Мөнхцэцэг: Энэ төслийн яг энэ зүйл дээр ажлын хэсэг дээр цөөнх болоод миний оруулсан санал бол унасан байгаа. Тэгэхээр бид нар бол Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай 16.7-гоор буюу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролын үнэ төлбөргүй олгоно гэдэг заалтаа одоо энэ Боловсролын хуулийн энэ үг, үсэг болгон суулгах ёстой. Хэдийгээр манай улсын эдийн засаг тэгээд эдийн засгийн хямралын холбоотойгоор боловсролын салбарын зардал бол харьцангуй бага байгаа ч гэсэн бид нар цэцэрлэг, бүх нийтийн, ерөнхий

боловсролын сургуулиудын тэр дотроо төрийн өмчийн сургуулиуд маань төсвөөс санхүүжиж эцэг, эхээс ямар нэг мөнгө гаргахгүйгээр боловсролыг аваад явах ийм боломж байгаа.

Хөгжлийн банк, нүүрсний хулгай зэрэг асар олон гэмт хэргүүдээс харахад бид нарын хараа хяналтаас гадна, парламентын хяналтаас гадна, ард түмний хяналтаас гадна асар их зардлыг санхүүжүүлж, олон компаниуд өөрсдийн өмнөх зээлүүдээ төлсөн, зориулалтын бусаар ашигласан байгаа. Гэтэл энэ тохиолдолд бид нар энэ парламентын хяналтаа сайжруулж эцэг, эхэд гэдэг юм уу энэ тухайн Монгол Улсын хүн амын дундаж давхарга асар багасаж, хүн амын олонх нь ядуу эгнээнд шилжих гэж байгаа энэ эзэгтэйн үед эцэг, эхэд ачаалал үүрүүлмээргүй байна. Тийм учраас улсын төсвөөс энэ цэцэрлэг төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг бүгдийг нь даах ёстой.

Гэтэл энэ төсөл дээр бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зардлыг л хоолыг нь даана гэдгээр оруулж ирж байна. Энэ бол хүнд хэцүү үед Монголын төр боловсролыг бүх хүүхдэд тэгш чанартай олгох үүргээсээ ухарч байгаа ийм хэлбэр. Тийм учраас энэ заалтыг та бүхэн маань миний оруулахаар буюу энэ улсын төсвөөс энэ бүх цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны зардлыг 100 хувь даана гэдгээр санал хураалтыг дэмжиж өгөөч. Ер нь бол энэ улсын төсвийн хулгайгүй болсон, авлигачдыг хязгаарласан цагт бид нар бол боловсролын салбарыг маш өндөр үр дүнтэй санхүүжүүлээд явах боломж байгаа шүү. Тийм учраас энэ мэтээр эцэг, эхэд дарамт үүрүүлсэн, төр өөрийн үүргээ бусдад нялзааж байгаа энэ асуудлыг дэмжих ёсгүй шүү гэдгийг Байнгын хорооны гишүүддээ хатуу хэлмээр байна.

Г.Мөнхцэцэг: Мөнхцэцэг гишүүний саяын гаргасан санал дээр

Боловсролын сайд Энх-Амгалан тайлбар өгье.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ яах вэ төсвөөс ингээд 100 хувь санхүүжүүлээд явна гэвэл татгалзах юм алга. Гэхдээ одоо ингээд энэ чинь хууль болоод батлаад гарахаар хууль хэрэгжих ёстой. Тэгээд төсвийн ачаалал бол ямар байх вэ, яг энэ хууль бодитойгоор хэрэгжих үү гэдгээ л бид нар зөв тооцоолох ёстой юм байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бол цэцэрлэгийн хүүхдийн хоол чинь 2240 төгрөг байна уу, тийм ээ өдрийн хоолны зардал. Яг энэ хэлбэрээрээ ингээд төр 100 хувь 2240 төгрөгөөр даагаад явна гэхээр нийт хүүхдүүдийн өдөрт авч байгаа илчлэг чинь 30, 40-хөн хувь л байгаа байхгүй юу. Энийг нь дабльдана гээд ингээд яахаар жилд бараг үндсэндээ энэ чинь цэцэрлэгийн хүүхдийн зардал чинь би буруу андуураагүй бол бараг 90-ээд тэрбум төгрөгийн зардлууд гарч байгаа юм. Одоогийн хүчин төгөлдөр байгаа Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын хууль дээр эцэг, эх тодорхой зардлуудыг нь даалцана гэсэн ийм зохицуулалтууд байгаа байхгүй юу Мөнхцэцэг гишүүнээ. Энэ хууль нь хүчин төгөлдөр байгаа юм.

Тэгэхээр энэ хэзээнээс яасан гэхээр 15 оноос л энэ хуулийн заалтыг хүчингүй болгоод, хүчингүй болгох ч яах вэ энэ хуулийг хэрэгжүүлээгүй засаг төр 100 хувь даагаад явчихсан нэг ийм л юутай л байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар одоо яг бодит нөгөө хөнжлийнхөө хэрээр хөдөө жийнэ гэдэг шиг л асуудалд жаахан бодитойгоор хандахгүй бол ингээд нэг баахан лоозонгийн шинж чанартай заалтууд хийгээд, эргээд ингээд нөгөө хүүхдэд ч хохирох, төсөв дээр ч маш том ачаалал ирэх нэг ийм нөхцөл ойлгомжгүй нөхцөл байдлууд бий болчих вий дээ л гэж бодож байгаа. Яах вэ мэдээж яваандаа Монгол Улсын төсөв үргэлж бас ийм дутуу ийм байна, тамир муутай байна гэж би бодохгүй л байна л даа. Яваандаа бол тэрийг тодорхой төр дагаад явах тийм

зохицуулалтууд байж болох болов уу гэж бодож байна. Тэгэхдээ яг өнөөдөр бид нар нэг ийм заалтаар дахиад оруулчих юм бол энийг хэрэгжүүлэхэд бол маш хүндрэлтэй шүү. Энийг бол хэрэгжүүлэх үүрэгжүүлчихнэ гэсэн үг шүү дээ. Төрийг үүрэгжүүлчихнэ гэсэн үг шүү дээ тийм ээ.

Тэгэхээр яг энэ дээр л бид нар бодож л шийдвэрээ л гаргах ёстой л гэж би бодоод байгаа юм. Одоо нийт бол СӨБ-ын түвшинд 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн түвшинд бол энэ асуудал хөндөгдөөгүй шүү дээ энэ чинь угаасаа нөгөө үдийн хоол гэдгээрээ 100 хувь төр зохицуулж байгаа. Одоо Хоол үйлдвэрлэлийн тухай хуулиараа ч гэсэн тийм юм байгаад байгаа юм. Хамгийн гол нь энэ нөгөө СӨБ-ын хувьд бол нэг ийм зохицуулалт одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээрээ ийм байгаа учраас энэ зохицуулалтаар нь явъя л гэсэн ийм саналтай л байгаа.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулж байгаа. Энэ саналын дагуу санал хураалт. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

68.Төслийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.4.9, 43.4.10, 43.4.11, 43.4.12, 43.4.13, 43.4.14 дэх заалт, 43.11 дэх хэсэг нэмж, мөн зүйлийн 43.6, 43.9 дэх хэсгийг төслөөс хасах.

“43.4.9.цэцэрлэгийн хүчин чадал, бүлэг дүүргэлтээс шалтгаалан үндсэн сургалтад хамрагдаагүй хоёр настай хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших хувилбарт сургалтын хэлбэрээс сонгосон тохиолдолд олгох гүйцэтгэлд суурилсан хувьсах зардал;

43.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник

коллежийн багшийн мэргэжлийг дээшлүүлэх зардал;

43.4.11.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, наадгай, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн баяжилт.

43.4.12.үндэсний

хэмжээнд нэвтрүүлэх суралцагч бүрийн сурлагын ахиц, үр дүнг илэрхийлэх цахим систем нэвтрүүлэлт, хөгжүүлэлт, ашиглалт, аюулгүй байдлыг хангах зардал.

43.4.13.энэ хуулийн 17.6-аас, 17.6.1-17.6.3-т заасан үйлчилгээ болон албан бус сургалтын зардлын тодорхой хэсэг.

43.4.14.урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн тусгайлан тодорхойлсон захиалгат хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэл, үр дүнд суурилсан сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний зардлын тодорхой хэсэг;”

43.11.Энэ хуулийн 43.1.2, 43.4.1-т заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй, төрийн бус өмчийн гэж юу гэж байгаа юм бэ? төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд олгохдоо гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал хураалт. Гэхдээ харин энийгээ зөв тодорхойлж байгаа нь зөв үү, томъёолол нь зөв үү? Тийм тэгж харагдаж байна. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

69.Төслийн 44.1, 44.3, 44.4, 44.5, 44.8, 44.9 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 44 дүгээр зүйлийн гарчгийн “Боловсролын байгууллагын орчин” гэснийг

“Боловсролын сургалтын байгууллагын орчин” гэж, 44.7 дахь хэсгийн “нөөцийн газрыг” гэснийг “газрыг” гэж, 44.6 дахь хэсэг, 44.10.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“44.6.Энэ хуулийн 44.5-д заасан эзэмшил газар болон боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглана.

44.10.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг арилжааны хөнгөлөлттэй нөхцөлөөр лизинг болон түрээсийн гэрээгээр 2 ба түүнээс дээш жилийн хугацаатай эзэмших, ашиглах, худалдан авах зардал;” Санал хураалт. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

70.Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.10.2, 44.10.3 дахь заалтыг нэмэх.

“44.10.2.бүх түвшний боловсрол сургалтын байгууллагын цахим сургалтын орчныг бүрдүүлэх тоног төхөөрөмж, хатуу болон зөөлөн дэд бүтцийн сүлжээ ашиглалт, түүнтэй холбогдох засвар үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан түрээсийн болон лизингийн гэрээний үндсэн дээр ашиглах, эзэмших, худалдан авах зардал;

44.10.3.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж багатай, нэмэлт элсэлт авах боломжгүй байршилд аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан сургалтын зориулалтаар барьсан барилга, байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардал.” Санал хураалт. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

71.Төслийн 45 дугаар зүйлийн гарчиг болон 45.1, 45.2 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэснийг “асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж, 45.2.9 дэх заалтын “асран хамгаалагчийн” гэснийг “асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн” гэж, 45.2.10 дахь заалтын “43.5.5” гэснийг “43.4.5” гэж, 45.2.3 дахь заалтын “ариун цэврийн” гэснийг “сургалтын болон эрүүл ахуйн” гэж, 45.2.6 дахь заалтын “сургууль, багшаас” гэснийг “сургуулиас” гэж өөрчилж, 45.1.1, 45.1.4 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 45.2.1 дэх заалтын “хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь илрүүлэн, дэмжин хөгжүүлэх, эерэгээр хүмүүжүүлэх, “ гэснийг, 45.2.7 дахь заалтын “багшийг өөрийг нь болон” гэснийг, 45.2.10 дахь заалтын “43.5.6” гэснийг, 45.2.4 дэх заалтыг төслөөс хасах. Санал хураалт. Алх бүр аймаг, одоо та нарыг ер нь ингээд оюун ухаан ингээд төвлөрчихсөн байгаа байх. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

72.Төслийн 45.1.3, 45.1.5 дахь заалт, 45.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.1.3.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн болон энэ хуулийн 39.2-т заасан сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох;

45.1.5.сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан боловсролын болон сургалтын баримт бичигтэй танилцах;

45.3.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь боловсролын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд гэрээний загварыг энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага батална.” Санал хураалт,

тийм. Тэгж бас хяналттай байхгүй бол болохгүй. Энэ санал 75 хувиар дэмжигдлээ.

73.Төслийн 46 дугаар зүйлийн 46.1.2, 46.1.3, 46.1.5 дахь заалтыг төслөөс хасаж, 46.1.1, 46.1.4 дэх заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын гэж нэмж, 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.2.1.гэрээний дагуу суралцагчийг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, бололцоогоор хангах, дагалдангаар ажиллуулах;

46.2.2.байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;

46.2.3.энэ хуулийн 46.2.2-т заасан сургалт зохион байгуулах зардлыг хариуцах;

46.2.4.хуульд заасан бусад.” Санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

74.Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 47.2.5 дахь заалтыг төслөөс хасах. Санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

75.Төсөлд доор дурдсан агуулгатай 42.2.9, 42.7.10 дахь заалт нэмэх.

“47.2.10.багш ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээг авах талаар зөвлөмж хүргүүлэх;

47.2.10.гадаад улсын болон олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг төрийн бус өмчийн сургалтын байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг шаардлагатай мэдээллээр

хангах;" Санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

76.Төслийн "ДОЛООДУГААР БҮЛЭГ"-ийн нэрийг "БОЛОВСРОЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, САН" гэж, 48 дугаар зүйлийн гарчгийг "Боловсролын цахим мэдээллийн сан, дэд бүтэц" гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ санал хураалтын өмнө Учрал гишүүн үг хэлье.

Н.Учрал: Энэ ЗГ-аас өргөн мэдүүлсэн анхны хуулийн төслөөрөө явбал яасан юм бэ л гэж би бол санал хэлэх гээд байгаа юм. Энэ ажлын хэсэг бол ажиллаад 48.1, 3, 7 дээр ийм санал оруулаад ирсэн юм байна. Гэхдээ яг нөгөө анхны төсөл дээрээ байсан Цахим мэдээллийн нэгдсэн сан гэдэг нэрээрээ, нэр нь бол яг энэ шинэчилсэн нэрээрээ байгаад, аюулгүй байдлаа бол хасаад яг энэ анхныхаа төслөөрөө явбал яасан юм бэ? Тэгэхгүй болохоор боловсролын цахим мэдээллийн хуулбар сантай байна. Боловсролын салбарт боловсролын цахим мэдээллийн сан төрийн мэдэлд байна энэ тэр гээд хуульд байхгүй үгнүүд их байгаа юм энэ дотор. Яагаад гэхээр энэ хуульд ерөөсөө хоорондоо нийцэхгүй. Нөгөө би түрүүн хэлсэн шүү дээ заавал гэдэг 6 үг орчихсон байна энэ хуульд, тийм нэг хүч нэмсэн нэг ийм яруу найраг шиг үг ороод байна шүү дээ. Тэгэхээр ингээд хүч нэмээд нөгөө нэрт зүтгэлтэн энэ тэр гэхээр чинь болохгүй байна шүү дээ. Тэгэхээр нөгөө заавал энэ тэр гэдэг ийм хүч нэмэгдүүлсэн үгнүүдээ жоохон авмаар байна.

2-т Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд заасан тэр төрийн мэдээлэл солилцооны системтэй л мэдээллийг нь солилцох. Нөгөө төр өөрт байгаа мэдээллийг иргэнээсээ нэхэхгүй байх үндсэн зарчмаа хадгалаад л, нийтийн мэдээлэл солилцоонуудынхаа системтэй цахим мэдээллийн сан нь мэдээллийг солилцох гэдэг агуулгыг нь оруулаад л явчихад бол би бол анхныхаа

төслөөрөө бараг зүгээр юм уу даа гэж бодоод байгаа юм.

Тэгээд бас тэр 49 дүгээр зүйлийг хасъя гэдэг би бол саналыг гаргасан. Цахим мэдээллийн аюулгүй байдал энэ ажлын хэсэг бас оруулж ирж байгаа юм байна. Яагаад гэхээр 49 дүгээр зүйл бол бүхэлдээ 49.1, 2 бол хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбоотой харилцаа. Энэ төрлийн харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг. Цахим мэдээллийн аюулгүй байдал гэдэг агуулгатай мөртөө дотор нь хувь хүний мэдээллийг хамгаалах агуулга багтаж байгаа нь зохимжгүй байна. Тийм учраас ажлын хэсгийн энэ саналыг хүлээж аваад 49.1, 2-ыг бүхэлд нь хасаад, энэ 48 дугаар зүйлийгээ Боловсролын цахим мэдээллийн сан гэдэг нэртэйгээр бол найруулгын хувьд нэг жоохон редакт хийгээд засаад явчихаач л гэж хэлэх гээд байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Хууль дээр байгаа энэ Учрал гишүүний гаргаад байгаа тэр үг, найруулга дээр жоохон анхаар гээд байгааг бас бид нар анхаарах хэрэгтэй байна. Ингээд харсан чинь нэлээн олон үг давхацсан ийм бас найруулга, зүйл заалтууд бас ороод ирсэн байна. Тэгээд энэ дээр энэ чинь ингээд уначих юм бол, энэ дээр Боловсролын сайд үг хэлье.

Л.Энх-Амгалан: Учрал сайд, Учрал сайдаа ийм юм байгаа юм. Энэ боловсролын цахим шилжилт гэдэг бол яг нөгөө дижитал трансформэйшин гэдэг нь л бас нэлээн тийм онцлогтой юм байна. Миний ойлгож байснаас бол их тийм их complicated их хэцүү ярвигтай төвөгтэй шилжилт юм байна лээ. Тэгээд энэ дээр бол бас бид нар ЮНЕСКО-той суугаад, ЮНЕСКО-гийн бас нэлээн саналуудыг аваад, яг бид нар өргөн барьсан яг нөгөө хувилбараараа яг баталчих гэхээр зарим юмнуудын зохицуулалтууд нь дутуу үлдчих гээд байна гэсэн ийм зөвлөмж өгсөн юм.

Тэгээд Цахим хөгжлийн яамны яг Бодлогын хэрэгжилтийн газрын даргатайгаа сууж байгаад танай яамны яг Бодлогын газрын даргатай сууж байгаад энэ юунуудыг хийсэн байхгүй юу. Энэ томъёоллуудыг хийсэн байхгүй юу. Тийм учраас миний болгоомжлол бол би яг эндээс энэ цахим мэдээллийн аюулгүй байдлыг зөвхөн хувь хүний мэдээллийн нууцлалтай холбоотой тэр зохицуулалтуудаар хийгээд явчихна гэж таны хэлж байгааг хүлээгээд авчихад, дараа нь ямар нэгэн тийм зохицуулалтгүй үлдчих нэг ийм эрсдэл байх вий дээ л гэж би хараад байгаа юм. Тэгээд энэ дээр манай дэд ажлын хэсгийнхэн яагаад байх уу? Яг энэ цахимтай холбоотой хэсэг дээр манайхан сайн суусан юм шүү дээ. Энэ Цахим хөгжлийн яамныхантай. Тэгэхээр яг бид нар цахим мэдээллийн аюулгүй байдлыг 49 дүгээр зүйл гэж тусгайлан авахын авч явахын давуу тал юу байгаа.

Г.Дамдинням: 49-ийг хасаж байгаа, бүтнээр нь хасаж байгаа.

Л.Энх-Амгалан: Биш ээ биш. Энэ чинь нэр нь бол цахим мэдээллийн нэгдсэн сан аюулгүй байдал гэж бас байгаа байхгүй юу.

Г.Дамдинням: Тэрийгээ сольж байгаа юм. Боловсролын цахим мэдээллийн систем, сан гэдэг нэртэй болж байгаа юм.

Л.Энх-Амгалан: Цахим мэдээллийн, тийм тэрийгээ хасчаж байгаа юм байна тийм байна. Тэгвэл тийм, яриад байгаар орчхож байгаа юм байна. Тэгвэл бид 2-ын ярьж байгаагаар орчхож байна гэсэн үг. Окей.

Г.Мөнхцэцэг: Санал хураалтаа явуулъя. Санал, тийм одоо энд ороод өөрчлөлтүүд орчихсон учраас бол тийм. Энэ саяын унхсанаар ажлын хэсгийн саналаар санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ. Дамдинням

гишүүнийг дэмжсэнээр протокол тэмдэглүүлэе.

77.Төслийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн “Монгол Улс иргэдийн” гэснийг “Иргэдийн” гэж, 48.6, 48.8 дахь хэсгийн “нэгдсэн сангийн” гэснийг “сангийн” гэж, 48.9 дэх хэсгийн “нэгдсэн сан” гэснийг “сан” гэж, 48.6 дахь хэсгийн “төрийн” гэснийг “боловсролын” гэж, 48.9 дэх хэсгийн “ажиллах” гэснийг “ажиллуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 48.4, 48.5, 48.10 дахь хэсгийг төслөөс хасаж, 48.1, 48.3, 48.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.1.Боловсролын салбарт боловсролын цахим мэдээллийн сантай байх бөгөөд тус сан нь төрийн мэдэлд байна.

48.3.Боловсролын цахим мэдээллийн сан нь бүх түвшиний боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн болон төсвийн мэдээллээс бүрдэнэ.

48.7.Боловсролын цахим мэдээллийн нөөц сантай байна.” Санал хураалт. Тэгж орчуулсан байна. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

78.Төслийн 49 дүгээр зүйлийг төслөөс хасах. Санал хураалт. Гишүүдээ анхаарлаа хандуулаарай. 78. Сая санал хураачихсан шүү дээ. Салбарын хуулбар сан гэдгийг. Тийм. Энэ түрүүчийн хураасан 48.7 дээр боловсролын цахим мэдээллийн хуулбар сантай байна гэсэн энэ заалт томъёоллыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуультай нийцүүлэн цаашид гүйцэтгэн боловсруулах чиглэл өглөө. Протоколд тэмдэглүүлээд явъя. Түрүүн 78 дугаар зүйл төслийн 49 дүгээр зүйлийг төслөөс хасах гэдэг саналаар санал хураалт явуулах гэж зогссон. Санал хураалт. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

79.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчилж, мөн зүйлийн 51.2 дахь хэсгийг төслөөс хасах. Санал хураалт. Яасан бэ? Санал хураалтыг цуцаллаа. Ажлын хэсгийн ахлагч. Энэ нөгөө хэзээнээс хэрэгжих вэ, дагаж мөрдөх вэ гэдэг дээр санал гаргаад байна. Ажлын хэсгийн ахлагч.

Г.Дамдинням: Энэ Боловсролын багц хуулийн ажлын хэсэг дээрээ бид нар хоорондоо ярилцсан юм. Тэгээд ер нь юу байгаа хуулийн төсөл дээр бол 24 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс гэж өөрчлөхөөр явж байгаа боловч энэ зүйлийг бид нар энэ санал хураалтаар хасчхаад, ердийн горимоороо хууль батлагдсан өдрөөсөө шууд хэрэгжээд явахаар болчхож байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Тэгээд томъёолж оруулж болохгүй байсан юм уу?

Г.Дамдинням: Тэгэхээр энэ 24 оны улсын төсөв хэлэлцэгдэнэ. Өргөн барихад энэ зарчим энэ хуулийн хөрөнгө оруулалтын асуудлууд тусаж явах ёстой юм. Тийм учраас энэ хууль батлагдсан өдрөөсөө хэрэгжээд явах нь салбартаа өөртөө хэрэгтэй байгаа юм. Бид нар энэ хууль баталсны бодит үр дүн 24 оны төсөв дээр гарч ирнэ гэсэн үг. Тэгэхээр энийг батлаад дэмжээд явах нь зөв байна л гэж хэлж байгаа юм. Тийм.

Г.Мөнхцэцэг: Батлахгүй дэмжихгүй явуулах нь. Сайд Боловсролын сайд нэмэлт тайлбар өгье.

Л.Энх-Амгалан: Энэ дээр ерөнхийдөө энэ хууль ердийн журмаар нөгөө батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болоод явах, явахгүй, болохгүй бол энэ дээр чинь бас хэд хэдэн ийм энэ хуулийг хүлээгээд, хүлээж байгаа мөртөө хийгдээд явчихсан ажлууд зөндөө байгаа байхгүй юу. Одоо жишээ

нь тэр тусмаа 9 сарын 1-нээс өмнө хичээлийн шинэ жил эхлэхэд бас бэлтгэл ажил хангахтай холбоотой нөгөө нэг мэдлээ сургуулиудыг яг албан ёсоор албажуулах энэ тэр гээд ингээд нэг нэлээн зохицуулалтууд байгаа учраас хууль батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр мөрдөгдөж явах ёстой.

2 дугаарт саяын ажлын хэсгийн ахлагчийн хэлсэн 24 оны улсын төсвийг Улсын Их Хуралд өргөн барихад яг энэ боловсролын салбарын санхүүжилтийн шинэ тогтолцооны зарчмаар энэ Төсвийн тухай хуулийн өргөн барихаар хүлээж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болгох, явуулах тэр зохицуулалтууд байгаасай л гэж байгаа юм.

Г.Дамдинням: Болороо энэ төслөөс 51.2-ыг хасна гэдэг чинь тэгээд байхгүй болоод шууд ердийн горим руу орно л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр зөв, зөв, дэмжсэн санал хураагаад л болоод байхгүй юу.

Л.Энх-Амгалан: Тийм. Тэгэхдээ яг 24 оны 1 сарын 1-нээс гэсэн үг биш шүү.

Г.Мөнхцэцэг: Тийм, төслийн заалт өөрчилж гэж байгаа юм.

Л.Энх-Амгалан: Яг шүү яг тэгж ойлголцлоо шүү дээ.

Г.Мөнхцэцэг: Энэ хардаа 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс өдрөөс гэснийг өөрчлөөд гэж байгаа шүү дээ тэгээд 51.2 дахь энэ дээр ингээд томъёолчихсон байгаа байхгүй юу. Өөрчлөөд мөн зүйлийг төслөөс хасна гэгчихсэн байгаа. Тийм хасаж байгаа учраас ердийн горим руу шилжээд явчихна тийм үү? Ингээд санал хураалт. Харин тийм шүү дээ. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

80.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэн тул хуулийн төсөлд тусгагдсан тодорхой зүйл, заалт хүчин

төгөлдөр үйлчилж эхлэх хугацаа, нөхцөл, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах асуудлыг зохицуулах зорилготой дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх. Санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

81.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх. Санал хураалт. Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

82.Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлагчид буцаах. Санал хураалт. 83-ыг уу? Энэ санал 58.3 хувиар дэмжигдлээ.

83.Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын ажлын хэсгийн ахлагч энэ санал дээр үг өгье.

Г.Дамдинням: Түрүүн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Учралын гаргасан зарчмын зөрүүтэй саналын хүрээнд энэ санал хураалтын утга агуулга ишийдэгдчихсэн учраас ажлын хэсгээс татаж авч байна 83 дугаар санал хураалтыг.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагч энэ саналыг татсан учраас дараагийн 84.Хуулийн төслийн холбогдох зохицуулалттай холбогдуулан хариуцлага ногдуулах асуудлаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх. Санал хураалт. Тэгээд дууслаа шүү дээ. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Энд түрүүн бас дэмжигдээд орхигдсон, хураагдсан боловчиг дэмжигдчихсэн боловчиг дэмжигдсэн боловчиг бас тодорхой хэмжээгээр өөрчлөлт оруулахаар түрүүн заагдчихсан байгаа чиглэл өгчихсөн байгаа. Энэ 26 дугаар санал уу тийм ээ? Хураагдсан. Энэ 13.3 дахь заалтын “цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчлөх. Энэ санал хураалт байхгүй шүү дээ. Энэ дээр санал хураалт явуулах юм байна. Санал хураалт. Алив хурдлаарай. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэнэ.

1.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийг хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Боловсролын хуулийн, Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл

дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Бага, дунд боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Бага боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Боловсрол Дээд боловсролын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамтран хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай

хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын хуулийн ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гамшигаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гамшигаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн 1 дүгээр

зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын хуулийн ерөнхий хуулийн төсөлтэй өргөн хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай байдлын тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын хуулийн төсөлтэй хамт өргөн Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл

дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн 2 дугаар зүйл дээр санал асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр санал асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хүний Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг нь хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай, асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Боловсролын хуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн

төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн этгээдийн тухай Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулт байна уу? Алга байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хуулийн этгээдийн дээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Буцааж байгаа хууль, тийм. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай. 1 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх хуулийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг хүчингүй болгосонд тооцсугай. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосонд тооцох тухай хуулийн төслийг санаачлагчид нь буцаая. Тийм байна тийм ээ, ингээд болчихсон уу?

Саяын миний уншсан тэр архины хуулийг буцааж байгаа тухайд санал хураалттай юм байна гишүүдээ. Энэ дээр санал хураалт явуулах юм байна. Санал хураалт. Архидан согтуурахтай хуулийн төслийг буцаасан тухайд санал хураалт явж байна. Санал хураалт. Сая энд миний уншсан хууль өөрөө буцаагдсан, хүчингүй болчихсон учраас санал хураалт явуулж байгаа юм. Энэ хууль 53.8 хувиар дэмжигдлээ энэ заалт. Дамдинням гишүүний юу техник үе үе ажиллахгүй байгаад байгаа учраас саяын хуулийг саяын заалтыг дэмжсэнд тооцож протоколд тэмдэглүүлье. Болчихсон уу?

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Дамдинням танилцуулна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж, анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуралдаанд амжилттай оролцсон ажлын хэсэг, ажлын дэд хэсэг гишүүдэд баярлалаа. Дараагийн асуудалд орно.

17.22 цаг

Хоёр. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал Соёлын Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах ёстой байгаа. Гишүүд. Өнөөдрийн Байнгын хорооны 2 дугаар асуудал Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулах байгаа. Төсөл санаачлагчдын илтгэлийг Соёлын сайд Номин танилцуулна. 4 дүгээр микрофоныг өгчихье.

Ч.Номин: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-ын 1.2-т үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээлч Монгол хүн төвтэй улс болно. Монгол хүний оюуны бүтээлийг дэлхийн зах зээлд сурталчилна, сурталчлах төсөл хэрэгжүүлнэ гэх гэж, 4.2-т бүтээлч үйлдвэрлэх хөгжлийн бодлогыг суурийг тавьж, бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон

хөгжүүлнэ гэж, 9.5-д соёлын аялал жуулчлал бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, соёл урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбарын хоорондын уялдаа холбоог сайжруулна гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 4.2.4-д бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын суурийг тавихаар заасан бол Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.3-д үндэсний агуулгатай, инновац шингэсэн, соёлын, бүтээлч үйлдвэрлэлийг инновацын салбарыг хөгжүүлж, Монголын брэндийг бий болгож, соёл урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ гэж зорьсон. Урлахуйн үйлдвэрлэл болох соёлын бүтээлч үйлдвэрлэл нь тогтвортой хөгжлийг хангах, үзэл баримтлалыг дэмжих, эдийн засгаа олон тулгуурт болгох, бүтээлч авьяас билгийг нөхөн сэргээгдэх нөөц байдлаар хамгаалж, хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэлтэй. ЮНЕСКО-оос хийсэн судалгаагаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хувьд 2.2 их наяд ам.долларын орлоготой, 30 гаруй сая хүнийг ажлын байрыг бий болгодог, экспортын нийт орлого нь 253 тэрбум ам.доллар байна.

Тэгвэл Соёлын яамнаас хийсэн Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгаанаас үзэхэд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д оруулж буй хувь нэмэр нь 481 тэрбум төгрөг буюу улсын дүнд 1.4 хувь эзэлж байгааг тогтоосон. Энэ салбарт 11697 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 5665 нь идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Түүнчлэн дэлхий нийтээрээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн бодлогыг санаачлан хэрэгжүүлж, цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, цаашид улс орны тогтвортой хөгжлийг хангах бүтээлч авьяасыг билгийг нөхөн

сэргээгдэх нөөц байдлаар хөгжүүлэх гол салбараар нэрлээд байна.

Гэвч манай улсын хувьд соёлын салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж үйлчилж байгаа боловч өөрийн орны өвөрмөц онцлогт хадгалан нөөц боломж, техник технологи, хурдтай хурдацтай хөгжиж, дижитал шилжилт зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж, давамгайл соёлын нөлөөлөл болон дэлхийн эдийн засгийн өрсөлдөөнийг даван туулах мэдлэгт суурилсан эдийн засгийг цогцоор нь төрийн бодлогоор дэмжих зохицуулалт хангалтгүй байна. Иймд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн.

Хуулийн төсөл нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хэлбэр, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна. Уг хуулийн төсөл батлагдсанаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх орчин бүрдэж, импортыг орлох, экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг орлуулах үйл явц эрчимжүүлнэ. Мөн төр мөн төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхой болгож, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, түгээх холбоотой үе шат болгонд бүртгэл мэдээллийн тогтолцоог нэвтрэх, соёлын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг дэмжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Төрмөл авьяас билгийг эрх зүй, санхүү, дэд бүтэц, техник технологитой хослуулан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлснээр гадаад зах зээлд өрсөлдөх нөхцөл бий болж, ажлын байр нэмэгдэх, Монгол хүн, Монголын бүтээлийг дэлхийн хэмжээний хүлээн зөвшөөрөгдөх боломжийг бүрдүүлнэ. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 19 хуулийн төслийг боловсрууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Мөнхцэцэг: Соёлын сайд нь Номинд баярлалаа. Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Номин Соёлын сайд, Энх-Амгалан Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энх-Амгалан, Ууганбаяр Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн оруулалтын газрын шинжээч, Батцэцэг Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батхуяг Соёлын Бүтээлч Үйлдвэрлэлийн инновацын хэлтсийн дарга, Даваацэрэн Соёлын өв бодлогын Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Бямбадорж алга байна тийм ээ. Эрдэнэбаяр алга байна.

Төсөл санаачлагчдаас Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Энэ хууль дээр соёлын бүтээлч үйлдвэрлэлийг яг хэрхэн дэмжинэ гэж үзэж байгаа юм бэ? Соёлын бүтээлч үйлдвэрлэл гэдгээ яг юу гэж үзэж байгаа юм бэ? Одоо энэ сошиалаар соёлын салбарынхны цалин муу, авьяастай хүмүүс нь хар ажил хийгээд байна гээд л ингээд яваад байна. Үнэндээ соёлын салбар ишг хамгийн бага цалинтай ийм төрийн албан хаагч нар ер нь бол байхгүй байгаа. Тэгээд авьяасаараа бол дэлхийд нэр нь цуурайтаад байдаг, авдаг цалин нь амьдралд нь хүрдэггүй ийм асуудалтай байж байна.

Өнөөдөр энэ соёлын маш олон салбарт хаанаас ч, хэнээс ч цалинжихгүйгээр өөрөө өөрсдийгөө ингээд аваад шатвал шатаад, олбол олоод ингээд зөвхөн соёл урлагт хайртай гэдэг энэ сэтгэлээрээ явж байгаа олон хүмүүс байгаад байна. Тэгээд энийг яг

яаж дэмжих гэж байгаа юм бэ? Бүтээлч үйлдвэрлэл гэж яг юугаа хэлж байгаа юм бэ? Энэ олон соёлын салбарын ямар, ямар төрөл жанруудад хамрагдаж байгаа юм бэ? Тэгээд энийг дэмжсэнээрээ энэ соёлын салбарынхаа хүмүүсийг бид нар төсвөөр дэмжих гээд байгаа юм уу, бодлогоор дэмжих гээд байгаа юм уу? Энэ хууль гарснаараа ер нь ямар өөрчлөлт, шинэчлэлт энэ соёлын салбарт бий болох гээд байгаа юм гэдэг дээр тодорхой хариулт авъя.

Г.Мөнхцэцэг: Баярсайхан гишүүний асуултад 4 номер дээр Номин гишүүн, Номин сайд хариулъя.

Ч.Номин: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт бол соёлын салбарынхны цалин хөлсний талаар асуулаа гэж бодож байна. Энэ дээр эхлээд тодорхой хариулт өгчхөөд, цаашаагаа хуулийнхаа талаар асуултад хариулъя.

Соёлын салбарынхны хувьд цалин хөлс муу байгаа нь үнэн. Соёлын салбарынхны цалин хөлсний асуудал яригдаж байгаа бол төрд ажиллаж байгаа төрийн өмчит байгууллагуудад байгаа соёлын салбарын ажилчдын цалин хөлсний асуудал яригдаж байгаа. Тэгээд эдгээр асуудал дээр бол Засгийн газар дээр нэгдсэн хэмжээгээр шийдвэр гаргахаар яригдаж байгаа. Тэгээд өнөөдрийн байдлаар бол Засгийн газар дээр дараагийн 1 сарын дотор төрийн албан хаагчдын жигд бус байгаа цалинг жигдлэх талаар шийдвэр гаргах үүрэг өгсөн байгаа. Тэгэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай уялдуулаад цалин хөлсийг бол нэгмөсөн шийдэхээр байгаа. Тэгээд яг салбарын сайдын хувьд бол цалин хөлсийг бусад салбартай дундажлаж очих ёстой буюу хамгийн багадаа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс бол сая төгрөгийн цалинтай болох ёстой гэсэн үзэл бодолтой байгаа. Энэ талаараа бол бид нар шаардлагатай бүх ажлыг хийж байгаа.

Энэхүү хууль бол хуулийн хүрээнд ярихад бол Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль бол соёлын салбарыг бие даасан эдийн засгийн салбар болохоор тулгуурлаж хийгдэж байгаа хууль буюу байгаа. Тэгэхээр энэ талаасаа үзэхэд бол бид нар илүү бизнесийн ч бизнес чиглэлтэй, эдийн засаг чиглэл суурьтай хууль оруулж ирж байгаа гэж хэлж болно. Энэ хуулийг бид нар хийхдээ бол соёлын бүтээлч үйлдвэрлэлийг тодорхойлохдоо хүний оюун санаа, авьяас билгийг техник технологи дээрээс нь оюуны өмчтэй уялдуулаад хэрхэн бүтээлч үйлдвэрлэлийг бий болгох вэ гэдэг суурийг гаргасан. Ингэхдээ эко системээ бүрэн судалж үзээд, соёлын бодлогын эко систем, судалгаа шинжилгээ хөгжүүлэлт, үйлдвэрлэл, контент үйлдвэрлэл, түгээлт гэсэн дэд системүүдээ бүрэн хэмжээнд судалж үзээд энэ хүрээндээ дэмжлэг зохицуулалтуудыг бий болгосон байгаа.

Үндсэн дэмжлэгүүд бол бүтээн туурвигчдын хүрээнд байх буюу бүтээн туурвигчдын хувьд үндэсний агуулгатай бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргавал хэрхэн бүтээн дэмжих талаас байгаа. Хүний нөөцийг сайжруулах. Үүнээс гадна үйлдвэрлэл чиглэл дээрээ бол хөрөнгө оруулалт, санхүү, татварын дэмжлэгүүд талаасаа орж ирж байгаа. Тэгвэл энэ бүтээн туурвисан зүйлээ хэрхэн түгээх вэ гэдэг дээр энэ оюуны өмчийн зохицуулалтыг илүү сайжруулах, хяналтын зохицуулалтыг бий болгох. Үүнээс гадна олон улсад өөрийнхөө бүтээлийг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлэх талаасаа байгаа.

Нөгөө томоохон зохицуулалт юу байгаа гэхээр ирээдүйд хэрвээ энийг ингэж зах зээл болгож хөгжүүлж авч явна гэвэл бид нар хэрэглэгч нарыг бэлтгэх ёстой гэж үзэж байгаа. Тэр утгаараа бид нар ирээдүйд соёл хүртээж сурсан иргэдийг хэрхэн бий болгох вэ, энэхүү үйлдвэрлэлийг бий болгож байгаа

бүтээгдэхүүн үйлчилгээг хийж байгаа хүмүүст хэрэглэгч хэрхэн бий болгох вэ гэдэг талаасаа хэрэглэгч суурь талаа дэмжсэн ийм бүрэн тал бүрийн оролцоог дэмжсэн ийм хуулийн төслийг оруулж ирж байгаа.

Г.Мөнхцэцэг: Баярсайхан гишүүн тодруулъя.

Б.Баярсайхан: Би хувьдаа ер нь бол Монгол Улсын Засгийн газар төрийн албан хаагчдынхаа цалинг нэмэх тал дээр бол бодлого шийдвэр гаргаад явж байгааг бол ойлгож байгаа. Гэхдээ Улсын Их Хурал ч гэсэн үүнийг дэмжиж байгаа. Тэгэхдээ яагаад соёлын салбарынхаа дахиад л төрийн албан хаагчдын дундажтай дүйцүүлэх ёстой гэж. Өөрөө энэ салбар нь энэ нийгмээ чирээд явах, соён гэгээрүүлээд явах хамгийн чухал салбар байхгүй юу даа. Мөн Монгол Улс оршихуй, эс оршихуй гэдэг чинь соёл, соёл нь байна уу, хэл нь байна уу, соёл нь байна уу, Монгол хүнээ бэлдэж байна уу, Монгол үндэстэн байх тэр дархлаа нь байна уу гэдэг нь хамгийн чухал энэ салбар чинь л байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр энд байгаа хүмүүсийнхээ урам зоригийг дэмжих, төсөв мөнгөөр бүр дэмжиж чаддаггүй юм гэхэд бор зүрхээрээ бүтээгээд хийгээд явж байгаа хүмүүсээ бодлогын хэмжээнд дэмжээд, урамшуулчих иймэрхүү ажлуудыг хийж байж дараа нь энэ үйлдвэрлэл үйлчилгээ гэдэг.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Баярсайхан гишүүн дараа нь үг байгаа тийм ээ. Тэгвэл 1 минутаа нэмж өгөөд, асуултаар тооцъё. Баярсайхан гишүүн нэмнэ.

Б.Баярсайхан: Тэгэхээр би та нарыгаа битгий ингээд энэ олон жил ингээд соёлын салбар орхигдчихсон энэ дээр ингээд та нар маань ийм зориггүй битгий бай л даа. Энэ 14, 5 яамны бүр тэргүүнд нь Соёлын яам байх ёстой бөгөөд энэ салбарын ажилчдын цалин илүү өндөр байх ёстой. Энэ салбар

дэмжигдэж байж, энэ соён гэгээрүүлэх энэ хүчирхэг үндэстэн байх, Монгол Улс байх энэ дархлаа л та нар л тогтоох ийм л салбар байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр соёлын салбарынхаа хүмүүсийн цалинг ч нэмнэ мөн бодлогоор энэ салбарт сайн дураараа, сэтгэл зүрхээрээ явж байгаа хүмүүсээ ч дэмжинэ. Тэр бүтээлч үйлдвэрлэлээ ч дэмжинэ гээд л ингээд нэлээн зоригтой явмаар байх юм. Тэгээд энэ дээр нэг тодруулаад хэлээд өгөөч. Өөрсдийгөө дандаа сүүлд тавиад.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Номин сайд Баярсайхан гишүүний асуултад нэмж хариулъя. Тэр соёлын салбар бол тэргүүлэх салбар байх ёстой, тэр онцлох ёстой. Тэр тусмаа энэ хууль бас өөрөө маш том чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ гээд ингээд хэлээд байгаа. Энэ дээр ер нь бас нэг дэлгэрэнгүй бас нэг хариулт өгөөдхөөрэй.

Ч.Номин: Баярсайхан гишүүнтэй бол санал нэг байна. Ур чадвартай авьяас билигтэй хүмүүс бол энэ улсад өөрийгөө үнэлүүлж, өөрийнхөө ур чадварт тэнцсэн цалин хөлсийг авах ёстой гэдэгтэй бол санал нэг байна. Тийм ч учраас Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль бол үүнийг хөшүүрэгдэж гарч ирж байгаа хууль. Үүнээс гадна 2019 онд гарч ирсэн журам байгаа. Энэ журмын хүрээнд бол манай салбарынхан маань хэрвээ суурь цалин нь гайгүй болоод дээрээс нь бүтээлч үйлдвэрлэлийг, оюун оюуны өмчийг эргэлтэд оруулаад ирэх юм бол олсон орлогоо буцаагаад бас өөрсдөө захиран зарцуулах эрх нь байгаа. Тэгэхээр бид нарын хувьд бол энэ бид 2020 оноос хойш яам байгуулагдсанаасаа хойш хууль, эрх зүйн орчнуудыг маш сайжруулж байгаа учраас.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Сая Баярсайхан гишүүн Байнгын хорооны

дарга бас хэллээ л дээ. Соёлын салбар гэдэг бол нийгмийн манлайлал нь байх ёстой, хөдөлгөгч хүч нь байх ёстой гээд. Үнэхээр соёл урлагийн салбар маань яг ямар хэмжээнд байгаа вэ гэдэг бол өнөөдөр үүсэж байгаа нөхцөл байдалд бас харагдаж байгаа байх гэж үзэж байна. Өөрөөр хэлэх юм бол би гадаа талбайд жагссан жагсаал цуглаан гэдэг юм уу эндээс харж байна. Театруудынхаа барилга байлга байгууламжийг бас харж байна. Ямар хэмжээнд байгаа билээ, бид нар өнөөдөр хүчитгэх хэмжээнд л үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Тодорхой хэмжээнд Монгол Улсын Засгийн газраас бас хөрөнгө оруулалтыг бас хангалттай хэмжээнд тавьсан боловчиг бодит үр дүнд хүрсэн зүйл маань Чингисийн музейгээс хэтрэхээргүй хэмжээнд байгаа гэдэг бол бас үнэхээр энэ ажлын энэ салбарын хөрөнгө оруулалт бодлогыг бас зайлиггүй төр засгаас дэмжих энэ бодлого бол харагдаж байгаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг бол нэлээн удаан хүлээлээ. Тэгэхээр боловсруулалт бол хангалттай байгаа байх гэж би бодож байна. Өөрөөр хэлэх юм бол салбарынхныхаа санал бодлыг, санал, дүгнэлтийг бас хангалттай тусгасан болов уу гэж бодож байна.

Үнэхээр Монгол Улсын эдийн засгийг солонгоруулах бас нэгэн гарц бол соёлын бүтээлч үйлдвэрлэл. Өнөөдөр Монгол Улс соёлын өв болон язгуур урлаг гэдэг юм уу, бүхий л төрлөөрөө үүнийг биет бүтээл болгоод, дэлхийн зах зээл дээр гаргах тэр боломж нь бүрэн байгаа боловчиг тодорхой хэмжээнд хууль, эрх зүйн орчин үгүйлэгдэж байсан. Энэ боломжийг бас бид хангаж өгөх гэж байна гэж харж байгаа. Яг ер нь бол яг өнөөдөр бид бүтээлч үйлдвэрлэлээрээ гэдэг юм уу, бид хуульгүй ч гэсэн бас энэ ажил явагдаж байсан тийм ээ. Яг эдийн засагт оруулсан гол төлөөлөл, тооцоолол, үр дүн ер нь хэр байсан бэ гэдэг дээр бас мэдээллийг өгөөч гэж

хүсэж байна. Яг одоогоор зөвхөн Соёлын бүтээл үйлдвэрлэл гэж байгаа энэ юунд соёлын биет өвүүд уламжлагдсан тийм ээ, үндэсний биет өвүүд ер нь хэчнээнээр тоологддог юм бол? Миний асууж байгаа асуулт бол бид уламжлалт соёл урлагаа дүр бүтээл болгох тал дээр ер нь хэр анхаарч ажиллаж байгаа вэ гэдэг асуулт. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Өнөөдөр та түрүүн хэллээ. Давсан орлогоо өөрөө захиран зарцуулах эрхтэй гэж. Гэтэл нөгөө бусад дагасан хуулиуд байдаг юм уу, Аудитын хуулиараа бид нар захиран зарцуулах эрх нь бас үүсэхгүй, эргээд олсон орлого нь Сангийн яам руу улсын төсөв рүү явчихдаг ийм нөхцөл байдал байсаар байгаа. Энэ дээр ямар зохицуулалт хийгдэж байна вэ гэдэг дээр нэг тайлбар авчхаад, тодруулъя. Өөрөөр хэлэх юм бол давсан орлогоо уран бүтээлчдээ урамшуулал болгон өгөх тэр боломж нь бий юу?

Г.Мөнхцэцэг: Жаргалмаа гишүүний асуултад 4 номер дээр Номин сайд хариулах уу.

Ч.Номин: Ер нь бол мэдлэгийн зах зээлийг хөгжүүлэх гээд бид нар маш олон жил ярьж байгаа боловч яг одоо энэ бүтээлч үйлдвэрлэл буюу энэ *creative industrial* дээр хамгийн чухал зүйл юу байдаг вэ гэхээр эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн тоолж, хэрхэн хянах вэ гэдэг систем өнөөдрийг хүртэл байхгүй байгаа. Манай Зохиогчийн эрхийн тухай хууль бол Оюуны өмчийн тухай хууль бол маш сайн хууль болсон. Оюуны өмчийн тухай хууль бол хэний өмч вэ гэдгийг тодорхойлж өгдөг. Зохиогчийн эрхийн тухай хууль хэрэглээнд оруулж байгаа хууль байгаа боловч яг энийг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа механизм буюу тооллогын механизм нь байхгүй байгаа учраас энийг бол энэ манай Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль маань оруулж ирж байгаа.

Соёлын өвийн тухай асуулаа. Соёлын өв бол бид нарт мэдээж биет, биет бус гээд олон төрлөөрөө байгаа. 400 гаруй мянган биет өвүүд байна, тийм. Нөгөө талдаа биет бус өвүүд маань бол байгаа. Эдгээрийг бол бид нар манай нөөц гэж үзэж байгаа. Соёлын өвийг бол бид нар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нөөц буюу бид нар соёлын өвдөө суурилсан онцлогтой олон улсад бусдаас ялгарах бүтээгдэхүүн, үйлчилгээ гарах боломжтой гэж харж үзэж энэ дээр явж эхэлж байгаа. Тэгэхээр Соёлын өвөө бид нар суурь нөөц болгоод, энүүнийгээ хэрхэн үүсмэл бүтээгдэхүүн болгох вэ гэдэг дээр илүү анхаарч байгаа буюу Монгол агуулгатай бүтээгдэхүүнүүдийг хийхэд илүү дэмжлэг үзүүлж байгаа гэж үзэж болно.

Өнөөдрийг хүртэл бол яг албан тооцоогоор бол өнөөдрийн байдлаар ДНБ-ий 0.4 хувийг соёлын бүтээлч үйлдвэрлэл эзэлж байгаа. Соёлын яамнаас хийсэн судалгаагаар бол одоогийн байдлаар 1.4 хувь гэж гарч ирчхээд байгаа. Бид нарын харж байгаагаар бол энэхүү хууль бүрэн хэмжээнд хэрэгжээд явж чадвал 2027 он гэхэд 4 хувь болох боломжтой салбар гэж үзэж байгаа.

Г.Мөнхцэцэг: Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Яг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуульд ер нь хариуцлагын тогтолцоог хэр оруулж өгсөн бол? Та сая хэллээ л дээ. Нөгөө оюуны өмчийн хулгай гээд. Гэтэл бид нар зөвхөн оюуны өмчөөр баталгаажсан бүтээлээс гадна уран бүтээлчид маань өөрсдөө аливаа бүтээлээ бас оюуны өмчийн баталгаажилт авалгүйгээр олон нийтэд танилцуулах, мэдээлэх, нөгөө сошиал сүлжээнд тавих ингээд олон нийтэд хүргэх ийм нөхцөл байдал байдаг л даа. Гэтэл түүгээрээ бид нар мөнгө олох биш зүгээр л жишээ нь миний авсан зургийг хэн нэгэн ашиглаад байх энэ тохиолдолд энэ оюуны бүтээлийг үнэлэх

тэр үнэлэмжийг тогтоож өгөх боломж энэ хуульд байгаа юу?

Г.Мөнхцэцэг: Нэмэлт асуултад Номин сайд тодруулж хариулъя.

Ч.Номин: Түрүүн би хэлсэнчлэн манай хувьд бол Оюуны өмчийн тухай хууль бол манай бүтээл туурвиж байгаа хүмүүсийн маань бүтээгдэхүүн үйлчилгээг зүгээр тухайн хүний оюуны өмч юм гэдгийг бүртгэж байгаа. Зохиогчийн эрхийн тухай хууль бол хэрэглээнд орох механизмуудыг бий болгож байгаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэл бол бид нар яг тоолох, хянах механизмыг буюу яг эдийн засгийн эргэлтэд орох механизмыг оруулж ирж байгаагаараа онцлогтой байгаа. Тэгэхээр энэ дээр хяналтын систем болон тооллогын систем орж ирж байгаа. Энийг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшил, хамтын удирдлагын байгууллагын гуравласан хүрээнд хэрэгжүүлж авч явна гэж үзэж байгаа.

Г.Мөнхцэцэг: Хэлж байгаа, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүн байна уу? Баярсайхан гишүүн санал хэлье.

Б.Баярсайхан: Тэгээд энэ маш чухал хууль учраас гишүүд маань хэлэлцэх эсэхийг нь ингээд өнөөдөр Байнгын хороогоороо дэмжээд, тэгээд цааш нь хэлэлцэх явцад нь бүгдээрээ саналаа хэлээд үргэлжлүүлээд явбал ямар вэ? Тэгээд Номин сайдад бас нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Энэ Өвөр Монгол ахан дүүс маань энэ Монголын соёл урлагийнхны кино, энэ тоглолт дуучид, жүжигчдийн энэ тоглолтуудыг үзэх бол аягүй дуртай байдаг юм байна. Гэхдээ манай энэ уран бүтээлчдийн энэ ямар ч оюуны өмчийн баталгаа байхгүй, Өвөр Монголд зүгээр Vi чатаар мөнгө төлөөд ингээд ямар ч шинэ уран бүтээл байсан ингээд өчнөөн сая хүн рүү гараад яваад байдаг юм байна. Энийг соёлын яам сайд

бас Хятадын Элчин сайдын яамтай уулзаж, ярилцаж энэ уран бүтээлчдийнхээ энэ бүтээлийг бас оюуны өмчийн баталгаатай мөн боломжтой бол өөрсдөө энэ уран бүтээлчид нь үр шимийг нь, Монгол Улс үр шимийг нь хүртэхээр ингээж гадагш нь гаргах тал дээр бодлогын арга хэмжээ авч уулзаж, ярилцаж энэ асуудлыг бас цэгцэлж өгөөсэй гэж хүсэж байна. Тэгээд энэ хуулийг дэмжихийг, хэлэлцэхийг бол дэмжиж байна. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Баярсайхан гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хувьд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах ёстой. Ингээд санал хураалт. Санал хураалт 54.5 хувиар дэмжигдлээ. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хуулийг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Жаргалмаа гишүүн танилцуулчих уу? Жаргалмаа гишүүн танилцуулъя.

17.48 цаг

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн энэ удаагийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. 2 асуудал хэлэлцлээ. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА